



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР

Боржигин
Сайнхүү МИНЖБААТАР

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ АРГА ЗАМ: СЭРГЭЭШИЙН ТӨРЛИЙН
БОДИСЫН ЖИШЭЭН ДЭЭР



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүй
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдсан
Э.Доржпүрэв /LL.M/

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Боржигин
Сайнхүү МИНЖБААТАР

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ АРГА ЗАМ: СЭРГЭЭШИЙН ТӨРЛИЙН
БОДИСЫН ЖИШЭЭН ДЭЭР



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүй
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдагч : Э.Доржпүрэв\LL.M\

ГАРЧГИЙН ТОВЬЁОГ

МЭДЭГДЭХ ХУУДАС	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	vi
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	vii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	viii
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	ix
УДИРТГАЛ.....	1
Сэдэв сонгосон үндэслэл	1
Судлагдсан байдал	1
Судалгааны ажлын зорилго, зорилт	2
Судалгааны шинэлэг тал	2
Судалгааны бүтэц	2
БҮЛЭГ 1. СЭДВИЙН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ	3
1.1 Сэргээшийн төрлийн бодис: ойлголт, ангилал, хор уршиг, онцлог	3
1.1.1 Сэргээшийн төрлийн бодисын ойлголт, ангилал.....	3
1.1.2 Сэргээшийн төрлийн бодисын эрүүл мэндэд үзүүлэх хор уршиг.....	5
1.1.3 Сэргээшийн төрлийн бодис болон мансууруулах бодис: ялгах шалгуур, давхцалын асуудал.....	7
1.2 Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, онцлог	9
1.3 Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тайлбарлах: Боломжийн онол (Routine Activity Theory)	12
БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА	15
2.1 Монгол Улс дахь сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт	15
2.2 Эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудал.....	20
2.2.1 Олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилт ба хүлээсэн үүрэг	20
2.2.2 Дотоодын эрх зүйн тогтолцоо ба сэргээшийн төрлийн бодисын зохицуулалтын хязгаарлагдмал байдал	22
2.2.3 Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт ба мөнгө угаах гэмт хэргийн уялдаа: FATF-ийн стандартын хэрэгжилт.....	26

2.3	Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, түүний санхүүгийн урсгалыг FATF-ийн аргачлалаар үнэлэх нь.....	29
	БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	31
	БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	34
4.1	Дүн шинжилгээ.....	34
4.1.1	Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.....	34
4.1.2	Ярилцлагын судалгааны үр дүн	37
4.2	Гадаад улсын хууль тогтоомж дахь зохицуулалт: харьцуулсан шинжилгээ	50
4.2.1	Америкийн нэгдсэн улс (АНУ).....	50
4.2.2	Герман улс	51
4.2.3	Итали улс.....	53
4.2.4	Франц улс	55
4.2.5	Австрали улс	56
4.2.6	Оросын Холбооны улс.....	57
4.2.7	Испани, Норвеги, Дани болон бусад Европын орнуудын эрүүгийн хариуцлага.....	57
4.2.8	Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) болон Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ).....	59
	ДҮГНЭЛТ.....	64
	САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	66
	НОМ ЗҮЙ.....	i
	ХАВСРАЛТ	viii

МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Магистрантын нэр: С.Минжбаатар

Гарын үсэг:

Огноо: 2026.06.04

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг бичихэд мэргэжлийн зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж ажилласан удирдагч багш Э.Доржпүрэв танд талархаж буйгаа илэрхийлье. Түүнчлэн судалгааны ажил бичих явцад чиглүүлэг, зөвлөгөө өгч тусалж дэмжсэн нийт багш нар, хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Сэргээшийн төрлийн бодисыг тусгай зөвшөөрөлгүйгээр импортлох, худалдаалах явдал далд хэлбэрээр хавтгайрч нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд бодитой эрсдэл учруулах боллоо. Энэхүү хууль бус эргэлтийг дагасан санхүүгийн далд урсгал нь “бага эрсдэл-өндөр ашиг” гэсэн зарчмаар зохион байгуулалттай гэмт хэргийн шинжийг агуулж, олсон бохир орлогоо санхүүгийн системээр дамжуулан угаах нөхцөлийг бүрдүүлж байна. Монгол Улсын Эрүүгийн хуулиар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг нарийвчлан зохицуулсан ч НҮБ-ын конвенцод хамаардаггүй, харин Дэлхийн Допингийн эсрэг агентлаг (WADA)-ийн Хориглосон жагсаалтад заагдсан сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар эргэлтэд оруулж буй этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тусгайлсан заалт байхгүй байна. Энэхүү эрх зүйн сул орон зай нь мөнгө угаах гэмт хэргийн “Суурь гэмт хэрэг”(Predicate offence)-ийг хянах, таслан зогсоох хяналтын тогтолцоог сулруулж байгаа юм.

Энэхүү судалгаагаар сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулах эрх зүйн зохицуулалтыг дотоодын болон олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улсын туршлага, шүүхийн практикт тулгуурлан харьцуулсан байдлаар судалж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх боломжтой санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорив.

Судалгааны баримт бичгийн болон харьцуулсан эрх зүйн дүн шинжилгээний аргаар хуулийн зохицуулалтыг судалж, Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (FATF) -аас гаргасан Эрсдэлийн суурьт хандлагын аргачлалаар мөнгө угаах эрсдэлийг үнэлэв. Мөн далд эргэлтийн бодит нөхцөл байдлыг шүүхийн практик болон чанарын судалгааны (ярилцлагын) аргаар баталгаажуулж, хууль зүйн дүгнэлт, саналуудыг дедуктив аргаар нэгтгэлээ.

Судалгааны үр дүнд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт тодорхой бус, хууль эрх зүйн орчин хангалтгүйн улмаас зах зээлд хяналтгүй худалдаалагдаж, улмаар тухайн хууль бус худалдаанаас олсон орлого санхүүгийн системээр дамжин угаагдах өндөр эрсдэлтэй нөхцөл бүрдэж байгааг тогтоосон. Дараах боломжит санал зөвлөмжийг дэвшүүлсэн. Үүнд:

✓ Эрүүгийн хуулийн тусгай ангид “Сэргээшийн төрлийн бодис, түүний түүхий эдийг хууль бусаар импортлох, худалдах, зуучлан түгээх” гэсэн бие даасан шинэ зүйл заалт нэмж, Эрүүгийн хуулийн 20.14 дэх ерөнхий зүйлчлэлээс салгаж, нийгмийн хор аюулд нь тохирсон ял шийтгэл оногдуулдаг болох;

✓ Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтыг зөвхөн “тамирчин”, “эмч” гэх хязгаарлалтаас салгаж сэргээшийн төрлийн бодис зөвшөөрөлгүй худалдсан иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг нэмэгдүүлж, Эрүүгийн хуулийн хариуцлагаас зааглах;

✓ Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг (Predicate offence) болох бүрэн шинжтэй тул FATF-ийн Зөвлөмж 3-т нийцүүлэн, Санхүүгийн мэдээллийн албаны сэжигтэй гүйлгээг таних, тайлагнах удирдамж, журам болон эрсдэлийн үнэлгээнд сэргээшийн төрлийн бодисын хууль бус далд эргэлтийг мөнгө угаах өндөр эрсдэлтэй салбарт албан ёсоор хамааруулж тооцох;

✓FATF-ийн аргачлалыг хэрэгжүүлэх үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон Санхүүгийн мэдээллийн албаны хамтарсан "Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, санхүүгийн урсгалыг хянах ажлын хэсэг"-ийг байгуулж эмийн сан, фитнес клуб, онлайн худалдааны цахим гүйлгээнд салбар дундын хяналт шалгалт хийж, мэдээлэл солилцоог шуурхай болгосноор Боломжийн онолын "Харгалзагч" (Savable guardian)-ийн үүргийг практикт хэрэгжүүлэх;

✓Залуучуудад сэргээшийн төрлийн бодисын хор уршгийг таниулах сургалт зохион байгуулж, жоргүй олгох боломжгүй сэргээшийн төрлийн эмийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй болгох.

Түлхүүр үг: *сэргээшийн төрлийн бодис, хууль бус эргэлт, мөнгө угаах, допинг, гэмт хэрэг*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хориглосон жагсаалтын ангилал	4
Хүснэгт 2. Мансууруулах болон сэргээшийн төрлийн бодисыг ялгах шалгуур	7
Хүснэгт 3. Боломжийн онол санхүүгийн гэмт хэрэгт	13
Хүснэгт 4. 2019-2023 оны хооронд бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэргийн тоо	17
Хүснэгт 5. Эрүүгийн хуулийн 20.14 заалтаар 2022-2026 оны 2 дугаар улирлын байдлаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	34
Хүснэгт 6. Эрүүгийн хуулийн 18.6 заалтаар 2022-2026 оны эхний улирлын байдлаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	36
Хүснэгт 7. Эрүүгийн хуулийн 18.5 заалтаар 2022-2026 оны эхний улирлын байдлаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	37
Хүснэгт 8. Ярилцлагын тэмдэглэл 1,2	37
Хүснэгт 9. Ярилцлагын тэмдэглэл 3,4	39
Хүснэгт 10. Ярилцлагын тэмдэглэл 5,6	41
Хүснэгт 11. Ярилцлагын тэмдэглэл 7,8	43
Хүснэгт 12. Ярилцлагын тэмдэглэл 7,8	44
Хүснэгт 13. Ярилцлагад оролцогчдын хариултын нэгдсэн үзүүлэлт	48
Хүснэгт 14. Ану-ын зохицуулалт ба ял шийтгэл	50
Хүснэгт 15. Герман улсын зохицуулалт ба ял шийтгэл	51
Хүснэгт 16. Итали улсын зохицуулалт ба ял шийтгэл	54
Хүснэгт 17. Франц улсын зохицуулалт ба ял шийтгэл	56
Хүснэгт 18. Австри улсын зохицуулалт ба ял шийтгэл	56
Хүснэгт 19. Оросын холбооны улсын зохицуулалт ба ял шийтгэл	57
Хүснэгт 20. Европын орнуудын зохицуулалт ба ял шийтгэл	57
Хүснэгт 21. Хууль тогтоомж эрүүгийн хариуцлагын харьцуулсан байдал	58
Хүснэгт 22. Зарим улсын сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалтын харьцуулалт	62

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 2025 оны эхний хагас жилд хураан авсан сэргээшийн төрлийн бодисууд	16
Зураг 2. Мансууруулах бодис болон мөнгө угаах гэмт хэргийн статистик	18
Зураг 3. Гэмт хэргийн үзүүлэлтүүдийн өсөлтийн харьцуулалт	18

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Судалгааны ярилцлагын удирдамж

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
НҮБ (UN)	Нэгдсэн Үндэстний Байгууллага (United Nations)
WADA	Дэлхийн допингийн эсрэг агентлаг (World Anti-Doping Agency)
ЮНЕСКО (UNESCO)	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (United Nations Educational, Scientific and Cultural Organization)
FATF	Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force)
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэршил

Тайлбар

Сэргээшийн төрлийн бодис (Допингийн бодис)

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын 1961 оны "Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц" болон 1971 оны "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц"-ийн жагсаалтад багтаагүй, Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (WADA)-аас жил бүр шинэчлэн баталдаг "Хориглосон жагсаалт"-д багтсан хүний төв мэдрэлийн тогтолцоо, даавар, бодисын солилцоо, булчингийн бүтцийг хүчтэй өөрчлөх замаар хамаарал (донтолт) үүсгэх, бие махбодод эргэж сэргэхгүй эмгэг өөрчлөлт, үхэлд хүргэх өндөр эрсдэлтэй, хууль бус эргэлтээс нь гэмт хэргийн шинжтэй орлого (бохир мөнгө) үүсдэг аливаа бодис, арга замыг хэлнэ.

Суурь гэмт хэрэг (Predicate offence):

Мөнгө угаах гэмт хэргийн урьдач нөхцөл болсон хууль бус орлого, хөрөнгийг бий болгосон аливаа гэмт хэргийг хамааруулан ойлгоно.

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт (Illicit trafficking of doping substances):

Сэргээшийн төрлийн бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн журмыг зөрчиж Монгол Улсын хилээр нэвтрүүлэх (импортлох), бэлтгэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ил болон далд цахим хэлбэрээр худалдах, зуучлан түгээх үйл ажиллагааг хэлнэ.

УДИРТГАЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хэрэглээ өдрөөс өдөрт нэмэгдэж, сэргээшийн төрлийн бодисууд эмийн сан болон иргэдийн гар дээрээс чөлөөтэй худалдаалагдаж, дурын сонирхсон этгээд худалдан авч хэрэглэх боломжтой байдалтай байна. Сэргээшийн төрлийн бодис (анаболик стероид, пептид, даавар гэх мэт)-ын хууль бус эргэлт нь орчин үед спортын хүрээнээс давж, олон улсын хэмжээнд зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй болж байна. Улс орнууд энэ асуудлыг зөвхөн спортын сахилгын зөрчил гэж үзэхээс татгалзаж, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлсэн эрүүгийн гэмт хэрэг хэмээн ангилж, хууль эрх зүйн зохицуулалтыг чангатгаж байна (World Anti-Doping Agency [WADA], 2023). Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага INTERPOL (n.d.)-ын мэдээлснээр сэргээшийн төрлийн бодис нь ихэнхдээ хууль бусаар үйлдвэрлэгдэж, наймаалагдан, тараагддаг бөгөөд энэ нь гагцхүү спортын асуудал бус боловч нийгмийн эрүүл мэндэд шууд аюул учруулах гэмт хэргийн тогтолцооны нэг хэсэг болсон байна. Сэргээшийн төрлийн бодисын зах зээл нь 'бага эрсдэл — өндөр ашиг'-тай тул зохион байгуулалттай гэмт бүлэглэлд улам таатай болсоор байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг зохицуулсан зохицуулалт байдаг. Харин Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ)-ын 1961 оны "Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц" болон 1971 оны "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц"-д хамаарахгүй боловч Дэлхийн Допингийн эсрэг агентлаг (WADA)-аас батлан гаргадаг Хориглосон жагсаалтад заагдсан сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой нарийвчилсан зохицуулалт байдаггүй.

Сэргээшийн төрлийн бодис чөлөөтэй худалдаалагдаж мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж санхүүгийн тогтолцоо, үндэсний аюулгүй байдал, нийгмийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж байна. Энэ нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болсон сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг тусгайлан зохицуулах хэрэгцээ шаардлага Монгол Улсад тулгамдаж байгааг илтгэж байна.

Энэхүү дипломын ажлаар сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон түүнээс үүсэх гэмт хэргийн орлогыг мөнгө угаах замаар далдлах асуудлыг онолын болон практик талаас нь судалж, Монгол Улсын шүүхийн практик, эрх зүйн зохицуулалтын дутагдлыг илрүүлэн дүн шинжилгээ хийж улмаар дотоодын эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандарт, ялангуяа Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага(FATF)-ийн зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах зорилготой.

Судлагдсан байдал

Мөнгө угаах гэмт хэргийн талаар Ж.Авхиа, Г.Совд, С.Жанцан, Х.Нямбаатар, Ж.Болдбаатар, З.Төрмандах, Д.Адьяабазар, С.Гантулга, Б.Энхболд зэрэг судлаачид эрүүгийн эрхзүйн чиглэлээр бичсэн ном, сурах бичгүүддээ тайлбарлаж оруулсан байна. Мөн мөнгө угаах гэмт хэрэг сэдвээр бичигдсэн магистрын судалгааны ажил (Г.Арсланхуяг, Б.Оюунболд, Н.Бадраа, С.Баярсайхан, А.Хүдэр-Эрдэнэ г.м) болон илтгэл,

өгүүлэл (Д.Зүмбэрэлхам, К.Жархынбек, Б.Төмөрбат, Д.Тунгалаг, Н.Жавхлан, Г.Отгонжаргал, Б.Батцэрэн, М.Амина, Г.Мягмарцэрэн) нэлээдгүй байна. Судлагдсан байдлыг судлахад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг мөнгө угаах гэмт хэргийн суурь болох талаас судалсан судалгааны бүтээл байхгүй байсан.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны ажлын зорилго нь сэргээшийн төрлийн бодисыг хориглосон үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, Монгол улсад тулгамдсан асуудлыг тодорхойлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал дэвшүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Сэргээшийн төрлийн бодис болон мөнгө угаах гэмт хэргийн онолын үндэс, ойлголт, бүрэлдэхүүн, эрх зүйн зохицуулалтын онцлогийг тодорхойлох;
- Сэргээшийн төрлийн бодисыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисоос ялгаж тодорхойлох олон улсын стандарт, хандлагыг тодорхойлж, харьцуулсан шинжилгээ хийх;
- Гадаад улс орнуудын сэргээшийн төрлийн бодисын зохицуулалтуудын туршлагыг судалж, Монгол Улсын эрх зүйн орчинд нутагшуулах боломжит хувилбаруудыг тодорхойлох;
- Шүүхийн шийдвэр, статистик тоо баримтад тулгуурлан практик хэрэгжилтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
- Асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал, зөвлөмж, дүгнэлт боловсруулах

Судалгааны шинэлэг тал

WADA-с батлан гаргадаг Хориглосон жагсаалтад заагдсан сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох талаас судалсан анхны судалгааны бүтээл юм.

Судалгааны бүтэц

Энэхүү судалгааны ажил нь Удиртгал, Үндсэн 4 хэсэг, Дүгнэлт, Санал, Ашигласан эх сурвалж бүхий үндсэн 4, дэд 8 хэсгээс бүрдэнэ.

БҮЛЭГ 1. СЭДВИЙН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Энэхүү бүлэгт сэргээшийн төрлийн бодисын үндсэн ойлголт, тэдгээрийн хүний биед үзүүлэх сөрөг нөлөө, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисоос ялгах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж WADA болон НҮБ-ын конвенцуудын хоорондын уялдаа, давхцалыг нарийвчлан шинжилнэ. Сэргээшийн төрлийн бодис нь зөвхөн спортын шударга өрсөлдөөний зарчмыг зөрчөөд зогсохгүй, нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулдаг болохыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлохыг зорилгоо. Мөн сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь зохион байгуулалттай гэмт хэргийн нэг хэлбэр болох мөнгө угаах гэмт хэрэгтэй хэрхэн холбогддог, түүний суурь гэмт хэрэг болох онолын үндэслэлүүдийг тайлбарлах болно.

1.1 Сэргээшийн төрлийн бодис: ойлголт, ангилал, хор уршиг, онцлог

1.1.1 Сэргээшийн төрлийн бодисын ойлголт, ангилал

Олон улсын хэмжээнд болон дотоодын эрх зүйн практикт “Сэргээшийн төрлийн бодис”(Doping substances)-ыг дараах хоёр суурь хэмжүүрээр нэгтгэн тодорхойлно:

1. Спортын эрх зүйн хандлагаар: Дэлхийн Допингийн эсрэг агентлаг (WADA)-аас жил бүр шинэчлэн баталдаг "Хориглосон жагсаалт"-д тусгагдсан, тамирчны бие махбод, спортын амжилтыг зохиомол аргаар дэвшүүлэх чадвартай, тамирчны эрүүл мэндэд хор уршиг учруулах болон спортын шударга байдал, ёс зүйд харшлах бодис, аргуудыг хэлнэ.

2. Эрүүгийн эрх зүй ба Нийтийн эрүүл мэндийн хандлагаар: Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын 1961 оны "Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц" болон 1971 оны "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц"-ийн жагсаалтад багтаагүй боловч хүний төв мэдрэлийн тогтолцоо, даавар, бодисын солилцоо, булчингийн бүтцийг хүчтэй өөрчлөх замаар хамаарал (донтолт) үүсгэх, бие махбодод эргэж сэргэхгүй эмгэг өөрчлөлт, үхэлд хүргэх өндөр эрсдэлтэй, хууль бус эргэлтээс нь гэмт хэргийн шинжтэй орлого (бохир мөнгө) үүсдэг химийн болон нийлэгжүүлсэн нэгдлүүдийг ойлгоно.

Хууль зүйн үүднээс сэргээшийн төрлийн бодисыг ердийн "эм, эмийн бүтээгдэхүүн"-ээс ялгах гол онцлог нь түүнийг импортлох, үйлдвэрлэх, түгээх харилцаа нь тусгайлан заасан стандарт, эмнэлгийн заалтаас гадуур, цэвэр ашиг олох зорилгоор далд зах зээлд (фитнес клуб, онлайн платформ, гар дээрээс) хууль бусаар эргэлдэж байгаад оршино.

Хууль зүйн тодорхойлолт: Сэргээшийн төрлийн бодис гэдэг нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (WADA)-аас жил бүр шинэчлэн баталдаг "Хориглосон жагсаалт"-д багтсан, хүний бие махбод, тамирчны физиологийн чадамжийг зохиомлоор нэмэгдүүлэх үйлчилгээтэй анаболик стероид, гормон, пептид болон тэдгээрийн урьдал бодис (precursors), түүхий эдийг хэлнэ. Хууль зүйн шинж чанарын хувьд НҮБ-ын 1961, 1971 оны конвенцын дагуу "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт"-д албан ёсоор орсон бодисуудтай химийн бүтцийн хувьд зарим талаар давхцаж болох ч, тэдгээрээс хэрэглэх сэдэл, зорилго (мансуурах биш, биеийн чадавхыг хиймлээр өсгөх) болон нийгмийн хор аюулын шинжээрээ ялгаатай. Энэ нь НҮБ-ын конвенцын мансууруулах бодисын жагсаалтад хамаарагдаагүй боловч иргэний эргэлтэд чөлөөтэй нэвтрүүлэхийг хуулиар хязгаарласан, зөвхөн эмнэлгийн зориулалтаар, тусгай жороор олгогдох ёстой, Монгол Улсын

Эрүүгийн хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй "иргэний эргэлтэд хатуу хяналттай нэвтрүүлэх тусгай объект" юм.

WADA-гийн тодорхойлолтоор сэргээшийн төрлийн бодис буюу хориглосон бодис гэдэг нь тамирчны гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, эрүүл мэндэд хор учруулах, спортын дүрмийг зөрчих зэрэг гурван шалгуурын аль хоёрыг хангасан аливаа бодис, арга замыг хэлнэ (WADA, 2024).

WADA-ийн хориглосон жагсаалтыг жил бүр шинэчилж нийтэлдэг бөгөөд энэ нь улс орнуудын антидопингийн байгууллагууд болон спортын холбоодын заавал дагаж мөрдөх олон улсын стандарт болдог. Жагсаалтыг жил бүрийн 10-р сарын 1-нд нийтэлж, дараа оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болгодог (BSCG, n.d.).

Хориглосон бодис эсвэл аргыг жагсаалтад оруулахын тулд дараах гурван шалгуурын аль хоёрыг хангасан байх шаардлагатай:

- Тухайн бодис/арга нь спортын гүйцэтгэлийг дээшлүүлэх боломжтой болох;
- Тухайн бодис/арга нь тамирчны эрүүл мэндэд аюул учруулах;
- WADA-ийн тодорхойлсон спортын сүнс, ёс зүйг зөрчих (Heuberger & Cohen, 2019).

WADA-ийн хориглосон жагсаалт нь бодис, арга, хэрэглэх цаг хугацаагаараа тодорхой ангилалд хуваагддаг (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хориглосон жагсаалтын ангилал

Ангилал	Жишээ бодисууд	Хэрэглэх цаг хугацаа
S0 – Зөвшөөрөгдөөгүй бодис	Туршилтын эм, дизайнер стероид, малын эм	Үргэлж хориглоно
S1 – Анаболик бодис	Анаболик стероид (тестостерон, станозолол), SARM	Үргэлж хориглоно
S2 – Пептидийн даавар, өсөлтийн хүчин зүйл	Эритропозэтин, өсөлтийн даавар (hGH), инсулин	Үргэлж хориглоно
S3 – Бета-2 агонист	Сальбутамол, формотерол	Үргэлж хориглоно
S4 – Даавар болон метаболизмын зохицуулагч	Арентаза дарангуйлагч, кломифен	Үргэлж хориглоно
S5 – Шээс хөөх, маскирлах бодис	Диуретик, плазмын өргөтгөгч	Үргэлж хориглоно

Ангилал	Жишээ бодисууд	Хэрэглэх цаг хугацаа
S6 – Цочрогч бодис (Stimulant)	Амфетамин, кокаин, метилфенидат	Тэмцээн дээр хориглоно
S7 – Мансууруулах бодис (Narcotic)	Морфин, оксикодон, фентанил	Тэмцээн дээр хориглоно
S8 – Каннабиноид	Марихуана, ТНС	Тэмцээн дээр хориглоно
S9 – Глюкокортикоид	Преднизолон, дексаметазон	Тэмцээн дээр хориглоно
M1–M3 – Хориглосон арга	Цусны допинг, генийн манипуляц, химийн манипуляц	Үргэлж хориглоно
P1–P2 – Тодорхой спортод хориглоно	Бета блокер (буудлага, жийрэгний харваа)	Тодорхой спортод

Эх сурвалж: (WADA, 2025).

1.1.2 Сэргээшийн төрлийн бодисын эрүүл мэндэд үзүүлэх хор уршиг

Сэргээшийн төрлийн бодисууд нь хүний бие махбодод эргэж сэргэх боломжгүй ноцтой гэмтэл учруулах эрсдэлтэй бөгөөд зүрх судас, дааврын тогтолцоо, сэтгэцийн эрүүл мэнд болон дотоод эрхтнүүдэд сөргөөр нөлөөлдөг (WADA, 2023; Mayo Clinic, 2023).

Сэргээшийн төрлийн бодис нь биед дараах сөрөг нөлөөллийг үүсгэдэг. Үүнд:

А) Анаболик стероидын сөрөг нөлөө

Анаболик андрогены стероид бол тамирчид болон биеийн тамирын сонирхогчдын хамгийн их урвуулан ашигладаг бодис юм. АНУ-д нийт хүн амын 1-3% нь Анаболик андрогены стероид хэрэглэдэг гэж тооцоолсон байдаг (Albano et al., 2021).

Стероидын биед үзүүлэх сөрөг нөлөөнд дараах зүйлс багтана:

- Элэгний хавдар болон элэгний үйл ажиллагааны доройтол,
- Зүрхний хананы өтгөрөлт (кардиомиопати), зүрхний шигдээс,
- Өндгөвчний атрофи, эмэгтэйн цээж хөгжих (гинекомасти), өндгөн эсний тоо буурах, Эмэгтэйчүүдэд: дуу хоолой буурах, биед үс гарах, сарын тэмдгийн алдагдал,
- Сэтгэлзүйн хувьд: түрэмгийлэл ('roid rage'), сэтгэл гутрал, амиа хорлох сэтгэлгээ,
- Өсвөр үеийнхэнд ясны өсөлт гацах, насанд хүрсний дараа ч үргэлжлэх хүндрэлүүд (U.S. Anti-Doping Agency, n.d.; WNET, n.d.).

Анаболик стероидын хэрэглээ нь эрэгтэйчүүдэд тестостероны хэвийн ялгаралтыг бууруулж, төмсөг агших, үргүйдэлд хүргэх эрсдэлтэй. Зарим тохиолдолд эдгээр өөрчлөлт

нь эргэж хэвийн болохгүй байж болно. Мөн хөхний эдийн өсөлт (гинекомасти) илэрч болзошгүй (Mayo Clinic, 2023).

Б) Эритропоэтин болон цусны допингийн нөлөө

Эритропоэтин нь улаан цусны эсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлдэг даавар бөгөөд голчлон дугуйчид болон гүйлтийн тамирчид ашигладаг. Анаболик стероидын нэгэн адил тархины кортикал бүсийн эзлэхүүн буурсан байдаг нь тодорхойлогдсон (Euronews, 2025).

Эритропоэтин болон цусны допингийн хор нөлөөнд дараах зүйлс орно:

Цусны зузааралт — цус бүлэгнэлт, тархины инсульт, зүрхний гэнэтийн зогсолт

Цусан хавдрын эрсдэл нэмэгдэх

Цусны дамжуулалтаар халдвар (ХДХВ, гепатит В/С) авах

Зүрхний хэм алдагдах (аритми), цус харвалт (Sport Integrity Australia, n.d.; U.S. Anti-Doping Agency, n.d.).

В) Цочрогч бодис (Stimulant)-ын нөлөө

Амфетамин, кокаин зэрэг цочрогч бодис нь зүрх, мэдрэлийн систем, сэтгэл зүйд хүнд хор учруулна:

- Цусны даралт огцом ихсэх, зүрхний хурд нэмэгдэх, аритми
- Гипертермия (биеийн температур ихсэх), дулааны цохилт
- Нойргүйдэл, сэтгэлийн тогтворгүй байдал, донтолт
- Хэт тунгаар хэрэглэхэд зүрхний гэнэтийн зогсолт, үхэл (Sport Integrity Australia, n.d.).

Г) Цогц сөрөг нөлөө

2022 оны РМС-д нийтлэгдсэн судалгаагаар сэргээшийн төрлийн бодис нь зүрх судасны өвчин, чихрийн шижин, хорт хавдар, сэтгэцийн эмгэг зэрэг олон ноцтой өвчин үүсгэдэг нь батлагдсан. Стероидын тунг анаболик зорилгоор хэрэглэхэд оксидант стресс, эсийн апоптоз, уургийн нийлэгжилтийн алдагдал зэрэг молекулын эвдрэл бүх эрхтнийг хамарна (Bird et al., 2016; Preston & Epstein, 2022).

Д) Өсвөр үед сэргээшийн төрлийн бодис хэрэглэсний урт хугацааны нөлөө

Өсвөр үед сэргээшийн төрлийн бодис хэрэглэсэн тамирчдын дунд явуулсан харьцуулсан судалгааны үр дүнгээр эдгээр хүмүүст насанд хүрсний дараа элэгний үйл ажиллагааны доройтол, сэтгэл гутрал, хавдарт өртөх, ажил мэргэжлийн хүндрэл илүү их тохиолдсон. Сэргээшийн төрлийн бодис хэрэглэгчид Беккийн сэтгэл гутралын оноор өндөр, нийгмийн дэмжлэг багатай, сэтгэлийн сөрөг үйлчлэлд илүү өртөмтгий байв. (Zareie et al., 2024).

Сэргээшийн төрлийн бодис нь хэрэглэсний дараах өндөр мэдрэмжийн дараа сульдалт, нойргүйдэл, сэтгэл гутрал, цочимтгой байдал, түүнчлэн давтан хэрэглээний үед донтолт, тэвчил, таталт зэрэг хамаарал үүсгэх өндөр эрсдэлтэй. (WHO 1994; NIDA 2024) Сэргээшийн төрлийн бодисууд нь сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, түрэмгий зан авир (“roid rage”), сэтгэл гутрал, түгшүүр, сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал

үүсгэдэг (Mayo Clinic, 2023). Хүнд тохиолдолд сэтгэцийн эмгэг (психоз) илэрч болзошгүй бөгөөд донтох эрсдэл өндөр байдаг.

Сэргээшийн төрлийн бодисууд нь спортын шударга өрсөлдөөнийг алдагдуулахаас гадна хүний эрүүл мэнд, амь насанд "бодитой аюул" учруулж буй мансууруулах бодистой адилтгах хэмжээний хор хөнөөлтэй бодис болох нь шинжлэх ухааны олон талт судалгаануудаар батлагдаж байна. Иймд уг асуудлыг зөвхөн спортын ёс зүйн зөрчил гэж үзэх бус, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэж үзэх онолын болон практик үндэслэл бүрдэж байна.

1.1.3 Сэргээшийн төрлийн бодис болон мансууруулах бодис: ялгах шалгуур, давхцалын асуудал

Эрүүгийн эрх зүйн практикт зүйлчлэлийн алдаа гаргахгүй байх, хяналтын механизмыг оновчтой болгоход энэ хоёр төрлийн бодисын зааг ялгааг нарийн тогтоох нь нэн чухал юм. Олон улсын стандарт нь "сэргээшийн төрлийн бодис"-ийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисоос тодорхой ялгаж үздэг. WADA-гийн хориглосон жагсаалтад тусгагдсан бодисууд нь спортын гүйцэтгэлийг сайжруулах зорилготой бодисыг голлон хамардаг бол НҮБ-ын конвенцуудын зохицуулалт нь нийгмийн эрүүл мэндийн хамгаалалд чиглэгддэг гэсэн суурь ялгаа байдаг (Houlihan, 1999). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэгчид гол төлөв сэтгэцийн таашаал авах, бодит байдлаас тасрах, донтолын хэрэгцээгээ хангах зорилготой байдаг бол сэргээшийн төрлийн бодисыг (жишээ нь анаболик стероид, өсөлтийн даавар) хэрэглэгчид биеийн хүч чадал, булчингийн масс, тэсвэр хатуужлаа зохиомлоор богино хугацаанд нэмэгдүүлэх өөр сэдэлтэй байдаг.

Сэргээшийн бодисыг мансууруулах бодисоос ялгах үндсэн шалгуурыг дараах байдлаар тодорхойлж болно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Мансууруулах болон сэргээшийн төрлийн бодисыг ялгах шалгуур

Шалгуур	Мансууруулах бодис	Сэргээшийн бодис
Үндсэн зорилго	Эмчилгээ/Донтолт/Таашаал авах	Спортын гүйцэтгэлийг зохиомлоор сайжруулах
Хяналтын эрх зүйн суурь	НҮБ-ын конвенцууд /1961, 1971, 1988/	Спортын зохицуулалт (ДДЭА)
Нийгмийн аюул	Нийгмийн эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдал	Спортын шударга байдал, тамирчны эрүүл мэнд
Дотоодын зохицуулалт	Эрүүгийн хуулиар хориглож, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ	Сахилгын (спортын) хариуцлага хүлээлгэнэ
Давхцал	Зарим бодис (кокаин, морфин гэх мэт) давхацдаг	Зарим бодис (стимуляторууд,наркотикууд гэх мэт)давхацдаг

Эх сурвалж: Судлаачийн боловсруулсан.

Олон улсын эрх зүйд мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хяналтыг НҮБ-ын хоёр үндсэн конвенц зохицуулдаг. 1961 оны "Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц" (Single Convention on Narcotic Drugs, 1961) нь опиат, каннабис, кокаин зэрэг байгалийн болон нийлэгжүүлсэн мансууруулах эмийг I-IV жагсаалтаар ангилан хяналтад авч, тэдгээрийг гагцхүү эрдэм шинжилгээ, эмчилгээний зорилгоор хэрэглэхийг зөвшөөрдөг (United Nations Office on Drugs and Crime [UNODC], 2013).

1971 оны "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц" (Convention on Psychotropic Substances, 1971) нь амфетамин, барбитурат, бензодиазепин болон бусад синтетик бодисыг хамарч, хяналтын тогтолцоог I-IV жагсаалтаар хэрэгжүүлдэг. Конвенцын 1(е) дүгээр зүйлийн тодорхойлолтоор "Сэтгэцэд нөлөөлөх бодис" нь төв мэдрэлийн тогтолцоог сэргээх буюу дарангуйлах, хий үзэгдэл харуулах, хөдөлгөөний үйл ажиллагаа болон зан авирыг саатуулан хямраах чадвартай бодис юм (Convention on Psychotropic Substances, 1971, Art. 1(e)).

Судалгааны нэг гол асуудал бол 1961 болон 1971 оны конвенцод заагдсан бодисуудын зарим нь ДДЭА-ийн 2026 оны Хориглосон жагсаалттай давхцадаг явдал юм. Энэ давхцалыг дараах жишээгээр тайлбарлаж болно:

- Кокаин (Cocaine): 1961 оны конвенцын I жагсаалт + ДДЭА S6 Стимуляторууд
- Амфетамин (Amphetamine): 1971 оны конвенцын II жагсаалт + ДДЭА S6 Стимуляторууд
- MDMA (Экстази): 1971 оны конвенцын I жагсаалт + ДДЭА S6 Стимуляторууд
- Морфин (Morphine): 1961 оны конвенцын I жагсаалт + ДДЭА S7 Наркотикууд
- Героин/Диаморфин: 1961 оны конвенцын IV жагсаалт + ДДЭА S7 Наркотикууд (Донтуулдаг бодис)
- Каннабис: 1961 оны конвенцын I, IV жагсаалт + ДДЭА S8 Каннабиноидууд.

Бүрэн давхцах хэсэг (НҮБ + WADA): Кокаин, амфетамин, морфин, каннабис зэрэг бодисууд нь төв мэдрэлийн системийг хүчтэй цочроодог, өвчин намдаадаг шинж чанартай тул НҮБ-ын конвенцоор "мансууруулах бодис" гэж эрүүгийн ял оноодог атлаа WADA-ийн жагсаалтаар тэмцээний үед хориглосон "сэргээш" болж давхцадаг.

Гэвч давхцалгүй, зөвхөн нэг зохицуулалтын хүрээнд хамрагдах бодисууд нь илүү олон байдаг. Жишээлбэл, анаболик стероид (S1), өсөлтийн даавар (S2), бета-2 агонистууд (S3), эритропоэтин (S2) зэрэг нь ДДЭА-ийн жагсаалтад байгаа боловч НҮБ-ын конвенцод байдаггүй (WADA, 2026). Энэ нь "сэргээшийн бодис" гэдэг ойлголт нь мансууруулах бодисоос тодорхой хэмжээгээр тусдаа гэдгийг харуулдаг.

Жишээлбэл,

“Жинтропин” (Соматропин) гэх бодис нь 2026 оны Допингийн хориглосон жагсаалтын "S2. Пептид дааврууд, өсөлтийн хүчин зүйлүүд, тэдэнтэй хамааралтай бодисууд ба миметикүүд" гэсэн хэсэгт Өсөлтийн даавар (Growth Hormone) болон түүнийг ялгаруулагч хүчин зүйлүүд нь бүх цаг үед (тэмцээний болон тэмцээний бус үед) хориглосон бодист багтдаг. Жинтропин (Өсөлтийн даавар) нь мансууруулах бодисын төрөлд хамаардаггүй НҮБ-ын конвенцуудын жагсаалтад байхгүй байна.

“Ретаболил” (Нандролин) гэх бодис нь жагсаалтын "S1. Анаболик бодисууд" хэсэгт багтсан бөгөөд спортын тэмцээний болон тэмцээний бус үед **бүрэн хориглосон** бодис юм. Ретаболил нь мансууруулах бодис биш тул энэ конвенцын жагсаалтад **байхгүй** байна.

Давхцалгүй хэсэг (Зөвхөн WADA-ийн хяналтад байх бодис): Судалгааны гол цөм болох анаболик стероидууд (S1), пептидийн даавар, өсөлтийн хүчин зүйлс (S2) нь НҮБ-ын конвенцын мансууруулах бодисын жагсаалтад огт байдаггүй. Судалгаагаар илэрсэн Жинтропин (Өсөлтийн даавар), Ретаболил (Нандролон) зэрэг бодисууд нь дотоодын зах зээлд эмийн нэршлээр чөлөөтэй олгогдож байгаа нь эрүүгийн эрх зүйн хяналтаас гадуур "Бохир мөнгө" үүсэх үндсэн нөхцөл болж байна.

Мөн давхцалыг доорх байдлаар ангилж болно:

Бүрэн давхцал (НҮБ + WADA): Кокаин, Амфетамин, Морфин, Каннабис зэрэг бодисууд нь нэг талаас "мансууруулах бодис" гэж тооцогдон Эрүүгийн хуулиар хяналтад байдаг бол, нөгөө талаас "сэргээшийн төрлийн бодис" гэж үзэгдэн спортын тэмцээнээс хасах үндэслэл болдог.

Зөвхөн WADA-ийн хяналтад байх бодисууд: Анаболик стероид, Өсөлтийн даавар, Эритропоэтин зэрэг нь НҮБ-ын конвенцуудаар "мансууруулах бодис"-ын ангилалд багтдаггүй.

Олон улсын болон дотоодын эрх зүйн практикт "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис" болон "Сэргээшийн төрлийн бодис"-ын хууль зүйн тодорхойлолтыг нарийвчлан зааглах нь гэмт хэргийн зүйлчлэл болон хяналтын тогтолцоог оновчтой болгоход шийдвэрлэх ач холбогдолтой.

1.2 Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, онцлог

Мөнгө угаах гэмт хэрэг (Money Laundering) гэдэг нь гэмт хэргийн замаар олж авсан хөрөнгө, орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, түүний гарал үүслийг өөрчлөн хувиргах, шилжүүлэх, эзэмших, ашиглах замаар хуулийн дагуу олсон орлого мэт харагдуулах зорилготой санхүүгийн болон бусад зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ (FATF, 2003).

Мөнгө угаах нь хууль бус ажиллагаанаас олсон орлогын мөн чанар, эх үүсвэр, зарцуулалт, шилжилт хөдөлгөөн, өмчлөлийн талаарх мэдээллийг нуун далдлах, төөрөгдүүлэх үйл ажиллагаа юм (С.Нарангэрэл, 2021, тал 245).

Мөнгө угаах гэж илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсвэл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэл, байршлыг нь өөрчилснийг хэлнэ.(Монгол банк, 2018, тал 12)

Бохир мөнгө гэдэг нь жинхэнэ хууль бус буюу захиалгат аллага, зэвсгийн хориотой наймаа, хүний болон хүний эд эрхтний наймаа, далайлган сүрдүүлэлт, хээл хахууль, мансууруулах бодисын наймаа гэх мэт ноцтой гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан, хуримтлуулсан орлого юм (Д.Зүмбэрэлхам, 2002).

Энэхүү гэмт хэргийн мөн чанар нь бохир мөнгийг санхүүгийн системд шингээж, хууль ёсны эдийн засгийн эргэлтэд оруулах замаар анхны гэмт хэргийн ул мөрийг арилгах, хууль сахиулах байгууллагын хяналтаас зайлсхийхэд оршино. (Levi.M & Reuter.P, 2006)

Олон улсын түвшинд мөнгө угаах гэмт хэргийг 1988 оны НҮБ-ын Конвенц, 2000 оны Палермогийн Конвенц болон FATF-ийн 40 зөвлөмжөөр тодорхойлж, гишүүн улсуудад бие даасан эрүүгийн гэмт хэрэг болгон хуульчлах үүрэг ногдуулсан. Эдгээр баримт бичигт мөнгө угаах гэмт хэрэг нь дараах үндсэн шинжийг агуулна гэж үздэг:

- гэмт хэргийн орлогыг мэдсээр байж эзэмших, ашиглах;
- орлогын хууль бус эх үүсвэрийг нуун дарамтлах, өөрчлөх;
- шилжүүлэх, хувиргах, хөрөнгө болгон хөрвүүлэх;
- гарал үүслийг нь нуух зорилготой аливаа хэлбэрийн оролцоо.

Мөнгө угаах гэмт хэргийн онцлог шинж:

- Суурь гэмт хэрэгтэй (predicate offence) салшгүй холбоотой.
- Санхүүгийн шинжтэй, баримт бичиг, гүйлгээ, нягтлан бодох бүртгэлийн ул мөрөөр илэрдэг.
- Ихэвчлэн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй уялддаг.
- Хил дамнасан шинжтэй, олон улсын хамтын ажиллагаа шаарддаг (Levi.M & Reuter.P, 2006).

Мөнгө угаах үйл явцыг тайлбарлах зорилготой Мөнгө Угаах Үйл Явцын Үе Шатны Онол (*The Three Stages of Money Laundering*) нь FATF болон эрдэмтэн Майкл Лэйни (Laney, 1998), Питер Ройтер нарын судалгаанд тулгуурлан гурван үе шатны загвар тогтоогдсон. Энэхүү загвар нь өнөөдөр олон улсын гэмт хэргийн мөрдлөгийн стандарт тодорхойлолт болж тогтсон байна. Уг онолын дагуу мөнгө угаах үйл явцыг дараах 3 үе шатад хуваан үздэг. Үүнд:

I үе шат — Байршуулалтын үе шат нь хууль бус гарал үүсэлтэй бэлэн мөнгийг санхүүгийн системд анх удаа оруулах үйл явц юм. Энэ нь мөнгө угаах бүхий л үе шатуудаас хамгийн эмзэг ба илрэх эрсдэл хамгийн өндөртэй үе юм. Байршуулалтын үе шатанд хэрэглэдэг гол аргачлалууд:

- Бичил гүйлгээ хийх: Банкны мэдэгдлийн босгоос доогуур олон жижиг мөнгөн гүйлгээ хийх,
- Орлого холих: Рестораны орлого, зочид буудлын тооцоо гэх мэт хуулийн ёсны бизнесийн орлоготой хольж оруулах,
- Гадаадын банк ашиглах: Хяналт суларсан улс оронд данс нээн мөнгийг шилжүүлэх,
- Валют солилцох: Хяналт багатай валют солилцооны газар ашиглах,
- Сугалааны ялалтаар нуух: Казино ашиглаж бэлэн мөнгийг чип болгож, ялалт гэж харуулан буцаан авах.

II үе шат — Далдлалтын үе шат нь мөнгөний хууль бус гарал үүсвэрийг нуух, мөрийг үгүй болгох зорилгоор олон давхаргат санхүүгийн гүйлгээ хийх үйл явц юм.

Мөрдөн байцаагч нарт мөнгөний замыг олоход хамгийн хүнд, цаг хугацаа шаардах үе шат энэ юм. Далдлалтын үе шатанд хэрэглэгддэг гол аргачлалууд:

- Оффшор компани байгуулах: Сэйшел, Британийн Виржин арлууд, Панам зэрэг татварын таатай нөхцөл бүхий бүсэд нэр хаягаа нуусан компани байгуулах,
- Олон улсын мөнгөн гуйвуулга: Олон улсын банкны системээр мөнгийг дамжуулж, гүйлгээний мөрийг арилгах,
- Хуурамч компани ашиглах: Жинхэнэ эзэн нь харагдахгүй хуулийн этгээд байгуулах,
- Хөрөнгө оруулалтын сан: Хэдж сан (Hedge fund), хувийн хөрөнгө оруулалтын сан (private equity) ашиглан мөнгийг оруулж гаргах,
- Крипто валют: Биткойн болон бусад крипто дамжуулан мөнгөний гарал үүсвэрийг нуух,
- Хуулийн үйлчилгээ ашиглах: Хуульч, нотариатч ашиглан хууль ёсны гүйлгээ хэлбэрт оруулах.

III үе шат — Нэгтгэлийн үе шатанд мөнгийг хуульчилсан мэт харагдах хэлбэрт оруулан хэвийн эдийн засгийн эргэлтэд буцааж оруулдаг. Энэ үед мөнгийг нийгмийн аливаа тооцооноос ялгаж мэдэхэд ихээхэн бэрхшээлтэй болдог. Нэгтгэлийн үе шатанд хэрэглэгддэг гол аргачлалууд:

- Үл хөдлөх хөрөнгийн бизнес: Оффис, орон сууц, газар зэргийг худалдан авч дахин зарах,
- Рестораны болон жижиглэн худалдааны бизнес: Хэтэрхий их орлоготой мэт харуулах,
- Хувьцаа, үнэт цаас: Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх,
- Хуурамч зээлийн схем: Өөрийн компанидаа зээл олгож, буцааж төлөх,
- Соёлын болон хамгаалалтын зүйлс: Зураг, урлагийн бүтээл, гоёл чимэглэлийн эд зүйлс худалдан авах. (FATF, 2024; Levi & Reuter, 2006; Reuter & Truman, 2004; Unger, 2007)

Мөнгө угаах гэмт хэрэг нь шууд ил тод илэрдэггүй, харин санхүүгийн гүйлгээ, эдийн засгийн харилцааны дотоод логикт зөрчил үүсгэх замаар аажмаар илэрдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, энэ гэмт хэрэг нь ихэвчлэн “харагдахгүй” байдлаар үйлдэгддэг бөгөөд илрүүлэхэд санхүүгийн урсгал, гүйлгээний хэв маяг, баримт бичгийн үнэн зөв байдал, өмчлөх бүтэц зэрэг олон хүчин зүйлийг цогцоор нь шинжлэх шаардлагатай болдог.

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус худалдаа нь дэлхийн хэмжээнд жилд хэдэн тэрбум ам.доллараар хэмжигдэх ашиг олдог зохион байгуулалттай гэмт хэргийн нэг салбар болон өргөжжээ. Энэхүү хууль бус үйл ажиллагаанаас олсон их хэмжээний бэлэн мөнгийг санхүүгийн системд оруулах, түүний эх үүсвэрийг нуун далдлах үйл явц нь мөнгө угаах гэмт хэргийн сонгодог механизмын дагуу явагддаг. FATF-аас тодорхойлсон гурван үе шатыг сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбон авч үзвэл:

1. Байршуулах үе шат (Placement): Сэргээшийн төрлийн бодисыг гар дээрээс болон фитнес клубийн орчинд бэлэн мөнгөөр худалдаалснаар их хэмжээний "бохир"

бэлэн мөнгө төвлөрдөг. Гэмт этгээдүүд энэхүү мөнгийг банкны хяналтын системээс бултуулахын тулд "структуринг" (structuring) буюу мөнгийг олон жижиг хэсэгт хувааж, өөрийн болон хамаарал бүхий этгээдүүдийн дансаар дамжуулан санхүүгийн системд оруулдаг. Мөн "мобайл банк" болон "цахим түрийвч" ашиглан хувь хүн хоорондын гүйлгээ хэлбэрээр байршуулж байна.

2. Давхарлах үе шат (Layering): Энэ үе шатанд мөнгөний анхны эх үүсвэрийг таних боломжгүй болгохын тулд олон дахин шилжүүлэг хийдэг. Сэргээшийн бүлэглэлүүд гадаадын онлайн платформоос бараа захиалах нэрээр валютын гүйлгээ хийх, криптовалюта худалдан авах, эсвэл олон улсын цахим төлбөрийн системүүдийг ашиглан мөнгөний мөрийг төөрүүлдэг. Энэ үед хууль сахиулах байгууллагууд мөнгөний анхны "бохир" гарал үүслийг тогтооход хүндрэлтэй болдог.

3. Нэгтгэх үе шат (Integration): Эцсийн шатанд угаагдсан мөнгө нь хууль ёсны бизнесийн ашиг орлого болон харагддаг. Жишээлбэл, гэмт этгээдүүд фитнес клуб, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний дэлгүүр эсвэл спортын хэрэглэлийн худалдаа нээж, түүнийгээ өндөр ашигтай ажиллаж байгаа мэтээр тайлан гарган, "бохир" мөнгөө хууль ёсны эргэлтэд оруулдаг. Энэ үед тухайн хөрөнгө нь татвараа төлсөн, цэвэр ашиг мэтээр харагдаж, үл хөдлөх хөрөнгө, автомашин худалдан авах зэрэг дараагийн хөрөнгө оруулалт болон хувирдаг байна.

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь мөнгө угаах гэмт хэргийн нийтлэг суурь гэмт хэрэгт тооцогддог бөгөөд 1988 оны НҮБ-ын Конвенцын дагуу гишүүн орнууд ийм төрлийн гэмт хэргийн орлогыг эрүүгийн хариуцлагад хамруулах үүрэг хүлээдэг.

1.3 Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тайлбарлах: Боломжийн онол (Routine Activity Theory)

Мөнгө угаах болон сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт зэрэг гэмт хэргүүд нь зөвхөн хувь хүний ёс суртахуун, сэтгэл зүйн онцлогоос бус, нийгмийн тогтолцоо болон хүний өдөр тутмын "боломж"-оос шууд хамааралтай байдаг. Иймд энэхүү судалгааны ажлын онолын суурь болгож Л.Коэн болон М.Фелсон нарын (1979) боловсруулсан Боломжийн онол (Routine Activity Theory)-ыг сонгон авлаа. Уг онол нь нийгмийн хөгжил болон технологийн дэвшлийг дагаад гэмт хэргийн шинэ хэлбэрүүд (сэргээшийн төрлийн бодисын онлайн худалдаа гэх мэт) нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг тайлбарлах боломжийг олгодог. Боломжийн онолын гол үзэл баримтлал болох "Гэмт хэргийн гурвалжин" буюу сэдэл бүхий этгээд, тохиромжтой бай болон хяналтын механизм огтлолцох үед гэмт хэрэг үйлдэгддэг гэх зарчим нь сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийн өнөөгийн практик нөхцөл байдлыг шинжлэх үндэслэл болох юм.

Онолын гарал үүсэл ба суурь үзэл баримтлал

Лоренс Коэн ба Маркус Фелсон нарын 1979 онд боловсруулсан онол нь гэмт хэрэг яагаад нийгмийн хөгжил дэвшилтэй хамт нэмэгддэгийг тайлбарлах зорилгоор бий болсон. Тус онол нь гэмт хэрэг нь хувь хүний ёс суртахуун, нийгмийн доройтол биш, харин хүний өдөр тутмын үйл ажиллагааны загвар хэрхэн өөрчлөгдсөнөөс хамаарч бий болдог гэж үзсэн.

1. Боломж нь гэмт хэрэг бий болгодог (Opportunity Creates Crime)

Уламжлалт криминологи нь гэмт хэрэгтний шинж чанарт анхаарлаа хандуулдаг байсан бол Коэн, Фелсон нар “орчин тойрны боломж”-ийг онцолсон. Тохиромжтой зорилтот объект байгаа, харгалзагч (хяналт) дутмаг нөхцөлд гэмт хэрэг бараг автоматаар нэмэгддэг гэж үзсэн.

2. Нийгмийн хөгжил гэмт хэргийн боломжийг нэмэгдүүлдэг

Америкийн Нэгдсэн Улсын 1960-1770 оны жишээн дээр судалгаа хийхдээ Коэн, Фелсон нар нь дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэж, боловсрол дэлгэрч, нийгмийн байдал сайжирсан ч гэмт хэрэг нэмэгдсэн шалтгааныг "хүмүүс гэрээсээ гарч, ажилд явах болсноор гэрийн хамгаалалт суларч, хулгай нэмэгдсэн" гэж тайлбарласан. Энэ нь гэмт хэрэг нь "нийгмийн хямрал"-аас биш, хэвийн нийгмийн өөрчлөлтөөс ч бий болдог гэдгийг харуулна.

3. Макро нийгмийн шалтгааны тайлбар

Гэмт хэрэгтний хувийн шинж чанараас биш, нийгмийн бүтэц, байгууллагын зохицуулалтын тогтолцоо гэмт хэргийн хэмжээг тодорхойлдог. Иймд гэмт хэргийн урьдчилан сэргийлэлт нь хувь хүний "засал" биш, нийгмийн орчин тойрны өөрчлөлт-д чиглэх ёстой.

Боломжийн онолыг санхүүгийн гэмт хэрэгт хэрэглэх нь: Орчин үеийн санхүүгийн хүрээнд боломжийн онол нь мөнгө угаах гэмт хэргийн нэмэгдэж буй шалтгааныг тайлбарлахад хүчтэй хэрэгсэл болж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. *Боломжийн онол санхүүгийн гэмт хэрэгт*

Нийгмийн өөрчлөлт	Бий болгосон боломж	Мөнгө угаах гэмт хэрэг дахь нөлөө
Дижитал банкны хөгжил	Шууд, бодит цагийн шилжүүлэг	Мөнгийг хурдан, олон давхаргаар шилжүүлэх боломж
Криптовалютын тархалт	Нэргүй гүйлгээ	Гарал үүсвэрийг нуух шинэ арга зам бий болох
Глобалчлал, хил дамнасан бизнес	Олон улсын санхүүгийн интеграци	Оффшор бүтцийг ашиглах боломж
Зах зээлийн нийлмэл бүтэц	Санхүүгийн бүтээгдэхүүний нарийн төвөгтэй байдал	Хяналтын механизмын цооролт нэмэгдэх
Онлайн аль нэгийг биечлэн ирэхгүй үйлчилгээ	Үйлчлүүлэгчийг биечлэн баталгаажуулах шаардлага байхгүй	КҮС хяналт суларсан нөхцөл бий болох

Эх сурвалж: (Clarke, 1983; Cohen & Felson, 1979; Farrell & Clarke, 2004; Felson, 2002).

Боломжийн онолд үндэслэсэн Нөхцөл байдлын гэмт хэргийн урьдчилан сэргийлэлт (Situational Crime Prevention — Clarke, 1983) нь өнөөдөр мөнгө угаах гэмт хэргийг эсэргүүцэх бодлогын нэг суурь болсон байна:

- Боломжийг хааж, хяналтыг нэмэгдүүлэх (Reducing Opportunity)
- Зорилтот объектын эрсдэлд тэнцвэртэй байдлыг нэмэгдүүлэх (Target Hardening) — КҮС шаардлагыг чангатгах
- Хяналтын боломжийг нэмэгдүүлэх (Increasing the Chance of Being Caught) — STR, мониторингийн тогтолцоо
- Хорлогчийн цөхрөлийг нэмэгдүүлэх (Reducing Provocations) — иргэний боловсрол, мэдлэг нэмэгдүүлэх (Clarke, 1983; Cohen & Felson, 1979; Farrell & Clarke, 2004; Felson, 2002).

Дээрх онолын хүрээнд тайлбарлавал сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт явагдахад сэргээш худалдах этгээд (сэдэл бүхий этгээд), хяналтгүй сэргээшийн төрлийн бодис (тохиромжтой бай), хууль эрх зүйн хяналтгүй байдал (харгалзагч байхгүй) гэсэн гурван нөхцөл бүрдэж гэмт хэрэг үйлдэгдэх “Боломж” нь бүрдэж байна.

Дүгнэлт: Сэргээшийн төрлийн бодис нь олон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисоос тодорхой шалгуураар ялгагддаг бие даасан бодис болох нь тогтоогдлоо. ДДЭА-ын хориглосон жагсаалт болон НҮБ-ын конвенцуудын жагсаалтад багтсан зарим бодис (кокаин, амфетамин г.м) давхцаж байгаа боловч анаболик, стероид, өсөлтийн даавар зэрэг бодисууд нь зөвхөн сэргээшийн төрөлд хамаарч эрүүгийн эрх зүйн хяналтаас гадуур үлдэх эрсдэлтэй байна.

Сэргээшийн төрлийн бодис нь зөвхөн спортын шударга өрсөлдөөнийг зөрчөөд зогсохгүй, хүний зүрх судас, сэтгэц, нөхөн үржихүйн тогтолцоонд хор уршиг учруулж, донтолт үүсгэх эрсдэлтэй болох нь батлагдлаа. Энэ нь уг асуудлыг зөвхөн спортын зөрчил гэж үзэх бус нийгмийн эрүүл мэндийн эсрэг аюул гэж үзэх үндэслэл болж байна.

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох бүрэн боломжтой бөгөөд уг гэмт хэргийг үйлдэх замаар олсон орлого нь санхүүгийн системд шингэж, хууль ёсны бизнес рүү хөрвөх замаар зохион байгуулалттай гэмт хэргийг санхүүжүүлж буй механизмыг илрүүлэх нь судалгааны нэг гол ач холбогдол юм.

Боломжийн онолын хүрээнд авч үзвэл сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон мөнгө угаах гэмт хэрэг нь нийгмийн хөгжил, дижитал шилжилтээс үүдэлтэй “боломж”-оос хамаарч байна. Онолын хүрээнд авч үзвэл уг гэмт хэргийн урьдчилан сэргийлэлтийг хувь хүн рүү биш, харин гэмт хэрэг үйлдэгдэх “боломжийг хаах” буюу хяналтын тогтолцоог сайжруулахад чиглүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Дэлхий нийтэд сэргээшийн төрлийн бодисын эсрэг тэмцэл эрчимжиж байгаа хэдий ч сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь зөвхөн мэргэжлийн спортын хүрээнээс хальж, нийгмийн эрүүл мэндэд заналхийлсэн далд зах зээл болон өргөжиж байна. Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд энэ төрлийн бодисын олдоц нэмэгдэж, хяналт шалгалтын явцад илэрч буй тохиолдлууд нь уг асуудлыг эрх зүйн болон практик түвшинд нарийвчлан судлах зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Энэхүү дэд бүлгийн хүрээнд Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагаас гаргасан сүүлийн үеийн мэдээлэл, хяналтын байгууллагуудын ажиллагааны үр дүн болон зах зээл дээрх сэргээшийн төрлийн бодисын бодит хүртээмжид хийсэн судалгааг танилцуулна.

Мөн энэхүү бүлэгт Монгол Улсын одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчинд сэргээшийн төрлийн бодисын зохицуулалт хэрхэн тусгагдсаныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нарийвчлан судалж эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудлыг илрүүлэхээр зорилоо.

2.1 Монгол Улс дахь сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон мөнгө угаах гэмт хэргийн уялдаа нь Монгол Улсын нөхцөлд тодорхой онцлог шинжтэйгээр илэрч байна. Энэ нь зөвхөн олон улсын гэмт хэргийн сүлжээний нөлөө бус, харин газар зүйн байршил, эдийн засгийн бүтэц, санхүүгийн тогтолцооны онцлог, нийгмийн өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой. Юуны өмнө Монгол Улс хоёр том зах зээлийн дунд оршдог, өргөн уудам газар нутагтай, хилийн шугам урт улс гэдгээрээ онцлогтой. Монгол-Хятадын болон Монгол-Оросын хилийн зарим хэсэг нь хүн ам сийрэг, газар зүйн хувьд хяналт тогтооход хүндрэлтэй бүс нутагт байрладаг. Энэ нь хууль бус тээвэрлэлтийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь Монгол Улсад зөвхөн спортын ёс зүйн зөрчлийн хэмжээнээс хальж, банк санхүүгийн систем, далд эдийн засаг, мөнгө угаах гэмт хэргийн шинэ суваг болон өргөжсөнийг бодит баримтууд илтгэж байна.

Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага нь 2025 оны эхний хагас жилд хяналтын байгууллагуудын ажиллагааны хүрээнд илрүүлж, хурааж авсан допингийн бодисууд нь спортын салбарын хүрээнээс хальж, нийгмийн эрүүл мэнд, ялангуяа залуу үеийн ирээдүйд бодитоор аюул учруулж байгааг онцолсон байна. (Монголын Үндэсний Допингийн эсрэг байгууллага, 2025)

МҮДЭБ-аас гаргасан албан ёсны мэдээлэлд дурдсанаар сэргээшийн төрлийн бодисууд нь зөвхөн мэргэжлийн тамирчдаар хязгаарлагдахгүй, спортоор хичээллэж эхэлж буй хүүхэд, залуучуудад хууль бусаар худалдаалж байгаа нь үндэсний хэмжээний ноцтой асуудал болоод байна. Эдгээр бодисын хяналтгүй хэрэглээ нь дараах сөрөг үр дагаврыг дагуулдаг болохыг анхааруулжээ. Үүнд:

- Эрүүл мэндэд ноцтой хор уршигтай,
- Дааврын тэнцвэр алдагдуулж, урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг,
- Хараат байдал үүсгэх эрсдэлтэй,
- Шударга өрсөлдөөнийг алдагдуулдаг (Монголын Үндэсний Допингийн эсрэг байгууллага, 2025).

Допингийн эсрэг байгууллагын 2025 оны эхний хагас жилд хурааж авсан сэргээшийн төрлийн бодисын зургийг нийтэд мэдээлсэн (Зураг 1).

Зураг 1. 2025 оны эхний хагас жилд хураан авсан сэргээшийн төрлийн бодисууд



Эх сурвалж: (Монголын Үндэсний Допингийн эсрэг байгууллага, 2025)

2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Чингис хаан Олон улсын агаарын боомтоор Истанбул Улаанбаатар чиглэлээр зорчиж ирсэн Бүгд найрамдах Турк улсын иргэн улсын хилээр Дэлхийн Допингийн эсрэг байгууллагын хориглосон жагсаалтад багтсан 13 нэр төрлийн нийт 29,000 таблетик, 4000 ширхэг сэргээшийн төрлийн эм тариаг хууль бусаар нэвтрүүлэх гэж байсныг хяналт шалгалтын явцад илрүүлжээ. Илэрсэн бодисуудын зарим нь хүнд хэрэглэхийг хориглоно гэсэн анхааруулгатай, хүний эрүүл мэндэд ноцтой хор нөлөөтэй болох нь тогтоогдсон байна (Ийгл Ньюс, 2026).

Сэргээшийн төрлийн бодисын нийлүүлэлт, далд худалдаа хяналтаас гарсан практик нөхцөл байдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусгай сурвалжлагаар хөндөн тавьсан байна. Тухайлбал, "Ийгл Ньюс" телевизийн Допинг тусгай сурвалжилгад Олимпын медальт тамирчин, Жүдо бөхийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, Олон улсын ба үндэсний спортын арбитрын допингийн арбитрч болон спортын багш, дасгалжуулагч нар оролцож Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус сүлжээ хэдийн үүссэн бөгөөд үүнийг фитнесийн багш дасгалжуулагчид гар дээрээс зарж борлуулж буй далд практик байгааг албан ёсоор батлан илэрхийлжээ (Ийгл Ньюс, 2026).

Сүүлийн жилүүдэд фитнес, бодибилдинг сонирхогч иргэдийн дунд сэргээшийн төрлийн бодисын (стероид, гормон г.м) хэрэглээ эрс нэмэгдсэн. Гэвч энэ тохиолдолд "спортын тэмцээн" биш учраас Допингийн эсрэг үндэсний дүрэм үйлчилдэггүй. Эдгээр бодисууд нь мансууруулах бодис биш учраас цагдаагийн байгууллага хяналт тавьж, хураах эрх зүйн үндэслэл сул байдаг. Үүний үр дүнд сэргээшийн хууль бус, хяналтгүй зах зээл бүрдэж, түүнээс олсон орлого нь мөнгө угаах гэмт хэргийн эх үүсвэр болох эрсдэлийг бий болгож байна.

Судлаачийн зүгээс сэргээшийн төрлийн бодис нь эмийн сан болон хувь хүний гар дээрээс ямар хяналттайгаар зарагдаж буйг бодит нөхцөл байдал дээр тогтоох зорилгоор тандалтын судалгааг хийж гүйцэтгэсэн.

Судалгаанд WADA-аас гаргасан 2026 оны Допингийн хориглосон жагсаалтад багтсан боловч НҮБ-ын конвенцуудын жагсаалтад ороогүй буюу хяналт сул байх магадлалтай дараах хоёр төрлийн бодисыг сонгон авсан болно. Үүнд:

- Ретаболил (Retabolil): Анаболик стероид,
- Жинтропин (Jintropin): Өсөлтийн даавар.

Тандалтын судалгааны явцад дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

Нэгдүгээрт: “Эмийн сан-1”- ийн салбарууд болон онлайн худалдааны сувгаар “Ретаболил” гэх сэргээшийн төрлийн бодисыг ямар нэгэн тусгай зөвшөөрөл, жор шаардахгүйгээр худалдан авах боломжтой байна. Судалгаа хийх үеийн зах зээлийн ханшаар 50 мг/1 мл тунгаар савлагдсан ретаболил нь 31,500 төгрөгийн үнэтэй байна.

Хоёрдугаарт: “Эмийн сан-2”-оос “Жинтропин” гэх сэргээшийн төрлийн бодисыг 1,199,000 төгрөгөөр худалдан авах боломжтой байгаа нь өндөр үнэтэй боловч хүртээмжийн хувьд нээлттэй байгааг харуулж байна.

Дээрх тандалтын судалгааны үр дүнгээс үзэхэд олон улсын түвшинд спортын салбарт хатуу хориглосон бодисууд нь дотоодын зах зээлд эмийн бодисын нэршлээр чөлөөтэй худалдаалагдаж байгаа нь эдгээр бодисын хууль бус эргэлт болон зүй бус хэрэглээг хянах эрх зүйн зохицуулалт дутагдалтай байгааг илтгэж байна.

Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газрын 2019–2023 оны тайлангийн мэдээллийг (Цагдаагийн Ерөнхий газар, 2019-2023) нэгтгэн харвал мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг тогтвортой өсөлттэй байгааг харуулж байна (Хүснэгт 4).


Хүснэгт 4. 2019-2023 оны хооронд бүртгэгдсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэргийн тоо

Он	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэрэг	Мөнгө угаах гэмт хэрэг	Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болсон тохиолдол
2019	18,542	312	45	18
2020	19,103	389	52	24
2021	20,215	451	67	31
2022	21,890	523	89	48
2023	23,467	612	112	67

Эх сурвалж: (Цагдаагийн Ерөнхий газар, 2019-2023).


Дээрх тоо баримтаас харахад 2019–2023 оны хооронд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 96.2% өссөн бол мөнгө мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болж байгаа тохиолдол 272% (гурав дахин гаруй) өсжээ (Зураг 2). Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэрэг нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болж байгаа хэрэг ихэсгэж буй системтэй хандлагыг харуулж байна (Зураг 3).

Зураг 2. Мансууруулах бодис болон мөнгө угаах гэмт хэргийн статистик



Эх сурвалж: (2019–2023 он, ЦЕГ-ын тайлан)

Зураг 3. Гэмт хэргийн үзүүлэлтүүдийн өсөлтийн харьцуулалт



Эх сурвалж: (2019–2023 он, ЦЕГ-ын тайлан)

Харин Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газрын 2019–2023 оны тайлангийн мэдээллийг (Цагдаагийн Ерөнхий газар, 2019-2023) нэгтгэн үзэхэд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтэй холбоотой хэрэг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болсон хэрэг бүртгэгдээгүй байна. Зураг 2, Зураг 3-т үзүүлсэн өсөлт нь мансууруулах эм,

сэтгэцэд нөлөөлөх бодисын урсгалыг харуулж байгаа бөгөөд сэргээшийн төрлийн бодис хяналтын гадна үлдэж буйг батлах харьцуулалт юм.

Сүүлийн жилүүдэд фитнес, бодибилдинг сонирхогч иргэдийн дунд анаболик стероид, өсөлтийн дааврын хэрэглээ эрс нэмэгдсэн боловч эдгээр нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын ангилалд ордоггүй тул Цагдаагийн байгууллагаас хяналт тавьж шалгах, хөрөнгө, орлогыг нь хураах, тайлан мэдээндээ оруулах эрх зүйн үндэслэл сул байна.

Санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл, тайланд хийсэн дүн шинжилгээ: Санхүүгийн мэдээллийн алба (2020-2024)-ны сүүлийн 5 жилийн тайланд сэжигтэй гүйлгээний мэдээлэл (STR) болон бэлэн мөнгөний гүйлгээний мэдээлэл (CTR)-ийн статистикийг судлахад мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх, болон залилах гэмт хэрэг тэргүүлж байна. Харин нийгмийн эрүүл мэндийн эсрэг эсвэл сэргээшийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой мэдээлэл тусгагдаагүй байна.

Санхүүгийн мэдээллийн албаны тайлангуудад энэ төрлийн санхүүгийн урсгал тусгагдаагүй байгаа нь "эрсдэл байхгүй" гэсэн үг биш бөгөөд тус алба болон мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн хяналтын радар, эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтэд "сэргээшийн төрлийн бодис" гэдэг ойлголт тусгагдаагүй байгаатай холбоотой юм. Сэргээшийн төрлийн бодисыг импортлож, борлуулж буй гол суваг болох фитнес клуб, спортын холбоо, онлайн нэмэлт тэжээлийн дэлгүүр болон эрүүл мэндийн хувийн клиникүүд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар тогтоосон "мэдээлэх үүрэгтэй этгээд"-ийн жагсаалтын гадна үлдэж байна. Энэ нь сэргээшийн төрлийн бодисын худалдаанаас олж буй орлогыг мөнгө угаах эрсдэлтэй гэж үзэх санхүүгийн хяналтын тогтолцоо манай улсад сул байгааг илтгэж байна.

Санхүүгийн мэдээллийн албаны 2020-2024 оны жилийн тайлангуудад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, Монгол Улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх стратеги нь уламжлалт суурь гэмт хэргүүд болох авлига, татвараас зайлсхийх үйлдлүүдэд хэт төвлөрсөн байна. 'Боломжийн онол' (Routine Activity Theory)-ын үүднээс авч үзвэл, сэргээшийн төрлийн бодисын далд худалдаанаас үүдэлтэй санхүүгийн далд урсгал Санхүүгийн мэдээллийн албаны хяналтын радарт өртөхгүй байгаа нь гэмт этгээдүүдэд 'Үр нөлөөтэй харгалзагч байхгүй' (Absence of capable guardian) нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн системийг 'Тохиромжтой бай' (Suitable target) болгон ашиглах эрх зүйн болон практик боломжийг олгож байна. Иймд Санхүүгийн мэдээллийн албаны эрсдэлийн шалгуур үзүүлэлтэд тусгайлан өөрчлөлт оруулж, фитнес, эрүүл мэндийн салбарын санхүүгийн урсгалыг хяналтад авах шаардлагатай байна.

Тамирчдын сэргээшийн төрлийн бодисын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ: Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, түүний далд санхүүгийн урсгалыг хянах механизм хэрхэн уналтад орсныг тамирчдаас илэрч буй допингийн тоон үзүүлэлт болон холбогдох институцийн бүтцийн эрсдэлээс харж болно. Биеийн тамир спортын улсын хорооны Антидопинг сайт дээр допинг хэрэглэсэн тамирчдын хар жагсаалтаас үзэхэд допингийг дан ганц бөхчүүд ч биш, хүндийн өргөлтийнхөн, бодибилдинг зарим тулааны спортын тамирчид хэрэглэж байсан нь харагдана. Тамирчдын ихэнхи нь хүний эрүүл мэндэд эрсдэлтэй анаболик стероид хэрэглэх замаар

булчингийн массаа нэмж хүч тамираа шударга бусаар өсгөсөн нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан юм (Ийгл Ньюс, 2026).

Энгийн иргэд, фитнесээр хичээллэгчдийн дундах сэргээшийн төрлийн бодисын хэрэглээний статистикийг шууд гаргах практик боломжгүй боловч мэргэжлийн болон үндэсний спортын тамирчдын дундах эерэг хариу (илрэлт)-ийн хувь хэмжээ өндөр байгаа нь энэ төрлийн бодисын нийлүүлэлт, далд худалдаа ямар ч хяналтгүйгээр нийгэмд нэвтэрснийг гэрчилж байна.

Түүнчлэн, олон улсын түвшинд Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (WADA)-аас Монгол Улсыг дүрэм, журмаа мөрдөөгүй гэж үзэн ноцтой болон чухал ангиллын нийт 21 зөрчлийг арилгахыг шаардаж байсан нь дотоодын хяналтын тогтолцоо бүрэн нурсныг илтгэдэг (World Anti-Doping Agency, 2023).

"Ийгл Ньюс" телевизийн Допинг тусгай сурвалжилгаар сэргээшийн төрлийн бодисыг олох хэцүү юу? Хүссэн бүхэн авч хэрэглэх боломжтой юу? гэдгийг Үндэсний шигшээ багийн тамирчдын эрүүл мэндийг хамгаалдаг эмчээс лавлахад: Тусдаа юм бол байхгүй. Яагаад гэвэл өөрөө эмийн бодис учраас бүгд л өвчнийг эмчлэн зорилгоор бүтээгдсэн. Эмийн санд худалдаалагдаж байдаг. Зүгээр иргэд ханиадандаа аваад хэрэглэж байдаг. Зүрх өвдөхөд байнга хэрэглэдэг энгийн эмнүүд байдаг. Бүх цаг үед хориглосон эмийн бэлдмэлүүдээс манай Монгол Улсын эмийн бүртгэгдээд зүгээр эмийн санд зарагдаж байдаг бодисууд байдаг. Хямдхан байдаг гэжээ. (Ийгл Ньюс, 2026).

"Боломжийн онол"-ын "Үр нөлөөтэй харгалзагч байхгүй" (Absence of a capable guardian) гэх нөхцөлийг улсын хэмжээнд хамгийн дээд цэгт нь хүргэж байна (Cohen & Felson, 1979). Өөрөөр хэлбэл, допингийн бодисын хилээр нэвтрэх урсгал болон дотоодын борлуулалтад хяналт тавих хууль эрх зүйн орчин сул, дээр нь хяналт тавих ёстой институци нь өөрөө ажиллах чадамжгүй болсон нь гэмт этгээдүүдэд сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар нийлүүлж, түүнээс олох орлогоо чөлөөтэй угаах 'тохиромжтой бай' болон санхүүгийн аюулгүй талбарыг Монгол Улсад бүрдүүлж өгч байна.

2.2 Эрх зүйн зохицуулалтын тулгамдаж буй асуудал

2.2.1 Олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилт ба хүлээсэн үүрэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т Монгол Улс олон улсын гэрээг сахин биелүүлэх үүрэгтэйг заасан нь олон улсын конвенци, олон улсын стандартуудыг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх эрх зүйн үндэслэл болдог.

Монгол Улс нь 2005 онд “Спортод сэргээшийн эсрэг Копенгагены тунхаглал”-д нэгдэн орсон, Улсын Их Хурлаас 2007 онд “Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц”(International Convention against Doping in Sport)-ыг соёрхон баталсан. Монгол Улс Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцэд 2007 онд нэгдэн орсноор олон улсын өмнө спортын салбарт допингийн эсрэг тэмцэх, WADA-гийн дүрмийг дагаж мөрдөх, тамирчдаа допингоос ангид байлгах хууль эрх зүйн үүрэг хүлээсэн юм. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) баталсан энэхүү конвенци нь спортод сэргээш хэрэглэхийн эсрэг урьдчилан сэргийлэх, тэмцэх, улмаар түүнийг арилгахад биеийн тамир, спортын салбар дахь ЮНЕСКО-ийн

бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлэх зорилготой. Конвенцийн хэрэгжилтийг хангахаар “Допингийн эсрэг үндэсний төв” байгуулагдаж тамирчдаас сэргээшийн төрлийн бодисын шинжилгээ авах, сургалт сурталчилгаа хийх эрх зүйн орчин бүрдсэн.

2000 онд батлагдсан “Транснациональ зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай” Конвенц (Палермогийн Конвенц) нь мөнгө угаах гэмт хэргийг илүү өргөн хүрээнд авч үзсэн олон улсын баримт бичиг юм. Венийн Конвенц нь мансууруулах бодистой холбоотой орлогод төвлөрч байсан бол Палермогийн Конвенц нь аливаа ноцтой гэмт хэргийн орлоготой холбоотой мөнгө угаахыг криминализац хийхийг гишүүн улсуудад үүрэг болгосон. Энэхүү Конвенцын хүрээнд мөнгө угаах гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчлах, суурь гэмт хэргийн хүрээг өргөжүүлэх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй тэмцэх, олон улсын эрх зүйн харилцан туслалцааг өргөжүүлэх шаардлагыг тавьсан. Палермогийн конвенцын дагуу 'ноцтой гэмт хэрэг'-ийн хүрээг өргөжүүлсэн нь сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг 'мөнгө угаах' гэмт хэргийн суурь гэмт хэрэг (predicate offense) болгон үзэх олон улсын эрх зүйн боломжийг олгож байна. Олон улсын түвшинд мөнгө угаах гэмт хэргийг 1988 оны НҮБ-ын Конвенц, 2000 оны Палермогийн Конвенц болон FATF-ийн 40 зөвлөмжөөр тодорхойлж, гишүүн улсуудад бие даасан эрүүгийн гэмт хэрэг болгон хуульчлах үүрэг ногдуулсан.

Дэлхийн Допингийн эсрэг дүрэм нь спортын салбарт допингийн эсрэг үйл ажиллагааг дэлхий даяар нэгдсэн стандарт, дүрэм журмаар зохицуулах Дэлхийн допингийн эсрэг хөтөлбөрийн суурь болсон үндсэн болон нийтлэг бичиг баримт юм. Дүрмийн зорилго нь допингийн эсрэг тэмцлийн үндсэн элементүүдийг нэгтгэн допингтой тэмцэх, үр дүнг сайжруулахад оршдог ба зөвхөн "Гарын үсэг зурах эрх бүхий этгээд" (олон улсын болон үндэсний спортын холбоод, Олимпын хороо гэх мэт) болон тэдгээрийн харьяанд байдаг тамирчид, тамирчны туслах ажилтнуудад (дасгалжуулагч, эмч г.м) хамаардаг.

Хориглосон жагсаалт нь WADA-аас гаргасан спортын салбарт хэрэглэхийг хориглосон бодис болон аргуудын албан ёсны жагсаалт юм. Дэлхийн Допингийн Эсрэг Хөтөлбөрийн хүрээнд заавал мөрдөх Олон Улсын стандарт ба жагсаалтыг жил бүр шинэчлэн гаргадаг. Энэхүү хориглосон жагсаалт нь дэлхий нийтээр хориглосон сэргээшийн төрлийн бодисын гол жагсаалт юм.

Уг жагсаалтаар сэргээшийн төрлийн бодисуудыг дараах байдлаар ангилдаг:

Бүх цаг үед хориглосон (Тэмцээний болон тэмцээний бус үед): Анаболик бодисууд (булчингийн масс нэмэгдүүлэгч), даавар, өсөлтийн хүчин зүйлс, бета-2 агонистууд, даавар ба бодисын солилцооны модуляторууд, шээс хөөх болон бусад бүрхүүл үүсгэгч бодисууд багтана.

Тэмцээний үед хориглосон: Зөвхөн тэмцээний явцад хэрэглэхийг хориглох өдөөгч буюу сэргээшүүд, мансууруулах бодис, каннабиноид, глюкокортикоидууд багтана.

Тодорхой спортын төрөлд хориглосон: Жишээлбэл, бета-блокаторууд нь бай буудах, бай сур харвах зэрэг анхаарал төвлөрөл шаардсан спортын төрөлд хориглогддог.

WADA-аас баталсан “Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандарт 2016” (International Standard for Therapeutic Use Exemptions - ISTUE) 2016 нь дэлхийн

допингийн эсрэг хөтөлбөрийн нэгэн хэсэг олон улсын стандарт юм. Анх 2004 онд батлагдаж 2005 оны 1-р сарын 1-ны өдрөөс эхлэн үйлчилж эхэлсэн ба 2009, 2010, 2011, 2015 онуудад шинэчилсэн хувирлбарыг тус тус баталсан.

Уг стандартаар тамирчин өөрийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан “Хориглосон жагсаалт”-д орсон бодис, аргыг эмчилгээний журмаар зайлшгүй шаардлагатай болсон тохиолдолд түүнийг зөвшөөрөх үйл ажиллагааг зохицуулсан. Тамирчин стандартын дагуу зөвшөөрөл авсан бол тамирчны биеэс хориотой бодис илрэх, эсвэл хэрэглэсэн тохиолдолд Допингийн эсрэг дүрмийг зөрчихгүй байхаар заасан.

Монгол Улсын нэгдэн орсон дээрх олон улсын гэрээ, конвенцууд болон WADA-ийн стандартуудыг шинжлэхэд манай улс спортын хүрээнд допингийн эсрэг тэмцэх 'сахилгын' хариуцлагын тогтолцоог олон улсын түвшинд бүрэн нийцүүлсэн байна. Гэвч Палермогийн конвенцоор хүлээсэн үүргийн дагуу сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах үйл ажиллагааны суурь нөхцөл гэж үзэж, эрүүгийн эрх зүйн зохицуулалтаар нарийвчлан хянах асуудал нь дотоодын хууль тогтоомжид (Эрүүгийн хууль болон бусад хууль) бүрэн тусгалаа олж чадаагүй байна. Энэ нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг 'иж бүрэн' биелүүлэхэд эрх зүйн практик түвшинд тулгамдаж буй асуудал юм.

2.2.2 Дотоодын эрх зүйн тогтолцоо ба сэргээшийн төрлийн бодисын зохицуулалтын хязгаарлагдмал байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах” эрхтэй гэж заасан нь төрөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хортой бодисын эргэлтийг хязгаарлах, урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлэх үүргийг давхар үүсгэдэг. Сэргээшийн төрлийн бодис нь хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой хор уршиг учруулдаг тул түүний хууль бус эргэлтийг таслан зогсоох нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрхийг хамгаалах бодит хэрэгжилтийн нэг хэлбэр юм. Үүнтэй уялдан Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд иргэний үндсэн үүргийг тодорхойлж, хууль сахих, нийгмийн дэг журам, нийтийн ашиг сонирхлыг хүндэтгэх үүргийг тогтоосон. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус хэрэглээ, түгээлт нь зөвхөн хувь хүний асуудал бус, нийгмийн аюулгүй байдал, ёс суртахуун, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг тул иргэний үүрэг болон төрийн хамгааллын бодлого хоорондоо харилцан уялдаатай.

Биеийн тамир, спортын тухай хуулиар допингийн эсрэг үндэсний тогтолцоог хуульчилж өгсөн бөгөөд Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц, Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон Допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилтийг дараах байгууллагууд хангаж ажиллахаар заасан. Үүнд:

- Монголын үндэсний олимпын хороо;
- Монголын үндэсний паралимпын хороо;
- Допингийн эсрэг үндэсний байгууллага;
- Допингийн эсрэг үндэсний зөвлөл;
- Монголын олон улсын ба үндэсний спортын арбитр.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дэх хэсэгт допинг гэж спортын үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглосон бодис, хориотой аргыг хэлнэ гэж заасан бөгөөд уг хуулиар

суралцагч, тамирчдыг допинг хэрэглэхийг хориглосон харилцааг зохицуулсан. Монгол Улс нь WADA-с гаргасан дүрэм, заавар, зөвлөмж, олон улсын стандартын хэрэгжүүлж ажиллах үүрэгтэйг хуульчилсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 376 дугаар тогтоолын хавсралтаар “Допингийн эсрэг үндэсний дүрэм” батлагдсан. Допингийн эсрэг үндэсний дүрмийн гол зорилго нь спортод допинг хэрэглэхтэй тэмцэх ажлыг Дэлхийн допингийн эсрэг дүрмийн хүрээнд Монгол Улсад удирдах, зохион байгуулах, хянах, допинггүй спорт бий болгоход оршдог.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг.

Энэхүү хуулиар Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист ямар, ямар бодисууд хамаарахыг хуульчлан тогтоож өгсөн ба тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенц, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцын жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист хамааруулаар заасан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенц болон “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцод тусгагдаагүй “сэргээшийн төрлийн бодис” -ын эргэлтэд хяналт тавих зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын 2015 онд баталж, 2017 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хууль нь мөнгө угаах гэмт хэргийг бие даасан зүйл болгон тодорхойлж, олон улсын эрх зүйн баримт бичиг, ялангуяа НҮБ-ын 1988 оны Конвенц болон FATF-ийн зөвлөмжид нийцүүлэх зорилгоор шинэчлэгдсэн нь онцлог юм. Өмнөх хууль тогтоомжид мөнгө угаахтай холбоотой зохицуулалт хязгаарлагдмал, ерөнхий шинжтэй байсан бол шинэчилсэн Эрүүгийн хуульд гэмт хэргийн бүрэлдэхүүн, ял шийтгэлийн бодлогыг илүү тодорхой тусгасан байна.

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд мөнгө угаах гэдэгт “гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан” үйлдлийг хамааруулж хуульчилсан бөгөөд зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр зохицуулсан.

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 2,3,4 дэх хэсгүүдэд Мөнгө угаах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дараах үйлдлүүдийг мөнгө угаах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хамааруулж нэг жилээс таван жил хүртэл

хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Үүнд:

- хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн,
- байнга тогтвортой мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн,
- албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн.

Мөнгө угаах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол Эрүүгийн хуульд хамгийн хүнд ял шийтгэл буюу таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан байна.

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1-3 дахь зохицуулалт нь мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн хувь хүнд хамааралтай зохицуулалт бол 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт мөнгө угаах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэхээр зохицуулсан байна. Эрүүгийн хуулийн 20.7-20.10 заалтуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргүүдийг хуульчилсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, хэрэглэх орон байраар хангах, завших, мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

Харин Эрүүгийн хуульд “Сэргээшийн төрлийн бодис”, “Допингийн бодис”- той холбоотой тусгай зохицуулалт байхгүй байна.

Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.14 дугаар зүйлд хүний эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй эм, эмийн түүхий эд, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсэн бол гэмт хэрэгт тооцож хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, их хэмжээний хохирол учирсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцож арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байна. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой харилцаа нь Эрүүгийн хуулийн 20.14 “Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах” заалтаар зохицуулагдахад заасан “Эм, эмийн түүхий эд”-ийн хүрээнд авч үзэх нь түүний нийгмийн аюул, эрүүл мэндэд үзүүлэх хор уршигтай нь нийцэхгүйгээс гадна тухайн зохицуулалтад бүрэн хамаарах нь эргэлзээтэй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэл-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах, хадгалах, түгээх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд Допингийн жагсаалтад орсон эмд ямар эмүүд хамаарахыг хуульчилсан бөгөөд тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дэх хэсэгт Дэлхийн допингийн эсрэг код, олон улсын стандартад хориглосон жагсаалтад орсон эмийг “допингийн жагсаалтад орсон эм” гэж хэлнэ гэж заасан. Энэхүү хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.11 дэх заалтаар сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой зохицуулалтыг хуульчилж өгсөн. Уг зохицуулалтаар Дэлхийн допингийн эсрэг код, олон улсын стандартад хориглосон жагсаалтад орсон эмийг тамирчин болон спортоор хичээллэж байгаа иргэнд эмчилгээний бус зорилгоор санал болгох, дэмжин сурталчлах, зарж борлуулахыг хориглосон. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулинд дээрх хоёр зохицуулалтаас өөр сэргээшийн төрлийн бодистой холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна .

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах харилцааг зохицуулсан.

Хууль нь эрүүгийн хариуцлагын зохицуулалтыг дангаар нь хэрэгжүүлэхээс илүүтэйгээр санхүүгийн системийн дотоод хяналт, мэдээллийн урсгал, эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан урьдчилан сэргийлэх механизмыг бий болгоход чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэний дараа бус, үйлдэхээс өмнө илрүүлэх, эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлэх зорилготой.

Хууль нь FATF-ийн 40 зөвлөмжид нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд эрсдэлийн суурьт хандлагыг (Risk-Based Approach) үндсэн зарчим болгон тусгасан. Энэ нь бүх харилцагчид ижил түвшний хяналт хэрэглэх бус, харин эрсдэлийн түвшнээс хамааран хяналт, шалгалтыг ялгавартай хэрэгжүүлэх үзэл баримтлал юм.

Зөрчлийн тухай хуулийн Допингийн эсрэг үндэсний дүрмийг зөрчсөн тамирчин болон эмчид зөрчлийн хариуцлага оногдуулахаар заасан. Зөрчлийн тухай хуулийн 6.19 дүгээр зүйлийн 6.19.7 дэх заалтад Допингийн эсрэг үндэсний дүрмийг зөрчсөн бол спортын тэмцээнд оролцох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.

Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дугаар зүйлийн 7.2-т Эмч: Тамирчин болон спортоор хичээллэж байгаа иргэнд эмчилгээний бус зорилгоор Дэлхийн допингийн эсрэг код, олон улсын стандартад хориглосон жагсаалтад орсон эмийг санал болгосон, дэмжиж сурталчилсан, зарж борлуулсан бол таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж хуульчилсан.

Харин иргэний Допингийн бодистой холбоотой хууль бус үйлдлийг зохицуулсан зохицуулалт байхгүй.

Монгол Улс олон улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж, дотоодын хууль тогтоомжид тодорхой зохицуулалтуудыг тусгасан боловч эдгээр нь зөвхөн спортын хүрээнд болон эмч, тамирчин гэх явцуу субъектүүдэд чиглэсэн байна. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг нийтийн эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдалд

заналхийлж буй "бие даасан гэмт хэрэг" гэж үзэж, мөнгө угаах гэмт хэргийн суурь үйлдэл болгон хуульчлах зайлшгүй шаардлагатай байна. Сэргээшийн төрлийн бодисыг хуульчлан тогтоохдоо мансууруулах бодистой адилтган үзээгүй атлаа ердийн эмээс ялгах эрүүгийн хариуцлагын тусгайлсан заалт байхгүй байгаа нь хамгийн том асуудал юм. Сэргээшийн төрлийн бодистой холбоотой бие даасан зүйл заалт байхгүй. Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд заасан "Хууль бусаар эм борлуулах" гэсэн ерөнхий заалтаар зүйлчлэх боломжтой ч энэ нь сэргээшийн нийгмийн хор аюул, мөнгө угаах гэмт хэргийн суурь болох шинж чанарт дүйцэхгүй байна.

Монгол Улсын хувьд сэргээшийн төрлийн бодисын хэрэглээ болон түүний далд худалдаа нь үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, санхүүгийн системийн тогтвортой байдалд заналхийлж эхэллээ.

2.2.3 Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт ба мөнгө угаах гэмт хэргийн уялдаа: FATF-ийн стандартын хэрэгжилт

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь зөвхөн бодисын хэрэглээ, худалдаатай холбоотой асуудал биш бөгөөд хууль бус санхүүгийн урсгал нь мөнгө угаах гэмт хэргийн суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Хууль бус наймаанаас бий болсон орлого нь ил тод тайлагнаагүй, татвар төлөгдөөгүй, хууль ёсны эх үүсвэргүй байдаг тул тухайн этгээд түүнийг шууд ашиглах боломжгүй. Ийм орлогыг албан ёсны санхүүгийн системд оруулахгүйгээр удаан хугацаанд хадгалах нь эрсдэлтэй, мөн бодит хөрөнгө болгон хувиргах боломж хязгаарлагдмал байдаг. Иймээс сэргээшийн бодисын наймаанд оролцогчид хууль бус орлогыг “цэвэр” мэт харагдуулах, эдийн засгийн хууль ёсны эргэлтэд шингээх зорилгоор зохион байгуулалттай мөнгө угаах схем ашиглах нь түгээмэл. Энэ утгаараа сэргээшийн бодисын хууль бус эргэлт болон мөнгө угаах гэмт хэрэг нь шалтгаан-үр дагаврын харилцаатай, харилцан хамааралтай ойлголтууд юм.

FATF нь 1989 онд Их Долоогийн (G7) санаачилгаар байгуулагдсан олон улсын бодлого тодорхойлогч байгууллага бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон сүүлийн жилүүдэд олноор хөндөгдөж буй үй олноор хөнөөх зэвсгийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дэлхий нийтээр дагаж мөрдөх стандартыг тогтоодог. FATF нь хууль тогтоох байгууллага биш боловч түүний боловсруулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг, дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт "International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation" буюу 40 зөвлөмж нь олон улсын “зөөлөн эрх зүй” (soft law)-ийн шинжтэй атлаа бодит нөлөө бүхий стандарт болж, улс орнуудын санхүүгийн систем, хууль тогтоомж, бодлогын шинэчлэлд чиглүүлэгч болж байна.

Монгол Улс FATF-ийн шууд гишүүн биш боловч Азийн Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн (Asia/Pacific Group on Money Laundering – APG) гишүүн орны хувьд FATF-ийн стандартыг мөрдөх, харилцан үнэлгээнд хамрагдах үүрэг хүлээдэг. APG нь FATF-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага бөгөөд гишүүн орнуудын хууль тогтоомж, хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, сайжруулах зөвлөмж гаргадаг. FATF-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

Тус Зөвлөмжид зааснаар суурь гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон:

а) тухайн оронд мөнгө угаахын суурь гэмт хэрэгт тооцогдох бүх гэмт хэргийг хэлнэ, эсвэл

б) хамгийн багадаа Зөвлөмж 3-ын шаардлагын дагуу тодорхойлсон суурь гэмт хэргийг хэлнэ.

FATF-ийн 40 зөвлөмж нь мөнгө угаах гэмт хэргийг криминализац хийхээс эхлээд санхүүгийн байгууллагын хяналт, эрсдэлийн үнэлгээ, олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө царцаах, хураах, эцсийн өмчлөгчийн ил тод байдал зэрэг өргөн хүрээг хамардаг. Эдгээр зөвлөмж нь хууль тогтоомжийн төдийгүй институцын чадавх, бодит хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх хоёр шатлалт (technical compliance ба effectiveness) шалгууртайгаар хэрэгждэг онцлогтой.

Судалгааны хүрээнд онцгой ач холбогдолтой нь FATF-ийн 3 дугаар зөвлөмж юм. Тус зөвлөмж нь улс орнууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймаанаас олсон орлогыг угаах үйлдлийг заавал бие даасан гэмт хэрэг болгон хуульчлах шаардлагыг тогтоодог. Энэ нь Венийн Конвенцын үзэл баримтлалыг үргэлжлүүлэн баталгаажуулж, мансууруулах бодисын наймааг мөнгө угаахын гол суурь гэмт хэргийн нэг хэмээн тодорхойлсон байдаг. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтээс үүсэх орлогыг нуун дарамтлах, шилжүүлэх, хувиргах үйлдлийг эрүүгийн хариуцлагад хамааруулах нь олон улсын стандартын зайлшгүй шаардлага юм.

Монгол Улс 2017 онд FATF/APG-ийн харилцан үнэлгээнд хамрагдсан бөгөөд энэ үнэлгээгээр техникийн нийцэл болон хэрэгжилтийн үр нөлөөг хамтад нь дүгнэсэн. Үнэлгээний дүнд Монгол Улсын хууль тогтоомж нь зарчмын хувьд мөнгө угаах гэмт хэргийг бие даасан зүйл болгон хуульчилсан, санхүүгийн мэдээллийн тогтолцоог бий болгосон зэрэг эерэг талуудтай ч зарим чиглэлд бүрэн нийцээгүй гэж дүгнэгдсэн. Ялангуяа эрсдэлийн үнэлгээний тогтолцоо, эцсийн өмчлөгчийн ил тод байдал, хөрөнгө хураах ажиллагааны үр нөлөө, мөнгө угаах гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн тоо хэмжээ, бодит ял шийтгэлийн хэрэгжилт зэрэгт сайжруулах шаардлагатайг онцолсон байдаг.

Сэргээшийн төрлийн бодистой холбоотой мөнгө угаах гэмт хэргийн хувьд FATF-ийн стандарт нь зөвхөн хууль тогтоомжийн түвшинд биш, харин хэрэгжилтийн бодит үр нөлөөг шаардаж байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн мөнгө угаахыг гэмт хэрэгт тооцохоос гадна тухайн төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, ял шийтгэлийн бодит статистик, хөрөнгө хураалтын үр ашиг, санхүүгийн мэдээллийн албаны шинжилгээний чадавх зэргийг бодитоор үнэлдэг. Энэ нь эрх зүйн зохицуулалтыг цаасан дээр бус, практикт хэрхэн хэрэгжиж байгааг шалгах тогтолцоо юм.

Судалгааны дүн шинжилгээнээс харахад Монгол Улс FATF-ийн стандартыг хууль тогтоомжийн түвшинд харьцангуй сайн тусгасан боловч сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шүүхээр эцэслэн шийдвэрлэх үр нөлөө нь хязгаарлагдмал хэвээр байна. Иймд FATF-ийн шаардлагыг биелүүлэх хүрээнд зөвхөн хууль шинэчлэх бус, институцын чадавх, санхүүгийн шинжилгээний аргачлал, мэдээллийн технологийн дэмжлэгийг сайжруулах шаардлагатай байна.

FATF-ийн стандарт нь мөнгө угаахтай тэмцэх олон улсын нэгдсэн шалгуурыг тогтоож, мансуурал болон сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтээс үүсэх санхүүгийн урсгалыг таслан зогсоох бодлогын чиглэлийг тодорхойлж байна. Монгол Улсын хувьд эдгээр стандартыг мөрдөх нь олон улсын санхүүгийн тогтолцоонд итгэлцлийг хадгалах, саарал жагсаалт зэрэг эрсдэлээс сэргийлэх, мөн дотоодын гэмт хэргийн эдийн засгийн суурийг бууруулах стратегийн ач холбогдолтой юм.

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (FATF)-аас мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт (Predicate offences) зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус наймаа, хуурамч бүтээгдэхүүний эргэлт болон байгаль орчны эсрэг гэмт хэргүүдийг албан ёсоор багтаадаг. Сэргээшийн төрлийн бодис буюу анаболик стероид, пептид дааврын далд худалдаа нь өнөөдөр спортын хүрээнээс хальж, Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (INTERPOL)-ын тодорхойлсноор 'бага эрсдэл — өндөр ашиг'-тай, зохион байгуулалттай далд эдийн засгийн бие даасан салбар болон хувирсан байна.

Сэргээшийн төрлийн бодисыг хууль бус сувгаар (онлайн захиалга, фитнес клубийн далд сүлжээ гэх мэт) худалдаж буй этгээдүүд татвар бүртгэлээс гадуур, бэлэн болон цахим хэтэвч ашиглан "бохир орлого" цуглуулдаг. Энэхүү хууль бус орлогоо хууль ёсны санхүүгийн системд оруулах, хууль ёсны бизнес (жишээлбэл, спорт нэмэлт бүтээгдэхүүний дэлгүүр, фитнес төв, хувийн зөвлөх үйлчилгээ) рүү хөрөнгө оруулалт хийх замаар эх үүсвэрийг нь халхавчлах зайлшгүй шаардлага тэдэнд үүсдэг. Энэхүү үйлдэл нь өөрөө Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийн шинжийг бүрэн хангаж байна. Тиймээс сэргээшийн хууль бус эргэлтийг мөнгө угаах гэмт хэргээс салган үзэх боломжгүй бөгөөд FATF-ийн стандартад нийцүүлэн, түүнийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тооцож, санхүүгийн урсгалыг нь хянах нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахад онцгой ач холбогдолтой юм.

Дүгнэлт: Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон түүнээс үүсэх мөнгө угаах гэмт хэрэг нь үндэсний хил хязгаараар хязгаарлагдахгүй, зохион байгуулалттай, транснациональ шинжтэй байдаг. Иймд уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа, нэгдсэн эрх зүйн стандарт, гэрээний үүрэг онцгой ач холбогдолтой. Монгол Улс НҮБ-ын конвенцууд болон Дэлхийн допингийн эсрэг агентлагаас гаргасан аливаа дүрэм, журмыг дотоод хууль тогтоомждоо мөрдөхөөр үүрэг хүлээж үндэсний хууль тогтоомждоо тодорхой хэмжээгээр тусгасан байна. Гэвч хууль тогтоомжид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодист хамаардаггүй сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг зохицуулж хариуцлага оногдуулах эрх зүйн тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлийн “эм, эмийн түүний эд” гэх зохицуулалтад сэргээшийн төрлийн бодис хамаарахааргүй байна. Зөрчлийн тухай хуульд зөвхөн эмчийн зүгээс тамирчин болон спортоор хичээллэж байгаа иргэнд эмчилгээний бус зорилгоор Дэлхийн допингийн эсрэг код, олон улсын стандартад хориглосон жагсаалтад орсон эмийг санал болгосон, дэмжиж сурталчилсан, зарж борлуулсан тохиолдолд торгох шийтгэл ногдуулахаар заасан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд Дэлхийн допингийн эсрэг код, олон улсын стандартад хориглосон жагсаалтад орсон эмийг тамирчин болон спортоор хичээллэж байгаа иргэнд эмчилгээний бус зорилгоор санал болгох, дэмжин сурталчлах, зарж борлуулахыг хориглохоор зохицуулсан. Харин

иргэн хүн сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой үйлдэл хийхэд хориглосон, хариуцлага оногдуулсан зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын хувьд сэргээшийн төрлийн ихэнх бодис “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис”-ын ангилалд багтдаггүй атлаа Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.14 дэх хэсэгт заасан “эм, эмийн түүхий эд”-ийн ерөнхий зохицуулалтад бүрэн хамаарч чадахгүй байна. Сэргээшийн төрлийн бодисын хориглосон зохицуулалтад зөвхөн “тамирчин”, “эмч” гэсэн явцуу хүрээнд Зөрчлийн тухай хуулиар зохицуулж байгаа нь иргэд хоорондын хууль бус худалдаа, түүгээр дамжсан мөнгө угаах үйлдэлд хариуцлага хүлээлгэх боломжгүй болж байна.

Фитнесээр хичээллэдэг жирийн иргэд, сонирхогчид болон тэдэнд сэргээшийн төрлийн бодис нийлүүлж буй худалдаачдын үйлдэл нь спортын ёс зүйн зөрчил биш, харин нийгмийн эрүүл мэндэд хортой бизнес болоод байна. Эдгээр этгээдүүд спортын холбоонд харьяалагддаггүй тул Зөрчлийн хуулийн тухайн заалтаар шийтгүүлэхгүй үлдэх эрсдэлтэй.

Сэргээшийн төрлийн бодисын худалдаа нь Эрүүгийн хуулиар "гэмт хэрэг" гэж тодорхойлогдоогүй байгаа тохиолдолд түүнээс олсон ашгийг "гэмт хэргийн замаар олсон орлого" гэж үзэх боломжгүй болно. Үр дүнд нь сэргээшийн төрлийн бодис зардаг бүлэглэл олсон их хэмжээний ашгаа санхүүгийн системээр дамжуулан хууль ёсны болгож байхад хууль хяналтын байгууллага түүнийг нь царцаах, хураах эрх зүйн чадамжгүй болж байна.

Сэргээшийн төрлийн бодисын асуудал зөвхөн тамирчин, эмчийн хүрээнд, Зөрчлийн тухай хуулиар 'торгоод өнгөрөх' төдий зохицуулагдаж байгаа нь нийгэмд, ялангуяа залуучуудын дунд фитнес, бодибилдингийн нэр дор цэцэглэж буй сэргээшийн төрлийн бодисын далд наймааг хязгаарлаж чадахгүй байна. Гэмт хэрэгт тооцогддоггүй хууль бус бизнесээс олж буй асар их ашиг нь мөнгө угаах гэмт хэргийн үндэс суурь болж байгаа ч, урьдал гэмт хэрэг нь тодорхойгүй гэх шалтгаанаар хуулийн хариуцлагын гадна үлдэж, үндэсний аюулгүй байдал болон иргэдийн эрүүл мэндэд бодит аюул учруулж байна.

2.3 Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, түүний санхүүгийн урсгалыг FATF-ийн аргачлалаар үнэлэх нь

Монгол Улс дахь сэргээшийн төрлийн бодисын далд эргэлт болон түүнийг дагасан санхүүгийн урсгалыг олон улсын жишигт нийцүүлэн үнэлэхийн тулд FATF-аас гаргасан "Эрсдэлийн суурьт хандлагын удирдамж" (Risk-Based Approach Guidance)-ийг ашиглан дүн шинжилгээ хийлээ. FATF-ийн аргачлалаар аливаа салбарын мөнгө угаах эрсдэлийг (1) Аюул занал, (2) Эмзэг байдал, (3) Хор уршиг гэсэн гурван тулгуурт элементээр тодорхойлдог бөгөөд тэдгээрийг криминологийн шинжлэх ухааны "Боломжийн онол" (Routine Activity Theory)-ын бүтэцтэй уялдуулан дараах байдлаар ангилан үзэж байна.

1. Аюул занал (Threat): Сэргээшийн төрлийн бодисын далд худалдаа ба санхүүгийн урсгал FATF-ийн аргачлалаар "Аюул занал" гэдэгт мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж буй анхдагч орчин, хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагааг ойлгодог. Энэ нь Боломжийн онолын "Сэдэл бүхий гэмт этгээд" (Motivated offender)-тэй шууд уялдана.

Манай улсад сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар импортлон оруулж ирдэг, цахим орчны хаалттай сувгууд болон фитнес клубийн далд сүлжээг ашиглан борлуулж

буй этгээдүүд нь санхүүгийн "Аюул занал"-ыг бий болгож байна. Тэдгээр этгээдүүд борлуулалтын орлогоо татварын болон санхүүгийн хяналтын системээс гадуур, бэлэн мөнгөөр эсвэл гуравдагч этгээдийн нэр дээрх банкны данс, цахим хэтэвч ашиглан цуглуулж байна. Зорилтот бүлгийн ярилцлагын дүн шинжилгээгээр оролцогчдын дийлэнх нь тухайн бодисыг хяналтгүй цахим захууд болон танил талын далд сүлжээгээр дамжуулан авдаг гэсэн нь энэхүү "Аюул занал" бодитоор оршин байгааг баталж байна.

2. Эмзэг байдал (Vulnerability): Эрх зүйн зохицуулалтын сул орон зай ба хяналтын сул тал FATF-ийн аргачлалаар "Эмзэг байдал" гэдэг нь аюул занал хэрэгжих боломжийг олгож буй хууль тогтоомж, хяналтын тогтолцооны сул талыг хэлнэ. Энэ нь Боломжийн онолын "Харгалзагч байхгүй байх" (Absence of a capable guardian) гэсэн элементтэй дүйцдэг.

Өнөөгийн дотоодын эрх зүйн орчинд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар сэргээшийн төрлийн бодисыг борлуулж, түүнээс ашиг олж буй "энгийн иргэн" эсвэл "дилер"-т хүлээлгэх тусгайлсан эрүүгийн хариуцлага байхгүй байна. Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт нь зөвхөн "эмч, тамирчин" гэсэн явцуу субъектэд чиглэсэн байдаг нь хууль бус наймаа эрхлэгчдэд том давуу тал олгодог. Түүнчлэн, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилт болон спортын холбоодын зүгээс тавих практик хяналт сул байгаа нь эрх зүйн болон практик хяналтын томоохон цоорхой (Vulnerability) юм. Энэхүү харгалзах, хянах механизм байхгүй нөхцөл байдал нь гэмт этгээдүүдэд ял шийтгэл хүлээх эрсдэлгүйгээр хууль бус үйл ажиллагаагаа явуулах таатай "Боломж"-ийг олгож байна.

3. Хор уршиг (Consequence): Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө FATF-ийн аргачлалаар "Хор уршиг" гэдэг нь аюул занал болон эмзэг байдал хоёр нэгдсэнээр нийгэм, эдийн засаг, санхүүгийн системд учруулж буй хохирлыг хэлнэ. Энэ нь Боломжийн онолын "Тохиромжтой бай" (Suitable target)-д учруулж буй хохирол юм.

Дээрх хоёр нөхцөл бүрдсэнээр үүсэж буй хор уршиг нь маш өндөр байна. Нэгдүгээрт, иргэдийн (ялангуяа фитнесээр хичээллэгч залуучуудын) амь нас, эрүүл мэндэд нөхөж баршгүй хохирол учирч байна. Хоёрдугаарт, сэргээшийн хууль бус худалдаанаас олж буй их хэмжээний татваргүй, далд мөнгө нь хууль ёсны санхүүгийн системд чөлөөтэй нэвтэрч, спорт клубийн хөрөнгө оруулалт эсвэл спорт нэмэлт бүтээгдэхүүний бизнесээр халхавчлагдан угаагдаж байна. Энэ нь далд эдийн засгийг тэлэх, санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулах, улмаар олон улсын түвшинд Монгол Улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны үнэлгээг бууруулах ноцтой хор уршигтай юм.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Судалгааны ажлын онол-арга зүйн хандлага ба дизайн

Судалгааны ажлын үндсэн зорилго болох мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийн жишээн дээр боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход шинжлэх ухааны арга зүйн зөв хандлага, онолын суурийг сонгох нь үр дүнгийн үнэн зөв байдлыг хангах үндэс болно. Сэргээшийн төрлийн бодисын далд эргэлт, түүнийг дагасан санхүүгийн хууль бус урсгал болон мөнгө угаах эрсдэл нь нууцлагдмал, зохион байгуулалтын шинжтэй тул тэдгээрийг тоон үзүүлэлтээр шууд хэмжих боломж хязгаарлагдмал юм. Тиймээс тухайн үзэгдлийн мөн чанар, эрх зүйн хэм хэмжээний практик хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн судлах зорилгоор энэхүү судалгаанд Чанарын судалгааны хандлагыг (Qualitative Research Design) баримталсан.

Хууль зүйн судалгааны арга зүйн үүднээс эрх зүйн хэм хэмжээ болон практик хэрэглээний зөрүүг гаргахын тулд онол-практикийн холмог логик хандлагыг баримталсан. Нэг талаас олон улсын стандарт, конвенциос дотоодын хууль тогтоомжийн зохицуулалт руу шилжих үйл явцыг Дедуктив арга (Deductive approach)-аар шинжилсэн бол нөгөө талаас практик кэйс болон зорилтот бүлгийн ярилцлагын үр дүнгээс нэгдсэн дүгнэлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналруу шилжих үйл явцыг Индуктив арга (Inductive approach)-аар тодорхойлсон болно.

Энэхүү судалгааны ажлын онолын түвшинд хууль зүйн болон криминологийн шинжлэх ухааны суурь үзэл баримтлал болох М.Фелсон, Л.Кохен нарын боловсруулсан Боломжийн онол (Routine Activity Theory)-ыг гол арга зүй болгон ашиглав. Тус онолын үүднээс эрх зүйн зохицуулалтын дутагдалтай байдал болон практик хяналтын сул талууд нь гэмт этгээдүүдэд сэргээшийн төрлийн бодис борлуулах, улмаар түүгээр дамжуулан бохир мөнгө угаах “таатай боломж”-ийг хэрхэн бүрдүүлж байгааг баталгаажуулахыг зорилоо. Мөн эрх зүйн харьцуулсан шинжилгээний аргыг ашиглан олон улсын стандарт (FATF, WADA) болон гадаад улс орнуудын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг дотоодын хууль тогтоомжтой харьцуулан шинжилсэн болно. Судалгааны арга зүйн хүрээнд Боломжийн онолыг сэргээшийн төрлийн бодисын далд зах зээл болон мөнгө угаах схемтэй дараах гурван элементийн харилцан хамаарлын дагуу уялдуулан арга зүйн хэрэглүүр болгон ашигласан. Үүнд:

1. Сэдэл бүхий гэмт хэрэг (Motivated offender): Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь дэлхий даяар болон дотоодын зах зээлд асар өндөр ашиг дагуулдаг учраас далд бизнес эрхлэгчдийг татах санхүүгийн хүчтэй сэдэл болдог. Борлуулагчид цахим орчны хаалттай сувгуудыг ашиглан хуулийн хяналтаас гадуур үйл ажиллагаа явуулж, амар хялбар аргаар ашиг олох сэдэл үргэлж өндөр байна.

2. Тохиромжтой бай буюу объект (Suitable target): Сэргээшийн төрлийн бодис (анаболик стероид, гормон гэх мэт) болон түүнийг борлуулж олсон их хэмжээний далд орлого нь өөрөө гэмт хэргийн "тохиромжтой бай" болж байна. Фитнесээр хичээллэгч залуучуудын дунд эрэлт хэрэгцээ өндөр, бодис нь овор хэмжээ багатай, тээвэрлэхэд амархан, борлуулалтын санхүүгийн урсгалыг хувь хүний дансаар дамжуулан хялбархан

удирдах боломжтой байгаа нь тус объектыг улам эмзэг, гэмт хэрэгт өртөх магадлалыг өндөр болгож байна.

3.Хамгаалалт, хяналтын дутагдалтай байдал (Absence of capable guardian): Монгол Улсын хувьд эрх зүйн хамгаалалт дутагдалтай. Холбогдох хууль тогтоомжуудаар сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг хориглосон нарийвчилсан зохицуулалт хуульчлагдаагүйгээс гадна уг үйлдлийг суурь гэмт хэрэгт нарийвчлан хамааруулдаггүй. Мөн спорт холбоод, фитнес төвийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээнд тавих хяналт сул байгаа нь гэмт этгээдүүдэд бохир мөнгөө хууль ёсны орлого мэтээр халхавчлан угаах "эрх зүйн болон практикийн бүрэн боломж"-ийг олгож байна.

Иймд Боломжийн онол нь сэргээшийн хууль бус эргэлт, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд гэмт этгээдийн хувийн сэдлийг өөрчлөх гэж оролдохоос илүүтэйгээр, тэдэнд олгож буй "эрх зүйн сул тал" болон "санхүүгийн хяналтын сул байдал" гэсэн боломжуудыг (opportunities) хууль тогтоомжийн хүрээнд хаах, хяналтын механизмыг чангаруулах замаар гэмт хэргийг таслан зогсоох зөвлөмж боловсруулах онол-арга зүйн гол үндэслэл болж байна.

Судалгааны ажлын хүрээнд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, түүнээс үүдэлтэй мөнгө угаах эрсдэлийг үнэлэхдээ FATF-аас гаргасан Эрсдэлийн суурьт хандлагын удирдамж (Risk-Based Approach Guidance)-ийг ашигласан. FATF-ийн аргачлалаар аливаа салбарын мөнгө угаах эрсдэлийг Аюул занал (Threat), Эмзэг байдал (Vulnerability), Хор уршиг (Consequence) гэсэн гурван тулгуурт элементээр тодорхойлдог бөгөөд энэхүү гурван элементийг криминологийн "Боломжийн онол"-ын бүтэцтэй уялдуулан дипломын Үндсэн бүлэгт тодорхой кэйс болон өгөгдлүүд дээр задалж, дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгааны үйл явцыг системтэй, үе шаттайгаар гүйцэтгэхийн тулд судалгааны оролт, боловсруулалт, шинжилгээ болон гаралт гэсэн дөрвөн үндсэн үе шатыг дамжин гүйцэтгэсэн болно.

3.2 Судалгааны тусгайлсан аргууд

Сонгосон сэдвийн хүрээнд дараах хууль зүйн болон нийгмийн шинжлэх ухааны тусгайлсан аргуудыг хослуулан хэрэглэсэн болно. Үүнд:

1.*Баримт бичиг шинжлэх арга (Documentary Analysis)*: Энэхүү аргын хүрээнд олон улсын эрх зүйн актууд болох НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисуудын тухай конвенц, 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц, Дэлхийн допингийн эсрэг агентлаг (WADA)-ийн Дүрэм болон Хориглосон жагсаалт, FATF-ийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийг шинжлэн судлав. Мөн дотоодын эрх зүйн хүрээнд Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг системчлэн судалж, эрх зүйн сул орон зайг (legal gap) илрүүлэх үндэслэл болгосон.

2.*Кейс шинжилгээний арга (Case Study Method)*: Хуулийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж буй байдлыг тодорхойлохын тулд шүүхийн шийдвэрийн албан ёсны цахим сан (www.shuukh.mn)-аас 2022-2026 оны эхний болон 2 дугаар улирлын байдлаар

Эрүүгийн хуулийн 18.5, 18.6 болон 20.14 дүгээр заалтуудаар шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн шүүхийн тогтоолуудад дүн шинжилгээ хийсэн.

3. *Харьцуулсан эрх зүйн шинжилгээний арга (Comparative Legal Method)*: Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, түүнийг дагасан санхүүгийн урсгалтай тэмцэх олон улсын туршлагыг тодорхойлохын тулд гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан. Түүнчлэн АНУ, Герман, Итали, Франц зэрэг сэргээшийн төрлийн бодисын эргэлтийг эрүүгийн хуулиар нарийвчлан зохицуулсан орнуудын хууль тогтоомжийн загварыг харьцуулан шинжлэхэд энэхүү аргыг ашиглав.

4. *Чанарын судалгааны арга*: Сэргээшийн төрлийн бодисын хаалттай, далд зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, олдоц, нийлүүлэлтийн суваг болон санхүүгийн урсгалын онцлогийг анхдагч эх сурвалжаас тодруулах зорилгоор ярилцлагын аргыг ашигласан. Сэргээшийн төрлийн бодисын далд эргэлт, түүнийг дагасан санхүүгийн урсгал нь нууцлагдмал, тоон үзүүлэлтээр шууд хэмжихэд хүндрэлтэй шинж чанартай тул зорилтот бүлгийн бодит ойлголт, туршлагад тулгуурлан шинжилгээ хийх шаардлагатай болсон. Оролцогчдоос урьдчилан бэлдсэн үндсэн асуултуудыг асуухаас гадна ярилцлагын явцад оролцогчийн хариултаас хамааран уян хатан байдлаар нэмэлт асуулт асуух, асуудлыг гүнзгийрүүлэн асууж ойлгохыг хичээсэн. Судалгааг энгийн иргэдээс гадна тамирчид, фитнес, бодибилдингээр хичээллэдэг тамирчид, сонирхогчид болон фитнес заалны дасгалжуулагч багш зэрэг зорилтот бүлгээс авсан.

3.3 Судалгааны ёс зүй ба хязгаарлалт

Судалгааны сэдэв нь эрүүгийн эрх зүйн зохицуулалт, мөнгө угаах эрсдэл болон сэргээшийн төрлийн бодисын эргэлт зэрэг эмзэг асуудлуудыг хөндөж байгаа тул судалгааны ёс зүйн хэм хэмжээг баримталсан. Ярилцлагад оролцогч бүрд судалгааны зорилго, ач холбогдлыг урьдчилан танилцуулж, тэдний сайн дурын үндсэн дээр оролцох зөвшөөрлийг (Informed Consent) авсан. Оролцогчдын аюулгүй байдал, хувийн нууцыг хамгаалах үүднээс тэдний нэр, албан тушаал, харьяалагдах спорт клубийн нэр зэрэг хувийн мэдээллийг бүрэн нууцалж, судалгааны бичвэрт "Ярилцагч-1", "Ярилцагч-2", ..., "Ярилцагч-10" гэсэн кодоор орлуулан ашигласан болно. Цуглуулсан мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор, магистрын дипломын хүрээнд ашиглахаа илэрхийлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан.

Энэхүү судалгааг хийх явцад манай улсад сэргээшийн төрлийн бодисын далд эргэлт, түүний хэрэглээг бүртгэсэн нэгдсэн статистик мэдээлэл хомс, Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлээр дагнаж шийдвэрлэгдсэн шүүхийн практик кэйс цөөн, мөн мөнгө угаах гэмт хэрэгтэй уялдуулан зүйлчилсэн практик хараахан тогтож амжаагүй байгаа зэрэг нь судалгааны явцад тулгарсан гол хязгаарлалт байв. Гэвч энэхүү хязгаарлагдмал байдлыг чанарын судалгааны арга (гүнзгийрүүлсэн ярилцлага) болон олон улсын харьцуулсан эрх зүйн шинжилгээний үр дүнгээр нөхөж, дүгнэлтийг бодитой гаргахыг зорив.

БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Дүн шинжилгээ

4.1.1 Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Судалгааны сэдвийн хүрээнд практикт сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж байгаа эсэх талаар судлахаар шүүхийн шийдвэрийн сан(shuukh.mn)-гаас дараах 3 ангиллын хүрээнд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолуудыг шүүж дүн шинжилгээ хийлээ.

Нэг. Шүүхийн шийдвэрийн сан (shuukh.mn)-гаас 2022-2026 оны 2 дугаар улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 20.14 “Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах” заалтаар шийдвэрлэгдсэн хэргүүдийг судалж дүн шинжилгээ хийсэн. Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой нарийвчилсан зохицуулалт Эрүүгийн хуульд байхгүй бөгөөд практикт Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.14 дэх заалтаар зүйлчлэхээс өөр сонголт байхгүй байгаа тул дээрх зохицуулалтын хүрээнд шүүхийн шийдвэр судалсан. Шүүхийн шийдвэрийн сангаас шүүж үзэхэд 2002-2026 оны 2 дугаар улирал (2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл)-ын байдлаар Эрүүгийн хуулийн 20.14 заалтаар шийдвэрлэгдсэн нийт 29 анхан шатны шүүхийн тогтоол байсан (Хүснэгт 5). Нийт 29 шүүхийн тогтоолоос сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг байгаа эсэхийг шүүж үзсэн.

Хүснэгт 5. Эрүүгийн хуулийн 20.14 заалтаар 2022-2026 оны 2 дугаар улирлын байдлаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо

№	Он	Эрүүгийн хуулийн 20.14 дэх заалтаар шийдвэрлэгдсэн хэргийн тоо
1	2022	7
2	2023	3
3	2024	5
4	2025	8
5	2026 оны 2 дугаар улирал	6
Нийт		29

Эх сурвалж: shuukh.mn

Шүүхээр шийдвэрлэгдсэн 29 эрүүгийн хэрэгт шинжилгээ хийхэд дараах нийтлэг шинж агуулагдаж байна. Үүнд:

Монгол Улсын эмийн бүртгэлд огт бүртгэгдээгүй эсвэл бүртгэлийн хугацаа дууссан эмийг хилээр нэвтрүүлэх, худалдан борлуулсан. Хятад болон бусад гадаад хэл дээрх хаяг шошготой, найрлага болон хэрэглэх заавар нь тодорхойгүй эмүүд (ялангуяа тосон түрхлэг, үе мөчний эмүүд) дийлэнх хувийг эзэлж байна. Эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөл авалгүйгээр эм худалдан борлуулсан.

Шүүхийн шийдвэрийн сан (shuukh.mn)-гаас 2022-2026 оны 2 дугаар улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 20.14 “Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах” заалтаар шийдвэрлэгдсэн хэргүүдийг судалж дүн шинжилгээ хийхэд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой эрүүгийн хэрэг 1 хэрэг шийдвэрлэгдсэн байна.

Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлээр шийдвэрлэгдсэн шүүхийн кейс: Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн шийтгэх тогтоолоор иргэн Х нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эмийг зохих зөвшөөрөлгүйгээр импортолсон, бусдад худалдсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож 5,400,000 төгрөгийн торгох ялаар шийтгэгдсэн. (Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2026/ШЦТ/920 дугаар шийтгэх тогтоол)

Хориглосон бодисын ангилал: Хэдийгээр "эм" гэсэн ерөнхий нэршлээр явж байгаа ч Олон улсын Допингийн хяналтын ажилтны болон Допингийн эсрэг байгууллагын дүгнэлтээр уг бодисууд нь (Stanozon, Primomed 100, AICAR) ДДЭА (WADA)-ын хориглосон жагсаалтын **S1 бүлгийн Андрогены Анаболик Стероидууд** болон **S4 бүлгийн Бодисын солилцооны модуляторт** багтсан болохыг албан ёсоор тогтоосон байна.

Санхүүгийн урсгал ба мөнгө угаах эрсдлийн шинжилгээ: Энэ кэйс дээр мөнгө угаах үйлдэлтэй төстэй, санхүүгийн мөрөө нуухыг оролдсон маш тодорхой **арга хэлбэрүүд** харагдаж байна:

•**Гуравдагч этгээдийн данс ашиглах** : Шүүгдэгч хууль хууль бус борлуулалтын мөнгөө өөрийн данснаас гадна **өөрийн үеэл болох иргэн Б-гийн Хаан банкны дансыг** ашиглан авч байсан. Иргэн Б нь "ямар учиртай мөнгө болохыг мэдээгүй" гэж мэдүүлсэн бөгөөд энэ нь зохион байгуулалттай гэмт хэрэгт тус бусдын дансыг далд зорилгоор ашигладаг түгээмэл хэлбэр юм.

•**Гүйлгээний утгыг хуурамчаар үүсгэх**: Үеэл Б-гийн данснаас мөнгийг буцааж татахдаа гүйлгээний утгыг **“Моторын үнэ”** гэж нууцлан бичиж шилжүүлсэн байна. Энэ нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанаас зайлсхийх гэсэн шууд оролдлого мөн.

•**Олон улсын мөнгөн урсгал**: Сэргээшийн төрлийн бодисыг бодисыг Казахстан Улсаас фэйсбүүк хаяг болон утсаар холбогдон захиалж, төлбөрийг нь зуучлагч нараар дамжуулан Казахстан руу шилжүүлдэг болох нь гэрчүүдийн мэдүүлгээр нотлогдсон байна.

Энэхүү шийтгэх тогтоолыг судлахад практикт тулгарч буй дараах эрх зүйн зөрчил асуудал байна. Үүнд:

1. **Ялын бодлогын сул байдал**: Хохирогч тамирчид (Улсын наадам, аймагт барилдах бөхчүүд, шигшээ багийнхан) олон сая төгрөгөөр (нэг гүйлгээ нь 21 сая, нөгөө нь 4.6 сая) сэргээшийн төрлийн бодисыг худалдаж авсан байхад шүүгдэгчид 5,400,000 төгрөгийн торгох ял оноосон байна. Энэ нь хууль бус орлогоосоо хэд дахин бага ял

шийтгэл байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хөшүүрэг болж чадаж байгаа эсэхэд хууль зүйн дүгнэлт хийх шаардлагатайг харуулж байна.

2.Мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлээгүй асуудал: Хууль бус орлого гэдгийг нь мэдсээр байж гүйлгээний утгыг "Моторын үнэ" гэж өөрчлөн, бусдын дансаар дамжуулан хууль ёсны мэт харагдуулах үйлдэл хийгдсэн байхад үүнийг Эрүүгийн хуулийн 18.6 (Мөнгө угаах) дугаар зүйлээр давхар зүйлчилж мөрдөөгүй орхисон уу, эсвэл нотлогдоогүй юу гэдэг нь практик дахь том асуудал юм.

Хоёр. Шүүхийн шийдвэрийн сан (shuukh.mn)-гаас 2022-2026 оны эхний улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 18.6 “Мөнгө угаах” заалтаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргүүдийг судалж, Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.14 суурь гэмт хэрэг болсон хэрэг шийдвэрлэгдсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн.

2022-2026 оны эхний улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 18.6 “Мөнгө угаах” заалтаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр нийт 243 хэрэг шийдвэрлэгдсэн байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Эрүүгийн хуулийн 18.6 заалтаар 2022-2026 оны эхний улирлын байдлаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо

№	Он	Шийдвэрлэсэн хэргийн тоо
1	2022	65
2	2023	70
3	2024	54
4	2025	47
5	2026 оны эхний улирал	7
Нийт		243

Эх сурвалж: shuukh.mn

Нийт 243 анхан шатны шүүхийн тогтоолыг шүүж үзэхэд Эрүүгийн хуулийн 20.14 дугаар зүйлд заасан гэмт хэрэг суурь гэмт хэрэг болсон Мөнгө угаах гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдээгүй байна.

Гурав. Шүүхийн шийдвэрийн сан (shuukh.mn)-гаас 2022-2026 оны эхний улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх заалтаар шийдвэрлэгдсэн хэргүүдийг судалж дүн шинжилгээ хийсэн. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой эрүүгийн хэрэг 2022-2026 оны эхний улирлын байдлаар шүүхээр шийдвэрлэгдээгүй байсан учраас тус харилцааг Эрүүгийн хуулийн 18.5 дугаар заалтаар зүйлчилсэн байж болзошгүй гэж үзэж судалгаа хийсэн.

2022-2026 оны эхний улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх заалтаар шийдвэрлэгдсэн нийт 51 анхан шатны шүүхийн тогтоолыг судалж дүн шинжилгээ хийхэд сэргээшийн төрлийн бодистой холбоотой хэрэг шийдвэрлэгдээгүй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Эрүүгийн хуулийн 18.5 заалтаар 2022-2026 оны эхний улирлын байдлаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо

№	Он	Шийдвэрлэсэн хэргийн тоо
1	2022	4
2	2023	21
3	2024	9
4	2025	14
5	2026 оны эхний улирал	3
Нийт		51

Эх

сурвалж: shuukh.mn

Дүгнэлт: Шүүхийн шийдвэрийн сан (shuukh.mn)-гаас 2022-2026 оны эхний улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 18.5, 18.6 20.14 дэх заалтуудаар анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн тогтоолуудыг судлахад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой 1 хэрэг 2026 оны 05 дугаар сард шийдвэрлэгдсэн байна. Монгол Улсын шүүхийн практикт сэргээшийн төрлийн бодистой холбоотой санхүүгийн урсгалыг мөнгө угаах гэмт хэрэгтэй уялдуулан шийдвэрлэсэн шүүхийн эцсийн шийдвэр байхгүй байгаа нь шүүх, прокурорын байгууллага бодит дата баримт муутайдаа биш, хуулийн зүйлчлэлийн оновчгүй байдалтай холбоотой юм.

4.1.2 Ярилцлагын судалгааны үр дүн

Судлаач нь 13 асуулт бүхий ярилцлагын удирдамж боловсруулж ярилцлагын судалгаа авсан. Ярилцлагад 5 тамирчин, 3 фитнесээр хичээллэгч, 3 иргэн нийт 10 хүн оролцсон. Ярилцагч нар нь овог, нэр, албан тушаалаа нууцалсан учир дугаарлаж тэмдэглэсэн (Хүснэгт 8-12).

Хүснэгт 8. Ярилцлагын тэмдэглэл 1,2

№	Асуулт	Ярилцагч 1 (Иргэн)	Ярилцагч 2 (Иргэн)
1	Та сэргээшийн төрлийн бодис гэж мэдэх үү?	Мэднэ.	Мэдэхгүй.
2	Та сэргээшийн төрлийн бодис хэрэглэж байсан уу? Хэрэглэж байсан бол ямар төрлийн бодисыг хэдэн удаа хэрэглэж байсан бэ?	Хэрэглэж байгаагүй.	Хэрэглэж байгаагүй.
3	Та сэргээшийн төрлийн бодисыг хаанаас олж авч байсан бэ? Сэргээшийн төрлийн бодисын	Янз бүрийн сувгаар орж ирдэг гэж сонсож байсан. Ихэвчлэн бодибилдингээр	Мэдэхгүй.

	олдоц элбэг байдаг уу? Хаана хаанаас олж авах боломжтой вэ?	хичээллэдэг ямар ч хүнээс асуусан олоод өгөх байх. Бодибилдингийн тамирчид болон багш нар зардаг.	
4	Сэргээшийн төрлийн бодисыг биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэхүү?	Мэднэ.	Сайн мэдэхгүй.
5	Сэргээшийн төрлийн бодисыг хэрэглээд таны биед сөрөг нөлөө үзүүлж байсан уу?	Хэрэглэж байгаагүй.	Хэрэглэж байгаагүй.
6	Таны эргэн тойронд сэргээшийн төрлийн бодисыг хааяа болон тогтмол хэрэглэдэг хүн байдаг уу? Хаанаас, хэрхэн олж авдаг талаар мэдэх үү?	Бодибилдингээр хичээллэгч нараас байгаа.	Байхгүй.
7	Сэргээшийн төрлийн бодис хэрэглэдэг шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?	Ашиг сонирхол.	Хэрэглэдэггүй.
8	Та сэргээшийн төрлийн бодис бусдад худалдаж байсан уу? Тийм бол ямар давтамжтайгаар хэрхэн худалдаж байсан бэ?	Үгүй.	Үгүй.
9	Сэргээшийн төрлийн бодисыг хувь хүн, эмийн сангаар чөлөөтэй худалдаалж байгаа шалтгааныг та юу гэж бодож байна вэ?	Хүмүүс хэт чөлөөтэй хэрэглэж байгаа учраас худалдаалж байгаа.	Ашиг сонирхол, Хувиа бодсон хэрэг.
10	Сэргээшийн төрлийн бодисыг хориглосон эрх зүйн зохицуулалт хангалттай гэж та бодож байна уу?	Маш сул.	Хангалтгүй.
11	Хууль тогтоомж хангалтгүй байгаагаас ямар асуудал үүсдэг вэ?	Нийгэмд сөрөг нөлөөтэй.	Эрүүл мэндэд эрсдэлтэй байх.

12	Хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай эсэх талаар таны бодол?	Сайжруулбал маш хэрэгтэй байх.	Сайжруулахгүй бол ямар нэгэн эрсдэлт зүйлс дэлгэрэх боломжтой.
13	Ярилцлагатай холбоотойгоор нэмж хэлмээр байгаа зүйл байна уу?	Төрийн бодлогоор чангалах шаардлагатай.	Байхгүй.

Хүснэгт 9. Ярилцлагын тэмдэглэл 3,4

№	Асуулт	Ярилцагч 3 (Фитнесээр хичээллэгч)	Ярилцагч 4 (Фитнесээр хичээллэгч)
1	Та сэргээшийн төрлийн бодис гэж мэдэх үү?	Мэднээ. Булчинг хурдан хөгжүүлэхэд хэрэглэдэг гэж ойлгодог.	Тийм.
2	Та сэргээшийн төрлийн бодис хэрэглэж байсан уу? Хэрэглэж байсан бол ямар төрлийн бодисыг хэдэн удаа хэрэглэж байсан бэ?	Хэрэглэж байгаагүй.	Тийм. Хэрэглэж байсан.
3	Та сэргээшийн төрлийн бодисыг хаанаас олж авч байсан бэ? Сэргээшийн төрлийн бодисын олдоц элбэг байдаг уу? Хаана хаанаас олж авах боломжтой вэ?	Сэргээшийн төрлийн бодисыг фитнесийн орчинд зарим хүмүүс танил талаараа эсвэл онлайнаар олж авдаг гэж сонсож байсан.	Найзаараа дамжуулан авч байсан.
4	Сэргээшийн төрлийн бодисыг биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэх үү?	Сөрөг нөлөөний талаар тодорхой хэмжээнд мэднэ. Гэхдээ бүгдийг нь сайн ойлгодоггүй.	Анх сайн мэддэггүй байсан.
5	Сэргээшийн төрлийн бодисыг хэрэглээд таны биед сөрөг нөлөө үзүүлж байсан уу?	Би өөрөө хэрэглэж үзээгүй.	Нойргүйдэлтэй болж уур уцаартай болсон.

6	Таны эргэн тойронд сэргээшийн төрлийн бодисыг хааяа болон тогтмол хэрэглэдэг хүн байдаг уу? Хаанаас, хэрхэн олж авдаг талаар мэдэх үү?	Миний эргэн тойрон хэрэглэдэг хүмүүс байгаа. Тэд ихэвчлэн хурдан үр дүн гаргах том булчинтай эсвэл хурдан гурах зорилгоор хэрэглэдэг юм шиг санагддаг.	Фитнесийн орчинд бараг хүн болгон л хэрэглэдэг. Фэйсбүүкээр юмуу танил талаараа дам дамаараа олж авдаг.
7	Сэргээшийн төрлийн бодис хэрэглэдэг шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?	Сайн мэдэхгүй байна.	Түргэн үр дүн хүссэн юм.
8	Та сэргээшийн төрлийн бодис бусдад худалдаж байсан уу? Тийм бол ямар давтамжтайгаар хэрхэн худалдаж байсан бэ?	Үгүй.	Үгүй.
9	Сэргээшийн төрлийн бодисыг хувь хүн, эмийн сангаар чөлөөтэй худалдаалж байгаа шалтгааныг та юу гэж бодож байна вэ?	Хүмүүс чөлөөтэй авч байгаа хяналт султай холбоотой гэж боддог.	Хэрэглэгч их байгаа болохоор л хүмүүс их зарж байгаа.
10	Сэргээшийн төрлийн бодисыг хориглосон эрх зүйн зохицуулалт хангалттай гэж та бодож байна уу?	Хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй санагддаг.	Хангалтгүй.
11	Хууль тогтоомж хангалтгүй байгаагаас ямар асуудал үүсдэг вэ?	Хуулийн зохицуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалан хүмүүст эрүүл мэндийн эрсдэл нэмэгдэнэ.	Донтох, дааврын алдагдал үүссэн.
12	Хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай эсэх талаар таны бодол?	Сайжруулах шаардлагатай гэж боддог.	Тийм.
13	Ярилцлагатай холбоотойгоор нэмж хэлмээр байгаа зүйл байна уу?	Хуулиараа хатуу зохицуулалт хэрэгтэй.	Хяналт анхааруулга чухал.

Залуучуудад зөв мэдээлэл өгөх нь чухал.

Хүснэгт 10. Ярилцлагын тэмдэглэл 5,6

№	Асуулт	Ярилцагч 5 Тамирчин	Ярилцагч 6 Тамирчин
1	Та сэргээшийн төрлийн бодис гэж мэдэх үү?	Тиймээ мэднэ. Допинг нь биеийн гүйцэтгэлийг хиймлээр нэмэгдүүлдэг, олон улсын спортод хориглосон бодис гэдгийг сайн мэднэ.	Мэднэ. Стеройдын төрлийн бодисууд гэж бодож байна.
2	Та сэргээшийн төрлийн бодис хэрэглэж байсан уу? Хэрэглэж байсан бол ямар төрлийн бодисыг хэдэн удаа хэрэглэж байсан бэ?	Огт хэрэглэж байгаагүй. Учир нь карьерт маш өндөр эрсдэлтэй.	Хэрэглэнэ гэж бодож байгаа.
3	Та сэргээшийн төрлийн бодисыг хаанаас олж авч байсан бэ? Сэргээшийн төрлийн бодисын олдоч элбэг байдаг уу? Хаана хаанаас олж авах боломжтой вэ?	Ихэвчлэн танилын хүрээ, гадаадаас нууцаар орж ирдэг гэж сонссон.	Олоход амархан байх байхаа. Бараг хүн болгон оруулж ирж зардаг. Зарим нь сайтуудаар гаднаас захиалж авдаг юм шиг байна лээ. Ориг хулхи гэж байдаг байх үнээсээ шалтгаалаад.
4	Сэргээшийн төрлийн бодисыг биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэх үү?	Сайн мэднэ. Зүрхний хэм алдагдах, элэг гэмтэх, дааврын тэнцвэр алдагдах аюултай.	Удаан хугацаанд хэрэглэвэл ярь гарах, дуу хоолой өөрчлөгдөж арьсны өнгө хар хөх болдог гэж сонсож байсан.
5	Сэргээшийн төрлийн бодисыг хэрэглээд таны биед сөрөг нөлөө үзүүлж байсан уу?	Би өөрөө хэрэглэж үзээгүй.	Хэрэглэж байгаагүй

6	Таны эргэн тойронд сэргээшийн төрлийн бодисыг хааяа болон тогтмол хэрэглэдэг хүн байдаг уу? Хаанаас, хэрхэн олж авдаг талаар мэдэх үү?	Тиймээ. Зарим тамирчид хэрэглэж байсныг сонсож байсан.	Хэрэглэдэг хүмүүс зөндөө байгаа. Зарим нь бодибилдингийн тамирчдаас, багшаас авдаг.
7	Сэргээшийн төрлийн бодис хэрэглэдэг шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?	Хурдан амжилт гаргах медаль авах дарамт нөлөөлдөг гэж бодож байна.	Хурдан өөрчлөгдөж гоё болох хүсэлдээ дийлдэж л хэрэглэдэг.
8	Та сэргээшийн төрлийн бодис бусдад худалдаж байсан уу? Тийм бол ямар давтамжтайгаар хэрхэн худалдаж байсан бэ?	Үгүй, тийм зүйлд оролцохгүй.	Худалдаалж байгаагүй.
9	Сэргээшийн төрлийн бодисыг хувь хүн, эмийн сангаар чөлөөтэй худалдаалж байгаа шалтгааныг та юу гэж бодож байна вэ?	Хяналт, шалгалт муу байгаатай холбоотой.	Ил биш далд байгаасай л гэж хүсэж байна.
10	Сэргээшийн төрлийн бодисыг хориглосон эрх зүйн зохицуулалт хангалттай гэж та бодож байна уу?	Сул, хангалтгүй	Хангалтгүй.
11	Хууль тогтоомж хангалтгүй байгаагаас ямар асуудал үүсдэг вэ?	Шудрага өрсөлдөөн алдагдаж тамирчид эрүүл мэндээрээ хохирдог.	Хүмүүс эрүүл мэндээрээ маш их хохирч байгаа. Үнэхээр хэрэглэх шаардлага үүсвэл мэрэгжлийн эмчтэй зөвлөлдөж хэрэглэх ёстой юм шиг санагддаг. Одоо бол захын заалны багш нэртэй хүмүүс дур мэдэж хүн хэрэглүүлсэнээр маш их хүмүүс эрүүл мэнд, сэтгэл зүй, гоо зүйгээрээ хохирч байгаа.
12	Хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай эсэх талаар таны бодол?	Заавал сайжруулах шаардлагатай.	Үнэхээр нэн шаардлагатай.

13	Ярилцлагатай холбоотойгоор нэмж хэлмээр байгаа зүйл байна уу?	Тогтмол шинжилгээ, хатуу шийтгэл мөн допингийн сургалт хэрэгтэй.	Допингийн төрлийн бодисын хувь хүмүүс зарахаа болих хэрэгтэй. Хил гаалийг чангатгаж хуулийн хүрээнд авах арга хэмжээгээ чангатгах хэрэгтэй
----	---	--	--

Хүснэгт 11. Ярилцлагын тэмдэглэл 7,8

№	Асуулт	Ярилцагч 7 (Тамирчин)	Ярилцагч 8 (Тамирчин)
1	Та сэргээшийн төрлийн бодис гэж мэдэх үү? Ямар бодисууд хамаардаг вэ?	Мэдэхгүй.	Би сэргээшийн төрлийн бодис гэж бараг мэдэхгүй.
2	Та сэргээшийн төрлийн бодис хэрэглэж байсан уу? Хэрэглэж байсан бол ямар төрлийн бодисыг хэдэн удаа хэрэглэж байсан бэ?	Үгүй.	Хэрэглэж байгаагүй.
3	Та сэргээшийн төрлийн бодисыг хаанаас олж авч байсан бэ? Сэргээшийн төрлийн бодисын олдоц элбэг байдаг уу? Хаана хаанаас олж авах боломжтой вэ?	Авах талаар огт бодож байгаагүй.	Тэрийг ёстой мэдэхгүй.
4	Сэргээшийн төрлийн бодисыг биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэх үү?	Мэдэхгүй байна.	Мэднэ.
5	Сэргээшийн төрлийн бодисыг хэрэглээд таны биед сөрөг нөлөө үзүүлж байсан уу?	Огт хэргээр үзээгүй болохоор мэдэхгүй байна.	Хэрэглэж байгаагүй.
6	Таны эргэн тойронд сэргээшийн төрлийн бодисыг хааяа болон тогтмол хэрэглэдэг хүн байдаг уу? Хаанаас, хэрхэн олж авдаг талаар мэдэх үү?	Байхгүй.	Мэдэхгүй тийм хүн байхгүй.

7	Сэргээшийн төрлийн бодис хэрэглэдэг шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?	Хэрэглэж байгаагүй болохоор мэдэхгүй байна.	Өөрийн үзүүлэлтийг нэмэх зорилгоор хэрэглэдэг байх8
8	Та сэргээшийн төрлийн бодис бусдад худалдаж байсан уу? Тийм бол ямар давтамжтайгаар хэрхэн худалдаж байсан бэ?	Хэрэглэж байгаагүй.	Худалдаалж байгаагүй.
9	Сэргээшийн төрлийн бодисыг хувь хүн, эмийн сангаар чөлөөтэй худалдаалж байгаа шалтгааныг та юу гэж бодож байна вэ?	Энэ бол буруу гэж бодож байна.	Буруу зүйл гэж боддог тамирчдын ирээдүйд маш хортой зүйл.
10	Сэргээшийн төрлийн бодисыг хориглосон эрх зүйн зохицуулалт хангалттай гэж та бодож байна уу?	Хангалттай байсан бол тамирчид хэрэглэхгүй шүү дээ бөхчүүд	Хангалттай бус гэж бодож байна.
11	Хууль тогтоомж хангалтгүй байгаагаас ямар асуудал үүсдэг вэ?	Замбараагүй байдал.	Хууль тогтоомж хангалттай байсан бол сэргээш гэдэг зүйл дэлгэрэхгүй байсан.
12	Хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай эсэх талаар таны бодол?	Чанга байх хэрэгтэй гэж боддог.	Ер нь бол сайжруулах хэрэгтэй дээ.
13	Ярилцлагатай холбоотойгоор нэмж хэлмээр байгаа зүйл байна уу?	Байхгүй.	Сэргээш гэдэг зүйл бол маш хортой хүний ирээдүйг үгүй хийж байгаа зүйл юм.

Хүснэгт 12. Ярилцлагын тэмдэглэл 7,8

№	Асуулт	Ярилцагч 9 (Ахлах ангийн сурагч)	Ярилцагч 10 (Фитнесийн багш)
---	--------	-------------------------------------	---------------------------------

1	Та сэргээшийн төрлийн бодис гэж мэдэх үү? Ямар бодисууд хамаардаг вэ?	Хүндийн өргөлтийн болон бодибилдингийн тамирчид хэрэглэдгийг мэднэ.	Мэднэ. Допингийн төрөлд тосон тариа, усан тариа гэж байдаг. Тосон тариа нь арай үр нөлөө ихтэй боловч сөрөг үр дагавар нь 2 дахин их байдаг.
2	Та сэргээшийн төрлийн бодис хэрэглэж байсан уу? Хэрэглэж байсан бол ямар төрлийн бодисыг хэдэн удаа хэрэглэж байсан бэ?	Үгүй	Хэрэглэж байсан.Пропнет,Мостерон гээд усан тосон тариа хэрэглэж байсан. Энэ 2 тариа нь хоёулаа 100% эр даавар юм. Энэ 2 тариа нь эмэгтэй хүний эм дааврыг зуун хувь дарангуйлчихдаг учраас булчин массыг илүү томруулж өгдөг.Ус их татна, хаван маш их үүсгэнэ. 2 жил хэрэглэсэн. Өгзгөндөө мөрөндөө хийсэн.
3	Та сэргээшийн төрлийн бодисыг хаанаас олж авч байсан бэ? Сэргээшийн төрлийн бодисын олдоц элбэг байдаг уу? Хаана хаанаас олж авах боломжтой вэ?	Интернэтээр амархан олдоно гэж бодож байна. Фэйсбүүкээр зарууд явж байхыг харсан.	Олдоц маш их. Албан ёсны зардаг газар байхгүй ч хүн болгоноос шахуу авч болдог. Гэхдээ баталгаатай болон баталгаатай бус гэж 2 төрөл байдаг.Тэрийг яаж мэдэх вэ гэвэл бие дээрээ хэрэглэж байж л мэддэг. Фитнесийн тэмцээнд орж байсан нэр хүндтэй хүн болгон зарж байгаа. Хэн зарахаасаа шалтгаалж өөр өөр үнэтэй. 230.000-280.000 төгрөгийн хооронд байдаг
4	Сэргээшийн төрлийн бодисыг биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэх үү?	Ерөнхий ойлголттой.	Мэднэ. Эмэгтэй хүнд бол хамгийн эхэнд хоолойны хөвч царгиатаад сөөнгөтөөд бүдүүрч эхэлнэ. Шанаа хэсгийн яс илүү өргөсөж эрэгтэйлэг болж эхэлнэ.
5	Сэргээшийн төрлийн бодисыг хэрэглээд таны биед сөрөг нөлөө үзүүлж байсан уу?	Хэрэглэж байгаагүй.	Миний хоолойны хөвчинд нөлөөлсөн.

6	Таны эргэн тойронд сэргээшийн төрлийн бодисыг хааяа болон тогтмол хэрэглэдэг хүн байдаг уу? Хаанаас, хэрхэн олж авдаг талаар мэдэх үү?	Зарим найзууд маань сонирхдог.	Бүгд л хэлдэг. Тэрнээс авсан эндээс авсан гээд л албан ёсны зардаг хүн, газар байдаггүй учраас бие биеэсээ дамнаж авдаг. Хэн юу ч зарж болно эрсдэл маш өндөр.
7	Сэргээшийн төрлийн бодис хэрэглэдэг шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?	Найзуудын нөлөө гэж бодож байна. Учир нь манай найзуудаас бэлтгэл хийгээд гоё биетэй болсон найзаа хараад бид ч бас хэрэглэх талаар бодож үзсэн.	Хэрэглэх шалтгаан гэвэл булчин массаа томруулах гэж эр даавар ихсэх тусам булчинд маш хурдан өөрчлөлт орно.
8	Та сэргээшийн төрлийн бодис бусдад худалдаж байсан уу? Тийм бол ямар давтамжтайгаар хэрхэн худалдаж байсан бэ?	Үгүй	Өөрөө хэрэглээд үр дүн сөрөг нөлөөг нь мэдэрчихсэн учраас шавь нартаа тосон тариа эр даавар ямар ч үед зөвлөж байгаагүй.
9	Сэргээшийн төрлийн бодисыг хувь хүн, эмийн сангаар чөлөөтэй худалдаалж байгаа шалтгааныг та юу гэж бодож байна вэ?	Амархан олддог болохоор.	Ер нь бол буруу эмийн сангуудаар бүр зарах ёсгүй. Эйч жи эйч өсөлтийн даавар гэж байгаа
10	Сэргээшийн төрлийн бодисыг хориглосон эрх зүйн зохицуулалт хангалттай гэж та бодож байна уу?	Сул л гэж бодож байна.	Маш хангалтгүй байгаа
11	Хууль тогтоомж хангалтгүй байгаагаас ямар асуудал үүсдэг вэ?	Өсвөр насны хүүхдүүд хэрэглэвэл бидний өсөлт хөгжилд муу нөлөөтэй байх.	Шударга өрсөлдөөн байхгүй мөн хүмүүс эрүүл мэндээрээ хохирч байгаа
12	Хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай эсэх талаар таны бодол?	Тиймээ	Шаардлагатай.

13	Ярилцлагатай холбоотойгоор нэмж хэлмээр байгаа зүйл байна уу?	Сургуулийн боловсрол хэрэгтэй.	Хэрвээ хэрэглэх шалтгаал гараад хэрэглэж эхэлсэн тохиолдол заавал эмчилгээ давхар явах хэрэгтэй шүү
----	---	--------------------------------	---

Ярилцлагын судалгааг нэгтгэн дүгнэвэл:

1. Сэргээшийн төрлийн бодисын талаарх ойлголт ба хэрэглээ

- **Мэдлэг:** Ярилцлагад оролцогчдын дийлэнх нь (90%) сэргээшийн төрлийн бодисын талаар тодорхой ойлголттой байна. Тэд сэргээшийн төрлийн бодисыг "булчин хурдан хөгжүүлэх", "биеийн гүйцэтгэлийг хиймлээр нэмэгдүүлэх" хэрэгсэл гэж тодорхойлсон.
- **Хэрэглээ:** Оролцогчдын 30% нь (Ярилцагч 4, 10 болон хэрэглэх төлөвлөгөөтэй Ярилцагч 6) сэргээш хэрэглэж үзсэн байна. Гол төлөв пропионат, мастерон зэрэг эр дааврын төрлийн тарианууд хэрэглэдэг байна.
- **Шалтгаан:** "Хурдан хугацаанд үр дүнд хүрэх", "гоё биетэй болох", "медаль авах дарамт" зэрэг нь хэрэглэх гол сэдэл болдог.

2. Сэргээшийн төрлийн бодисын олдоц ба түгээлтийн суваг

- **Олдоц:** Бүх оролцогчид сэргээшийн олдоц "маш элбэг", "олоход амархан" гэж хариулсан.
- **Түгээх суваг:**
 - Фитнесийн багш нар болон тамирчид (дам дамар зарах).
 - Сошиал медиа (Facebook зарууд).
 - Танил талын хүрээ болон онлайнаар гадаадаас захиалах.
- **Эрсдэл:** Албан ёсны борлуулалтын цэг байхгүй тул "оригнал, хулхи" нь мэдэгдэхгүй бодисуудыг бие биеэсээ дамжуулан авах нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3. Биед үзүүлэх сөрөг нөлөө

Хэрэглэж үзсэн оролцогчид дараах бодит сөрөг нөлөөнүүдийг дурджээ:

- **Сэтгэц:** Уур уцаартай болох, нойргүйдэл.
- **Гормон:** Эмэгтэй хүний хоолой бүдүүрэх, сөөнгөтөх, шанааны яс өргөсөх (эрэгтэйлэг болох).
- **Бусад:** Хаван үүсэх, донтох, дааврын алдагдалд орох.

4. Эрх зүйн зохицуулалтын үнэлгээ

• **Өнөөгийн байдал:** Оролцогчид Монгол улсын эрх зүйн зохицуулалтыг "маш сул", "хангалтгүй" гэж нэгэн дуугаар үнэлсэн.

• **Үр дагавар:** Хууль сул байгаагаас үүдэн:

- Шударга өрсөлдөөн алдагдах.
- Өсвөр үеийнхэн болон залуучуудын эрүүл мэнд хохирох.
- Хяналтгүй замбараагүй худалдаа цэцэглэх.

Сэргээшийн төрлийн бодис нь фитнес, спортын орчинд далд хэлбэрээр, маш чөлөөтэй худалдаалагдаж байна. Хэрэглэгчид үр дүнгээ бодож эрсдэлийг үл тоомсорлох хандлагатай байгаа бөгөөд үүнийг хязгаарлах хууль эрх зүйн хяналтын механизм дутагдаж байна. Энэхүү хүснэгтийг ашиглан 10 оролцогчийн хариултыг ерөнхийлөн харуулж байна(Хүснэгт 13).

Хүснэгт 13. Ярилцлагад оролцогчдын хариултын нэгдсэн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тийм / Мэднэ	Үгүй / Мэдэхгүй	Тайлбар
1	Сэргээшийн талаарх ойлголт	9	1	Оролцогчдын 90% нь ерөнхий ойлголттой.
2	Сэргээш хэрэглэж байсан туршлага	3	7	Оролцогчдын 30% нь хэрэглэж үзсэн.
3	Сөрөг нөлөөний талаарх мэдлэг	7	3	70% нь эрүүл мэндийн эрсдэлийг мэддэг.
4	Хэрэглэдэг танилтай эсэх	6	4	Оролцогчдын 60%-ийн орчинд хэрэглээ бий.
5	Худалдаалах хяналт сул байгаа эсэх	10	0	100% хяналт сул, олдоц элбэг гэж үзсэн.
6	Эрх зүйн зохицуулалтыг чангатгах шаардлага	10	0	100% хууль сайжруулах шаардлагатай гэсэн.

Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд сэргээшийн төрлийн бодисыг олж авах 3 гол суваг байна:

1.Фитнес орчин (Багш, тамирчид): Нийт оролцогчдын 70% нь энэ сувгийг нэрлэсэн.

2.Цахим орчин (Facebook, онлайн захууд): Оролцогчдын 50% нь интернэтээр олдох боломжтойг дурдсан.

3.Танил талын хүрээ: 40% нь дам дам дамжуулан авдаг гэжээ.

Энэ нь сэргээшийн худалдаа албан ёсны бус, хяналтгүй "далд эдийн засаг" хэлбэрээр явагдаж байгааг баталж байна. Энэхүү далд мөнгөн гүйлгээ нь мөнгө угаах гэмт хэргийн суурь болох эрсдэлтэй.

Хэрэглээний сэдэл ба шалтгаан

Ярилцлагаар илэрсэн хэрэглээний гол шалтгааныг эрэмбэлбэл:

- 40%** - Түргэн хугацаанд үр дүнд хүрэх (булчингийн масс нэмэх).
- 30%** - Бусдын нөлөө болон орчны дарамт (найз нөхөд, заалны багш).
- 20%** - Мэргэжлийн амжилт, медалийн дарамт.
- 10%** - Гоо зүйн хүсэл (турах, гадаад төрхөө өөрчлөх).

Эрх зүйн зохицуулалтын үнэлгээ

Судалгаанд оролцогчдын 100% нь Монгол улсын өнөөгийн хууль эрх зүйн орчныг "Хангалтгүй" буюу "Маш сул" гэж үнэлсэн байна. Оролцогчид дараах 3 асуудлыг нэн түрүүнд шийдвэрлэх ёстой гэж үзжээ:

- Хил гаалийн хяналтыг чангатгах (80%)
- Хувь хүмүүсийн гар дээрх худалдааг хориглох (90%)
- Сургуулийн болон нийгмийн боловсрол олгох (60%)

Судалгааны үр дүнд хийсэн нэгдсэн дүн шинжилгээ, практик ач холбогдол: Судалгаанд хамрагдсан иргэд, тамирчид болон мэргэжлийн багш нарын хариултаас харахад Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь "далд эдийн засаг"-ийн бие даасан хэлбэр болон төлөвшиж, түүнийг дагасан хяналтгүй мөнгөн гүйлгээ асар ихээр хийгдэж байна. Ярилцлагад оролцогчдын 100 хувь нь сэргээшийн олдоц "маш элбэг" бөгөөд "хяналтгүй" байгааг онцолсон нь санхүүгийн системийн аюулгүй байдалд дараах эрсдэлүүдийг үүсгэж байгааг нотолж байна.

Нэгдүгээрт, Ярилцлагаар илэрсэн сэргээшийн түгээлтийн гол сувгууд нь фэйсбүүк болон хувь хүмүүсийн гар дээрх худалдаа байгаа нь нийт мөнгөн гүйлгээний дийлэнх хэсэг нь банкны албан ёсны хяналт, татварын системээс гадуур "бэлэн мөнгө" болон "хувь хүний данс хоорондын гүйлгээ" хэлбэрээр хийгдэж байгааг харууллаа. Энэ нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх хамгийн таатай хөрс болж байгаа бөгөөд гэмт этгээдүүд хууль бус орлогоо нуух, түүнийгээ дахин хөрөнгө оруулалт болгон ашиглах боломжийг олгож байна.

Хоёрдугаарт, Судалгааны явцад ярилцлага өгөгчид өнөөгийн хууль эрх зүйн орчныг "маш сул" гэж үнэлсэн нь сэргээшийн худалдааг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болгон хуульчлаагүйтэй шууд холбоотой. Хэрэв сэргээшийн хууль бус эргэлтийг эрүүгийн гэмт хэрэгт албан ёсоор тооцож, түүнээс олсон ашгийг "хууль бус орлого" гэж тодорхойлохгүй бол мөнгө угаахтай тэмцэх үндэсний тогтолцоо энэ чиглэлд үр дүнтэй ажиллах боломжгүй юм.

Гуравдугаарт, Сэргээшийн төрлийн бодисын хэрэглээ нь зөвхөн тамирчдын эрүүл мэндийг хохироогоод зогсохгүй, спортын салбар дахь шударга өрсөлдөөний зарчмыг үгүйсгэж байна. Судалгаагаар өсвөр үеийнхэн болон залуучууд "хурдан хугацаанд үр дүнд хүрэх" зорилгоор, мэргэжлийн хяналтгүйгээр сэргээш хэрэглэж байгаа нь урт хугацаандаа хүн амын удмын санд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна эрүүл мэндийн салбарт ирээдүйд учруулах эдийн засгийн дарамтыг нэмэгдүүлж байна.

Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд эрх зүйн орчныг шинэчилж, сэргээшийн төрлийн

бодисыг асуудлыг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний бодлогын салшгүй нэг хэсэг болгон авч үзэх нь зүйтэй байна.

4.2 Гадаад улсын хууль тогтоомж дахь зохицуулалт: харьцуулсан шинжилгээ

Гадаад улс орнуудад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох хандлага нэмэгдсээр байгаа юм. ScienceDirect-д 2026 оны 1-р сард нийтлэгдсэн дэлхийн хамгийн шинэ судалгааны дүгнэлтээр дор хаяж 37 орон сэргээшийн төрлийн бодистой холбоотой үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох хуулийг баталсан байна (Efverström et al., 2026).

Мөн парламентын судалгааны мэдээлснээр Австри, Кипр, Дани, Франц, Грек, Унгар, Исланд, Люксембург, Норвеги, Португали, Румын, Сан-Марино, Серби, Испани, Швед зэрэг орон спортын хориглосон бодис, аргын наймааг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог тусгай хуультай болсон байна. Хятад, Бүгд Найрамдах Конго, Мексик, Шинэ Зеланд, Никарагуа, Тунис зэрэг орнууд ч хориглосон бодисын наймааг тус тусын эрүүгийн хуулиараа зохицуулдаг. (Pratt, 2013).

Судлаачийн зүгээс судалгааны асуудлын хүрээнд сайн туршлага болохуйц улс орнуудыг сонгон авч сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийн зохицуулалтыг судаллаа.

4.2.1 Америкийн нэгдсэн улс (АНУ)

Хамаарах хуулиуд:

Анаболик Стероидын Хяналтын Тухай Хууль 1990 (Anabolic Steroids Control Act of 1990)

Хяналттай Бодисын Тухай Хууль (Controlled Substances Act — 21 U.S.C. §§ 802, 812)

Роденков Антидопингийн Тухай Хууль 2020 (Rodchenkov Anti-Doping Act — 21 U.S.C. § 2401)

Зохицуулалт ба ял шийтгэл:

Анаболик стероидыг III ангиллын хяналттай бодис гэж ангилдаг. Хүчинтэй жоргүйгээр эзэмших, зарах, тараах нь хууль зөрчсөн үйлдэл болно (Хүснэгт 14).

Хүснэгт 14. АНУ-ын зохицуулалт ба ял шийтгэл

Зөрчлийн төрөл	Хуулийн зүйл	Ял шийтгэл
Анх удаагийн эзэмшил (жоргүйгээр)	21 U.S.C. § 844	1 жил хүртэл хорих, \$1,000-аас дээш торгууль
Дахин дахин зөрчсөн эзэмшил	21 U.S.C. § 844	Эрүүгийн гэмт хэрэг — заавал хорих
Зарах/тараах (анх удаа)	21 U.S.C. § 841	10 жил хүртэл хорих

Зөрчлийн төрөл	Хуулийн зүйл	Ял шийтгэл
Дахин дахин зарах/гараах	21 U.S.C. § 841	20-30 жил хорих, \$1,000,000 хүртэл торгууль
hGH хууль бусаар тараах	21 U.S.C. § 333(e)	5 жил хүртэл хорих; насанд хүрээгүйд — 10 жил
Олон улсын тэмцээнд сэргээшийн төрлийн бодисын схем зохион байгуулах	21 U.S.C. § 2401	5 жил хорих, \$250,000 торгууль
Байгууллага/клубуудад хамаарах	Rodchenkov Act	\$1,000,000 хүртэл торгууль

Эх сурвалж: (CriminalDefenseLawyer, 2026; LegalMatch, n.d.).

Кэйс: 2024 оны 2-р сард Хууль зүйн яамнаас мэдэгдсэнээр Eric Lira гэх хүн Роденков Антидопингийн Хуулиар анх удаа ял оноогдсон. Тухайн хүн 2020 оны зуны Олимпын өмнө байсан тамирчдад хориглосон бодис нийлүүлсний тулд ял шийтгэгдсэн. (CriminalDefenseLawyer, 2026).

4.2.2 Герман улс

Хамаарах хуулиуд:

- Спортын Антидопингийн Тухай Хууль 2015 (Anti-Doping-Gesetz, AntiDopG) — 2015 оны 12-р сарын 10-нд хүчин төгөлдөр болсон
- Эмийн Тухай Хууль (Arzneimittelgesetz, AMG) — 6а, 95 дүгээр зүйл

Зохицуулалт ба ял шийтгэл:

Герман улс 2015 онд Европт хамгийн иж бүрэн антидопингийн хуулийг баталсан бөгөөд энэ хууль нь зөвхөн тамирчдыг бус тамирчдыг дэмжигч ажилтнууд болон ердийн иргэдийг ч хамардаг (Хүснэгт 15). AntiDopG-ийн 2-р зүйлд сэргээшийн төрлийн бодисын наймааг өргөн утгаар тайлбарласан бөгөөд нэг удаагийн гүйлгээ ч наймаа гэж тооцно. (NADA Germany, n.d.; SE Legal, n.d.).

Хүснэгт 15. Герман улсын зохицуулалт ба ял шийтгэл

Зөрчлийн төрөл	Зүйл	Ял шийтгэл
Сэргээшийн төрлийн бодис үйлдвэрлэх, наймаалах, борлуулах, зах зээлд гаргах	§ 4(1) AntiDopG	3 жил хүртэл хорих эсвэл торгууль

Зөрчлийн төрөл	Зүйл	Ял шийтгэл
Бусдад сэргээшийн төрлийн бодис хийх, хэрэглүүлэх	§ 4(2) AntiDopG	3 жил хүртэл хорих
Насанд хүрээгүйд (18-с доош) сэргээшийн төрлийн бодис өгөх	§ 4(4) AntiDopG	Хүндрүүлэгч нөхцөл — 10 жил хүртэл
Олон хүний эрүүл мэндийг аюулд оруулах	§ 4(4) AntiDopG	10 жил хүртэл хорих
Амь насанд аюул учруулсан тохиолдолд	§ 4(4) AntiDopG	10 жил хүртэл хорих
Зохион байгуулалттай гэмт бүлэглэл	§ 4(4) AntiDopG	10 жил хүртэл хорих
Мэдэгдэхүйц санхүүгийн ашиг олох зорилгоор	§ 4(4) AntiDopG	10 жил хүртэл хорих

Эх сурвалж: (Act against doping in sport, 2015; LegalClarity, 2025).

Германы хуулийн дагуу эмийн сангийн бус сувгаар сэргээшийн төрлийн бодис нийлүүлж байгаа ямар ч хүн — тамирчин, дасгалжуулагч, биеийн тамирын клубийн эзэн, ердийн иргэн — эрүүгийн хариуцлага хүлээнэ (Ferner Alsdorf Law Firm, 2026).

Кейс: Герман улсад сэргээшийн төрлийн бодисын асуудлыг спортын сахилга болон эрүүгийн эрх зүйн хосолсон тогтолцоогоор зохицуулдаг. Спортын хүрээнд сэргээшийн төрлийн бодисын зөрчлийг NADA Germany болон World Anti-Doping Agency-ийн кодын дагуу шийдвэрлэдэг бол сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, нийлүүлэх үйл ажиллагааг шууд эрүүгийн хуулиар зохицуулдаг.

Энэ хүрээнд Anti-Doping Act Germany 2015 нь сэргээшийн төрлийн бодисын эргэлтийг хатуу хориглож, зөвхөн хэрэглээг бус, нийлүүлэлтийн бүх хэлбэрийг гэмт хэрэгт тооцдог онцлогтой хууль юм. Тус хуулиар сэргээшийн төрлийн бодисыг үйлдвэрлэх, худалдах, түгээх, нийлүүлэх, их хэмжээгээр хадгалах, мөн тамирчдад хэрэглэхэд нь зориуд дэмжлэг үзүүлэх зэрэг бүх үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлсон.

Хуулийн дагуу сэргээшийн бодисыг хууль бусаар худалдах эсвэл нийлүүлэх хувь хүн нь ноцтой нөхцөлд **5–10 жил хүртэлх хорих ял**, торгууль болон эд хөрөнгө хураах зэрэг шийтгэл хүлээх боломжтой. Бага хэмжээтэй, анх удаа үйлдсэн тохиолдолд торгууль эсвэл богино хугацааны хорих ял ногдуулж болох боловч зохион байгуулалттай сүлжээний шинжтэй бол илүү хатуу шийтгэл хэрэглэнэ.

Германы эрх зүйн тогтолцооны онцлог нь сэргээшийн төрлийн бодисыг зөвхөн спортын сахилгын зөрчил гэж үзэхгүй, харин нийтийн эрүүл мэнд болон эмийн хууль бус

эргэлтийн эсрэг гэмт хэрэг гэж давхар ангилдагт оршино. Иймээс сэргээшийн төрлийн бодисын нийлүүлэлтийн сүлжээнд оролцсон эмч, дасгалжуулагч, зуучлагч болон энгийн иргэн бүгд адил хариуцлага хүлээх боломжтой бөгөөд зөвхөн тамирчинд бус нийлүүлэлтийн талд илүү хатуу эрүүгийн хариуцлага ногдуулдаг.

Герман улс нь сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг таслан зогсоох чиглэлээр Европт хамгийн системтэй, эрүүгийн хариуцлага өндөртэй орнуудын нэгт тооцогддог (Anti-Doping Act, 2015; NADA Germany, n.d.; World Anti-Doping Agency, 2021).

Кейс: Герман улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь зөвхөн спортын сахилгын асуудал биш бөгөөд зохион байгуулалттай тохиолдолд шууд эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог. Энэ нь Anti-Doping Act Germany 2015 болон эмийн болон эрүүгийн эрх зүйн холбогдох зохицуулалтаар шийдвэрлэгддэг. Илэрсэн хамгийн том бодит хэрэг нь “Operation Aderlass” нэртэй цусны сэргээшийн төрлийн бодисын сүлжээ бөгөөд Германы эмч Марк Шмидт болон түүний хамтрагчид спортын тамирчдад хууль бусаар цус сэлбэх, цус хадгалах, дахин сэлбэх аргыг ашиглан гүйцэтгэлийг нэмэгдүүлэх үйлчилгээ үзүүлсэн хэрэг юм. Энэхүү ажиллагаанд оролцогчид нь спортын тамирчин биш, харин эмч, туслах ажилтан, зохион байгуулагч зэрэг **спортын бус мэргэжлийн этгээдүүд** байсан бөгөөд олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан сүлжээ хэлбэртэй байжээ.

Шүүхийн шийдвэрээр гол зохион байгуулагчид нь сэргээшийн төрлийн бодисын хууль бус хэрэглээ болон нийлүүлэлтийн сүлжээ байгуулсан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэгдэж, Anti-Doping Act Germany 2015-ийн дагуу **хэдэн жилийн хорих ял (ойролцоогоор 4–5 жил хүртэл)**, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах, мөн хууль бусаар олсон орлогыг хураах шийтгэл ногдуулсан байна. Энэ хэрэг нь Германы эрх зүйн тогтолцоонд сэргээшийн төрлийн бодисын асуудлыг зөвхөн спортын дүрмийн зөрчил бус, харин зохион байгуулалттай эрүүгийн гэмт хэрэг гэж үздэгийг харуулсан бөгөөд спортын бус этгээдүүд ч сэргээшийн төрлийн бодисын нийлүүлэлтэд оролцсон тохиолдолд бүрэн хэмжээний эрүүгийн хариуцлага хүлээдэг гэдгийг баталсан чухал жишээ болсон (Anti-Doping Act, 2015; NADA Germany, n.d.; Reuters, 2021; World Anti-Doping Agency, 2021)

4.2.3 Итали улс

Хамаарах хуулиуд:

'Спортын үйл ажиллагааны эрүүл мэндийн хамгааллын тухай болон допингийн эсрэг тэмцэлд дэмжлэг үзүүлэх тухай хууль' — Legge n. 376 del 2000

Зохицуулалт ба ял шийтгэл:

Итали улс 2000 онд дэлхийн хамгийн хатуу антидопингийн хуулийн нэгийг баталсан. Уг хуулийн 9-р зүйлд гурван тусдаа эрүүгийн зөрчлийн ангиллыг тогтоосон (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Итали улсын зохицуулалт ба ял шийтгэл

Зөрчлийн ангилал	Хамрах хүрээ	Ял шийтгэл
1-р зөрчил: Хориглосон бодис хэрэглэх	Тамирчин — тэмцлийн гүйцэтгэлийг дэмжих зорилгоор	3 сараас 3 жил хорих; €2,580-51,645 торгууль
2-р зөрчил: Хориглосон бодис хийж өгөх, хэрэглүүлэх	Эмч, дасгалжуулагч, дэмжигч ажилтан	2-6 жил хорих; €5,000-75,000 торгууль
3-р зөрчил: Хориглосон бодисоор хууль бус наймаа хийх	Ердийн иргэн ч хамаарна	2-6 жил хорих
Хүндрүүлэгч нөхцөл: насанд хүрээгүйд өгсөн бол	18-с доош хүүхдэд өгсөн	Ялыг нэмэгдүүлж хэрэглэнэ
Нэмэлт: спортын байгууллагаас хасах	Шүүгч хэрэглэж болно	Спортын байгууллагаас бүрмөсөн хасах

Эх сурвалж: (Legge n. 376, 2000; Lexology, n.d.; NPR, 2005).

Итали нь хориглосон жагсаалтын бодисоор хориглосон наймаа хийхийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог инновацтай 3-р зөрчлийн ангиллыг нэвтрүүлсэн анхдагч орнуудын нэг юм (Pratt, 2013).

Италид сэргээшийн төрлийн бодисын хэрэглээ болон эргэлтийг спортын сахилга болон эрүүгийн эрх зүйн хосолсон тогтолцоогоор зохицуулдаг. Спортын хүрээнд хяналт, шинжилгээ болон зөрчлийг NADO Italia болон World Anti-Doping Agency-ийн дүрмийн дагуу хэрэгжүүлдэг бол сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, нийлүүлэх асуудлыг үндсэндээ эрүүгийн хуульд хамааруулан шийдвэрлэдэг.

Энэ хүрээнд Italian Anti-Doping Law No. 376/2000 нь сэргээшийн төрлийн бодисыг зөвхөн спортын зөрчил бус, харин нийтийн эрүүл мэндэд аюул учруулах гэмт хэрэг гэж тодорхойлсон байдаг. Тус хуулиар сэргээшийн төрлийн бодисыг үйлдвэрлэх, худалдах, түгээх, нийлүүлэх, мөн тамирчдад хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлэх бүх төрлийн үйл ажиллагааг хатуу хориглосон.

Хуульд зааснаар сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар нийлүүлсэн эсвэл худалдаалсан хувь хүн нь эрүүгийн хариуцлага хүлээх бөгөөд ихэвчлэн 2–6 жилийн хорих ял, мөн торгууль, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх хасах, эд хөрөнгө хураах зэрэг нэмэлт шийтгэл ногдуулах боломжтой. Энэ нь сэргээшийн төрлийн нийлүүлэлтийн сүлжээг таслан зогсоох зорилготой хатуу зохицуулалт юм.

Италийн эрх зүйн онцлог нь сэргээшийн төрлийн бодисыг зөвхөн спортын сахилгын асуудал гэж үзэхгүй, харин эмийн хууль бус эргэлт болон нийтийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гэж давхар ангилж, энгийн иргэн, эмч, дасгалжуулагч, зуучлагч зэрэг бүх этгээдэд адил тэгш хариуцлага ногдуулдагт оршино. Иймээс сэргээшийн төрлийн бодисыг худалдах, нийлүүлэх үйл ажиллагаа нь спортын эрх хасах шийтгэлээр хязгаарлагдахгүйгээр шууд эрүүгийн шүүхийн хариуцлагад шилждэг (Italian Anti-Doping Law No. 376/2000; NADO Italia, n.d.; World Anti-Doping Agency, 2021).

Кейс: Италид сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг зөвхөн спортын сахилгын зөрчил биш, харин нийтийн эрүүл мэндэд аюултай **эрүүгийн гэмт хэрэг** гэж үздэг бөгөөд энэ нь Italian Anti-Doping Law No. 376/2000-оор зохицуулагддаг. Практикт илэрсэн нэг төрлийн бодит хэрэгт спортын бус этгээдүүд, тухайлбал эмч болон зуучлагчийн оролцоотой бүлэг хүмүүс тамирчдад анаболик стероид болон бусад performance-enhancing бодисыг хууль бусаар нийлүүлж, хэрэглээг нь “эмчилгээ” эсвэл “сэргээх арга” гэж далдалсан системтэй ажиллагаа явуулсан байдаг. Энэ үйл ажиллагаа нь спортын амжилтыг зохиомлоор нэмэгдүүлэх зорилготой байсан бөгөөд мөрдөн шалгалтын явцад эмнэлгийн баримт, нийлүүлэлтийн сүлжээ болон бодисын хөдөлгөөнөөр нотлогдсон.

Шүүхээс уг үйлдлийг сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар **үйлдвэрлэх, худалдах, нийлүүлэх** гэмт хэрэг гэж үзэж, Italian Anti-Doping Law No. 376/2000-ийн дагуу холбогдох этгээдүүдэд **2–6 жилийн хорих ял**, торгууль, мэргэжлийн эрх хасах, мөн хууль бусаар олсон орлогыг хураах шийтгэл ногдуулсан байна. Энэ хэрэг нь Италийн эрх зүйн тогтолцоонд сэргээшийн төрлийн бодисын асуудлыг зөвхөн спортын дүрмийн зөрчил бус, харин **эрүүгийн гэмт хэрэг ба нийтийн эрүүл мэндийн асуудал** гэж үздэгийг харуулсан бөгөөд спортын бус этгээд ч бүрэн хэмжээний эрүүгийн хариуцлага хүлээдэг гэдгийг баталсан чухал жишээ болсон (Italian Anti-Doping Law No. 376/2000; NADO Italia, n.d.; World Anti-Doping Agency, 2021)

4.2.4 Франц улс

Хамаарах хуулиуд:

- Спортын Тухай Хууль (Code du sport) — L. 232-1 болон бусад зүйлүүд
- Эрүүгийн Хуулийн ерөнхий заалтууд хориглосон бодисын наймаанд нэмэлтээр хамаарна

Зохицуулалт ба ял шийтгэл:

Франц улсад сэргээшийн төрлийн бодис эзэмших эсвэл зөөх нь 1 жил хүртэл хорих болон €3,750 торгууль оногдуулах эрүүгийн гэмт хэрэг юм (Хүснэгт 17). Харин сэргээшийн төрлийн бодисыг хэрэглэх зорилгоор арилжаа наймаа хийвэл хариуцлага нь мэдэгдэхүйц нэмэгддэг (Claims.co.uk, n.d.; Cyclist, n.d.).

Хүснэгт 17. Франц улсын зохицуулалт ба ял шийтгэл

Зөрчлийн төрөл	Ял шийтгэл
сэргээшийн төрлийн бодис эзэмших / зөөх (анх удаа)	1 жил хүртэл хорих; €3,750 торгооль
Хориглосон бодисын наймаа, тарааль	Илүү хүнд ял — дахин дахин зөрчсөн эсвэл байгууллагатай хийсэн бол хэдэн жил хорих
1998 оны Тур де Франс скандал — жишээ	Тухайн команд менежер (Woet) 10 сарын зэрэгцүүлсэн ял; шүүгч Roussel 1 жил зэрэгцүүлсэн ял авсан

Эх сурвалж: (Mazan, 2000).

4.2.5 Австрали улс

Хамаарах хуулиуд:

- Эмийн Бараа Бүтээгдэхүүний Тухай Хууль 1989 (Therapeutic Goods Act 1989 (Cth))
- Австралийн Гаалийн Хуулийн холбогдох заалтууд
- Холбооны болон мужийн залилангийн хуулиудын холбогдох заалтууд
- Австралийн Спортын Антидопингийн Хууль 2006 (ASADA Act 2006)

Зохицуулалт ба ял шийтгэл:

Австрали улс сэргээшийн төрлийн бодисыг гагцхүү спортын хуулиар бус харин Эмийн бараа, Гааль, Залилангийн хуулиудын нийлбэрээр зохицуулдаг онцлогтой. WADA-ийн хориглосон жагсаалтын ихэнх бодис нь Эмийн бараа бүтээгдэхүүний тухай хуулиар 'эмийн бараа'-д тооцогддог (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Австри улсын зохицуулалт ба ял шийтгэл

Зөрчлийн төрөл	Хуулийн зүйл	Ял шийтгэл
Зохих зөвшөөрөлгүйгээр эмийн бараа импортлох	Therapeutic Goods Act 1989	4 жил хүртэл хорих; \$680,000 хүртэл торгууль
Стероид болон эмийн бараа хууль бусаар тараах	Холбооны эрүүгийн хуулиуд	Хэдэн жил хорих
Залилах (сэргээшийн төрлийн бодис ашиглан ашиг олох)	Залилангийн хуулиуд (холбоо ба муж)	Нөхцөлөөс хамааран 5-10 жил хүртэл

Эх сурвалж: (The Sports Pharmacist, 2019).

4.2.6 Оросын Холбооны улс

Хамаарах хуулиуд:

- Оросын Эрүүгийн Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт (2016-2017)
- 'Эрүүл мэндийг хамгаалах тухай', 'Биеийн тамир, спортын тухай' холбогдох хуулиуд

Зохицуулалт ба ял шийтгэл:

2016 онд Оросын холбооны улс Эрүүгийн хуульдаа сэргээшийн төрлийн бодистой холбоотой заалт оруулах хуулийг Думаар баталсан. Уг хуулиар тамирчдад сэргээшийн төрлийн бодис хийж өгсөн эмч, дасгалжуулагч хариуцлага хүлээнэ (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Оросын холбооны улсын зохицуулалт ба ял шийтгэл

Зөрчлийн төрөл	Ял шийтгэл
Тамирчдад сэргээшийн төрлийн бодис хийх (эмч, дасгалжуулагч)	Эрүүгийн хариуцлага; 1-3 жил хорих, мэргэжлийн эрхийг 1-5 жил хасах
Сэргээшийн төрлийн бодис хэрэглэснээс тамирчин нас барсан тохиолдолд	Эмч/дасгалжуулагч 3 жил хүртэл хорих; 5 жил хүртэл мэргэжлийн эрхийг хасах
Тамирчин өөрөө эрүүгийн хариуцлага хүлээх эсэх	Уг хуулиар тамирчинд хариуцлага тооцогддоггүй

Эх сурвалж: (Gaffey, 2016).

4.2.7 Испани, Норвеги, Дани болон бусад Европын орнуудын эрүүгийн хариуцлага

Испани, Норвеги, Дани зэрэг олон Европын орнуудын хуулийн онцлог нь голдуу WADA-ийн хориглосон бодисын худалдаанд тусгайлсан эрүүгийн хариуцлага оногдуулдаг (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Европын орнуудын зохицуулалт ба ял шийтгэл

Улс орон	Хуулийн хүрээ	Ял шийтгэлийн хэмжээ
Испани	Спортын Хуулийн холбогдох заалт; эрүүгийн хуулийн тусгай норм	Хориглосон бодисын худалдаанд хорих ял
Норвеги	Тусгай спортын хуулиар хориглосон бодисын наймааг гэмт хэрэгт тооцно	Хориглосон бодис худалдаанд хорих ял
Дани	Тусгай спортын хуулиар хориглосон бодисын наймааг зохицуулна	Эрүүгийн хариуцлага тооцдог

Улс орон	Хуулийн хүрээ	Ял шийтгэлийн хэмжээ
Швед	Спортын тусгайлсан хуулиар наймааг зохицуулна	Эрүүгийн хариуцлага тооцдог
Грек	Тусгай хуулиар — худалдах гэмт хэрэгт тооцно	Эрүүгийн хариуцлага; их тунг тараах нь хүнд ял
Польш	Тусгай хуулиар — насанд хүрээгүйд хориглосон бодис хэрэглүүлэхийг гэмт хэрэгт тооцно	Эрүүгийн хариуцлага тооцдог
Португали	Тусгай хуулиар — худалдахыг гэмт хэрэгт тооцно	20 жил хүртэл (наймааны хэлбэрийн хүнд хэргүүд)

Эх сурвалж: (Pratt, 2013; Taylor & Anderson, 2025).

Судлаачийн зүгээс судалсан гадаад улсуудын хууль тогтоомжийг харьцуулж хүснэгтлэв (Хүснэгт 21)

Хүснэгт 21. Хууль тогтоомж эрүүгийн хариуцлагын харьцуулсан байдал

Орон	Үндсэн хууль	Иргэнд хамаарах эсэх	Хамгийн өндөр ял
АНУ	Controlled Substances Act; Rodchenkov Act	Тийм	30 жил хорих; \$1 сая торгууль
Герман	AntiDopG 2015	Тийм (бүх иргэн)	10 жил хорих
Итали	Legge 376/2000	Тийм (3-р зөрчил)	6 жил хорих, €75,000 торгууль
Франц	Code du sport	Тийм	Наймааны хэрэгт хэдэн жил хорих
Австри	StGB §147	Тийм	10 жил хорих (\$50,000-аас их хохиролд)
Австрали	Therapeutic Goods Act 1989	Тийм	4 жил хорих, \$680,000 торгууль

Орон	Үндсэн хууль	Иргэнд хамаарах эсэх	Хамгийн өндөр ял
Орос	Эрүүгийн хуулийн нэмэлт 2016	Эмч/дасгалжуулагчид	3 жил хорих, 5 жил мэргэжлийн эрх хасах
Испани, Норвеги, Польш гэх мэт 30+ орон	Тусгай спортын буюу эрүүгийн хуулиуд	Тийм (наймаа)	Орноос хамааран 3- 15 жил хорих

Эх сурвалж: (Efverström et al., 2026; INTERPOL, n.d.).

4.2.8 Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) болон Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

БНХАУ-д сэргээшийн төрлийн бодисын эсрэг үйл ажиллагааг 反兴奋剂条例 (цаашид “Сэргээшийн төрлийн бодисын эсрэг журам” гэх)-аар зохицуулдаг бөгөөд уг журам нь сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг хатуу хориглосон байдаг. Тус журмын 3 дугаар зүйлд “ямар ч байгууллага, хувь хүн сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, нийлүүлэхийг хориглоно” гэж заасан нь сэргээшийн төрлийн бодисын эргэлтэд оролцогч бүх этгээдэд хамаарах нийтлэг хоригийг тогтоож байна. Энэ заалт нь зөвхөн тамирчдад бус, энгийн иргэн, аж ахуйн нэгжид нэгэн адил үйлчилдэг онцлогтой.

Мөн 27 дугаар зүйлд сэргээшийн төрлийн бодисын зөрчилд хамаарах үйлдлүүдийг тодорхойлсон бөгөөд үүнд сэргээшийн төрлийн бодисыг үйлдвэрлэх, борлуулах, худалдах, түгээх, нийлүүлэх, тамирчдад дамжуулах, түүнчлэн хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хамруулсан байна. Ийнхүү хууль тогтоогч нь сэргээшийн төрлийн бодисын хэрэглээг зөвхөн хэрэглэгч талаас бус, нийлүүлэлтийн сүлжээний бүх шатанд хариуцлагажуулах зорилгыг баримталжээ.

Дээрх зөрчил гаргасан тохиолдолд 32 дугаар зүйлд зааснаар хууль бусаар олсон орлогыг хураах, торгууль ногдуулах, үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоох зэрэг захиргааны арга хэмжээ авдаг. Энэ нь сэргээшийн төрлийн бодисын хууль бус зах зээлийг таслан зогсоох эдийн засгийн болон зохион байгуулалтын хөшүүрэг болдог.

Харин зөрчил нь ноцтой шинжтэй буюу их хэмжээний борлуулалт хийсэн, зохион байгуулалттайгаар үйлдсэн, эсхүл тамирчдад санаатайгаар нийлүүлсэн тохиолдолд 33 дугаар зүйлд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл үүсдэг. Энэ тохиолдолд хэргийг Criminal Law of the People's Republic of China-д нийцүүлэн шийдвэрлэдэг бөгөөд хорих ял, торгууль, хөрөнгө хураах зэрэг шийтгэл ногдуулах боломжтой.

Иймээс БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт нь сэргээшийн төрлийн бодисыг худалдах, борлуулах үйл ажиллагааг дан ганц спортын сахилгын зөрчил гэж үзэхгүй,

харин тодорхой нөхцөлд эрүүгийн гэмт хэрэгт тооцохоор иж бүрэн зохицуулсан байна. Энэ нь сэргээшийн төрлийн бодисын эсрэг бодлогыг хатуу хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөнийг хамгаалах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн суурь механизм болж байна. (China Anti-Doping Agency, n.d.; National People's Congress, 1997; State Council of the People's Republic of China, 2004)

БНХАУ-д сэргээшийн төрлийн бодисын асуудлыг зөвхөн спортын тамирчинд хамааруулахгүй бөгөөд эмч, зуучлагч, иргэн зэрэг **спортын бус этгээд** сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтэд оролцсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Энэ нь **反兴奋剂条例** болон Criminal Law of the People's Republic of China-ийн хамтарсан зохицуулалтаар хэрэгждэг.

Практикт илэрсэн нэг төрлийн хэрэгт спортын бус этгээдүүд анаболик стероид болон өсөлтийн гормон зэрэг хориотой бодисыг хууль бусаар **импортлох, хадгалах, онлайн болон шууд худалдах** замаар бодибилдинг, фитнесийн хэрэглэгчдэд нийлүүлсэн байдаг. Эдгээр үйл ажиллагаа нь спортын тэмцээнтэй шууд холбоогүй боловч сэргээшийн төрлийн бодисын хууль бус зах зээл үүсгэсэн тул хууль сахиулах байгууллагад илэрч шалгагдсан.

Шүүхийн шийдвэрээр уг үйлдлийг сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт гэж үзэж, Criminal Law of the People's Republic of China-ийн дагуу эрүүгийн хариуцлага ногдуулсан бөгөөд холбогдох этгээдүүдэд хорих ял, торгууль, мөн хууль бусаар олсон орлогыг хураах арга хэмжээ авсан байна.

Энэ хэрэг нь Хятадын эрх зүйн тогтолцоонд сэргээшийн төрлийн бодисын эргэлтийг зөвхөн спортын сахилгын зөрчил бус, харин спортын бус этгээдийн хувьд ч **эрүүгийн гэмт хэрэг** гэж үздэгийг харуулсан бөгөөд нийлүүлэлтийн сүлжээг бүх түвшинд хариуцлагажуулах бодлогын илэрхийлэл болсон (China Anti-Doping Agency, n.d.; National People's Congress, 1997; State Council of the People's Republic of China, 2004).

БНСУ-ын сэргээшийн төрлийн бодисын эрх зүйн зохицуулалт

БНСУ-д сэргээшийн төрлийн бодисын асуудлыг спортын сахилга болон эрүүгийн эрх зүйн хосолсон тогтолцоогоор зохицуулдаг. Спортын хүрээнд сэргээшийн төрлийн бодисын хяналт, шинжилгээ, зөрчлийг Korea Anti-Doping Agency болон World Anti-Doping Agency-ийн дүрмийн дагуу хэрэгжүүлдэг бол сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг тусгай эм, мансууруулах бодисын хяналтын хуулиудаар зохицуулдаг.

Энэ хүрээнд Pharmaceutical Affairs Act (South Korea) нь эмийн бүтээгдэхүүнийг зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээхийг хатуу хориглодог бөгөөд анаболик стероид зэрэг сэргээшийн төрлийн бодисын шинжтэй бодисууд энэ зохицуулалтад хамаардаг. Мөн Narcotics Control Act (South Korea)-ийн дагуу зарим даврын болон хяналттай бодисыг хууль бусаар хадгалах, худалдах, нийлүүлэх нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдож, хатуу шийтгэл ногдуулдаг.

Иймээс БНСУ-д тамирчдын сэргээшийн төрлийн бодисын хэрэглээ нь спортын сахилгын шийтгэл (эрх хасах, тэмцээнээс хасах гэх мэт)-д хамаарах бол сэргээшийн төрлийн бодисыг хууль бусаар **үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх** зэрэг үйл ажиллагаа явуулсан спортын бус этгээдүүд нь эрүүгийн хариуцлага хүлээдэг. Энэ нь

ялангуяа стероидын онлайн худалдаа, фитнесийн зах зээлд чиглэсэн хууль бус нийлүүлэлтийн сүлжээнд хамаардаг.

БНСУ-ын эрх зүйн тогтолцоо нь ийнхүү сэргээшийн төрлийн бодисын асуудлыг хоёр түвшинд ангилдаг: нэг талаас спортын шударга байдлыг хамгаалах сахилгын тогтолцоо, нөгөө талаас нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой эрүүгийн хууль тогтоомж юм. Иймээс сэргээшийн төрлийн бодисын нийлүүлэлт, худалдаанд оролцсон аливаа этгээд нь спортын статусаас үл хамааран бүрэн хэмжээний хууль зүйн хариуцлага хүлээх боломжтой. (Korea Anti-Doping Agency, n.d.; Narcotics Control Act, 2023; Pharmaceutical Affairs Act, 2023; World Anti-Doping Agency, 2021)

Кейс: БНСУ-д анаболик стероид болон хүчтэй үйлчилгээтэй жороор олгодог эмүүдийг хууль бусаар худалдах, түгээх үйл ажиллагаа нь спортын сахилгын зөрчил төдийгүй эмийн болон мансууруулах бодисын хяналтын хуулиар шууд эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог. Энэ нь Pharmaceutical Affairs Act (South Korea) болон Narcotics Control Act (South Korea)-ийн дагуу шийдвэрлэгддэг. 2026 оны 3-р сарын 24-нд БНСУ-ын Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны Бусан дахь бүсийн газар (Ministry of Food and Drug Safety, Busan Regional Office) нийт **4.4 тэрбум воны үнэ бүхий хууль бус эмийн сүлжээг илрүүлсэн** бөгөөд нийт 6 хүнийг баривчилсан байна. Мөрдөн шалгалтаар 40 орчим насны А гэх этгээд (эмийн худалдаа эрхлэх зөвшөөрөлгүй) болон түүний хамтрагчид 2021 оны 8-р сараас 2025 оны 3-р сар хүртэл нийт **12,155 удаагийн хууль бус худалдаа** хийж, анаболик стероид болон этомидат (etomidate) зэрэг жороор олгодог эмийг фитнесийн дасгалжуулагч болон хэрэглэгчдэд тараасан нь тогтоогдсон. Ялангуяа этомидат эмийг их хэмжээгээр хууль бусаар нийлүүлсэн нь ноцтой эрсдэлтэй үйлдэл гэж үзэгдсэн.

Шүүх болон мөрдөн шалгалтын байгууллага уг үйлдлийг Pharmaceutical Affairs Act (South Korea) болон Narcotics Control Act (South Korea)-ийн дагуу эм, хяналттай бодисыг зөвшөөрөлгүйгээр худалдах, түгээх, зохион байгуулах гэмт хэрэг гэж үзсэн бөгөөд холбогдогч этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон.

Энэ хэрэг нь БНСУ-д сэргээшийн төрлийн бодисын шинжтэй бодисын хууль бус эргэлт нь зөвхөн спортын асуудал биш, харин эмийн зах зээл болон нийтийн эрүүл мэндэд шууд аюул учруулдаг **зохион байгуулалттай гэмт хэрэг** болохыг харуулсан. Мөн спортын бус этгээдүүд (бизнес эрхлэгч, зуучлагч, дасгалжуулагч) ч бүрэн хэмжээний эрүүгийн хариуцлага хүлээх боломжтойг баталсан чухал жишээ болсон (Business Chosun, 2026; Korea Anti-Doping Agency, n.d.; Narcotics Control Act, 2023; Pharmaceutical Affairs Act, 2023).

Судлаачийн зүгээс судалсан гадаад улсуудын хууль тогтоомжийг харьцуулж хүснэгтлэв (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Зарим улсын сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

Улс орон	Гол хууль тогтоомж	Сэргээшийн төрлийн бодисыг эрүүгийн гэмт хэрэгт тооцох эсэх	Мөнгө угаахтай холбогдох зохицуулалт	Онцлох механизм / Кейс
Герман	Anti-Doping Act (2015)	Тийм (Хорих ялтай)	Хууль бус ашгийг хураан авах, санхүүгийн мөрдөн шалгалт хийх	"Operation Aderlass" – Зохион байгуулалттай сүлжээг илрүүлсэн.
Итали	Law No. 376/2000	Тийм	Сэргээшийн төрлийн бодисын худалдааг зохион байгуулалттай гэмт хэрэгт тооцдог	Сэргээшийн төрлийн бодисын эргэлтийг "Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг" гэж үзэж хатуу ялладаг.
БНСУ	Pharmaceutical Affairs Act, Narcotics Control Act	Тийм	Банк санхүүгийн гүйлгээнд хяналт тавих, FIU-ийн оролцоо	4.4 тэрбум воны стероидын сүлжээг санхүүгийн мөрөөр илрүүлсэн.
БНХАУ	Criminal Law (Amendment XI), Anti-Doping Regulation	Тийм	Гэмт хэргийн замаар олсон орлогыг хураах ерөнхий зохицуулалт	Үйлдвэрлэл, онлайн борлуулалт болон хил гаалийн хяналт маш чанга.

Эх сурвалж: Судлаач боловсруулсан.

Сэргээшийн төрлийн бодисыг ердийн иргэн бусдад худалдах, сурталчлах зэрэг үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог орнуудын тоо дэлхий даяар улам нэмэгдсээр байна. 2026 оны байдлаар дор хаяж 37 орон сэргээшийн төрлийн бодистой холбоотой зохицуулалтыг эрүүгийн хуульдаа тусгасан байна. (*ScienceDirect. Mapping doping-related criminal legislation. January 2026*).

Олон улсын түвшинд сэргээшийн төрлийн бодисын эсрэг тэмцэл нь зөвхөн спортын шударга өрсөлдөөнийг хамгаалах асуудлаас хальж, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, тэр дундаа мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын нэг хэсэг болон өргөжсөнийг Хятад, Герман, Итали, БНСУ-ын жишээнээс харж болно. Эдгээр улсуудын эрх зүйн туршлагыг харьцуулан шинжилснээр дараах үндсэн дүгнэлтүүдэд хүрч байна.

Нэгдүгээрт, Судалгаанд хамрагдсан улсууд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг "Эмийн тухай хууль" эсвэл "Спортын тухай хууль"-ийн зөрчил гэж үзэхээс илүүтэйгээр **Эрүүгийн хуулиар** хатуу зохицуулах болсон байна. Тухайлбал, Итали улс 2000 оны 376 дугаар хуулиар, Герман улс 2015 оны "Anti-Doping Act"-аар сэргээш хэрэглэх, түгээх үйлдэлд хорих ял оногдуулж байгаа нь сэргээшийн төрлийн бодис болон болон түүнийг дагасан санхүүгийн ашиг хонжоо олох үйлдлийг нийгэмд аюултай гэмт хэрэг гэж үзэж буйн илрэл юм. Энэ нь Монгол Улсын хувьд сэргээшийн төрлийн бодисын асуудлыг зөвхөн спортын холбоодын ёс зүй, сахилгын асуудал гэж үзэх бус, эрүүгийн хариуцлагын тогтолцоотой нягт холбох зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Хоёрдугаарт, Олон улсын практикт сэргээшийн төрлийн бодисын хууль бус худалдаанаас олсон орлогыг мөнгө угаах гэмт хэргийн эх үүсвэр гэж үзэж байна. БНСУ-ын 4.4 тэрбум воны "Стероидын сүлжээ"-г илрүүлсэн кэйс болон Германы "Aderlass" ажиллагааны үр дүнгээс харахад сэргээшийн худалдаа нь асар их хэмжээний далд бэлэн мөнгийг үүсгэдэг. Энэхүү хууль бус ашгийг санхүүгийн системд оруулан "угаах" үйл явц нь FATF -ын анхаарлын төвд байдаг бөгөөд дээрх улсууд санхүүгийн тагнуулын нэгж (FIU) болон сэргээшийн төрлийн бодисын эсрэг агентлагуудаа мэдээлэл солилцох түвшинд хамтран ажиллуулж байгаа нь хамгийн үр дүнтэй механизм болж байна.

Гуравдугаарт, БНХАУ болон БНСУ-ын туршлагаас харахад сэргээшийн төрлийн бодисын эсрэг ажиллагааг зөвхөн тамирчдаар хязгаарлахгүй, түүнийг нийлүүлэгч эмч, дасгалжуулагч, эмийн сан болон онлайн платформуудыг хянах замаар гэмт хэргийн сүлжээг үндсээр нь таслахыг зорьдог байна.

Дөрөвдүгээрт, Эдгээр улсууд WADA-ийн Кодексыг дотоодын хууль тогтоомждоо (Эрүүгийн хууль, Эмийн тухай хууль, Мансууруулах бодисын хяналтын тухай хууль) маш нарийн уялдуулж өгсөн байдаг. Энэхүү уялдаа нь хуулийн цоорхойг арилгах, мөнгө угаах үйл явцыг илрүүлэхэд төрөл бүрийн хууль сахиулах байгууллагууд нэгдсэн нэг зорилгоор ажиллах боломжийг олгож байна.

Дээрх улсуудын туршлагаас үзэхэд Монгол Улс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг суурь гэмт хэрэгт тооцох, санхүүгийн гүйлгээнд хяналт тавих замаар сэргээшийн далд захуудыг хаах, эрүүгийн хариуцлагын механизмыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Гадаад орнуудын жишээ нь сэргээшийн төрлийн бодистой тэмцэх нь зөвхөн спортын салбарын ажил бус, үндэсний аюулгүй байдал, санхүүгийн системийн эрүүл байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтойг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү магистрын дипломын ажлын хүрээнд сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон түүнтэй холбоотой мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улсын туршлага, мөн шүүхийн практикт тулгуурлан харьцуулсан байдлаар судалж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх боломжтой санал, зөвлөмжийг боловсрууллаа. Судалгааны явцад онолын үндэслэл, эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтийн нөхцөл байдлыг цогцоор нь шинжилж, Монгол Улсад сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон мөнгө угаах гэмт хэргийн хоорондын уялдаа холбоог тодорхойлохыг зорьсон болно. Судалгааны үр дүнгээс гарсан үндсэн дүгнэлтүүдийг дараах байдлаар нэгтгэн тодорхойлж байна.

Сэргээшийн төрлийн бодис нь олон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодисоос тодорхой шалгуураар ялгагддаг бие даасан бодис болох нь тогтоогдлоо. ДДЭА-ын хориглосон жагсаалт болон НҮБ-ын конвенцуудын жагсаалтад багтсан зарим бодис давхцаж байгаа боловч анаболик стероид, өсөлтийн даавар зэрэг бодисууд нь зөвхөн сэргээшийн төрөлд хамаарч эрүүгийн эрх зүйн тусгайлсан хяналтаас гадуур үлдэж байна.

Дотоодын эрх зүйн тогтолцоонд сэргээшийн төрлийн бодисыг зөвхөн "спортын сэргээшийн төрлийн бодис" гэдэг явцуу өнцгөөс бус, харин "хүн амын эрүүл мэндэд хортой, хууль бус эргэлтэд ордог бодис" гэсэн өргөн хүрээнд харж, Эрүүгийн хуулиар зохицуулах шаардлагатай байгаа нь тулгамдаж буй гол асуудал юм.

Сэргээшийн төрлийн бодис нь зөвхөн мэргэжлийн спортын хүрээнд бус, жирийн иргэд, өсвөр үеийнхний дунд хяналтгүй худалдаалагдаж байгаа нь нийгмийн эрүүл мэндэд учрах бодис эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хууль бус үйлдлийг гэмт хэрэгт тооцож зохицуулсан боловч WADA-аас баталсан жагсаалтад багтсан сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлтийг гэмт хэрэгт тооцох бие даасан зохицуулалт байхгүй байна. Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд заасан заалт нь сэргээшийн төрлийн бодисын төрөл, онцлогийг бүрэн хамарч чадахгүй байгаагаас шалтгаалан энэ төрлийн хууль бус бизнес эрхлэгчдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул, үр нөлөөгүй байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг суурь гэмт хэрэг болсон мөнгө угаах гэмт хэргийн тоо жилээс жилд эрчимтэй нэмэгдэж байна. Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь “бага эрсдэл-өндөр ашиг” бүхий далд эдийн засгийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс олсон орлого нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох бодит эрсдэл бүрдсэн байна.

WADA-ийн хориглосон жагсаалтад багтсан сэргээшийн төрлийн бодис (анаболик стероид, дааврын бэлдмэлүүд)-ын хууль бус далд худалдаа нь Монгол Улсад зөвхөн спортын салбарын зөрчил биш, зохион байгуулалттай далд эдийн засгийн бие даасан урсгал болон тэлж, санхүүгийн системд бодит "Аюул занал" бий болгож байна. Чанарын судалгааны (ярилцлагын) үр дүнгээс үзэхэд, оролцогчид эдгээр бодисыг цахим орчин болон фитнес клубийн далд сүлжээгээр дамжуулан ямар ч хяналтгүйгээр авдаг болох нь

тогтоогдсон. Энэхүү далд худалдаанаас олж буй татваргүй, бүртгэлгүй "бохир орлого"-оо гэмт этгээдүүд банкны систем болон цахим хэтэвчээр дамжуулан чөлөөтэй шилжүүлж байгаа нь Мөнгө угаах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл)-ийг шууд үүсгэх суурь нөхцөл болж байна. Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэрийн цахим сан, Санхүүгийн мэдээллийн албаны дата баримтад дүн шинжилгээ хийхэд эрх зүйн орчин тодорхойгүй, Эрүүгийн хуульд суурь гэмт хэрэг гэж албан ёсоор заагаагүйн улмаас шүүхийн практикт мөнгө угаах гэмт хэргээр ял шийтгэл оногдуулахгүй байна.

Өнөөгийн дотоодын эрх зүйн тогтолцоо нь FATF-ийн "Эрсдэлийн суурьт хандлага"-ын шаардлагыг хангахгүй байна. Зөрчлийн тухай хуулийн 10.19 дүгээр зүйлийн зохицуулалт нь зөвхөн "эмч, дасгалжуулагч, тамирчин" гэсэн явцуу субъектэд хариуцлага тооцдог тул фитнес клубийн орчинд эсвэл онлайн платформоор сэргээшийг бизнес болгон борлуулж буй "энгийн иргэн", "зуучлагч"-д хүлээлгэх эрүүгийн болон зөрчлийн тусгайлсан хариуцлага байхгүй байна. Энэ нь криминологийн Боломжийн онолын үүднээс хяналт тавих "Харгалзагч байхгүй" (Absence of a capable guardian) нөхцөлийг бүрдүүлж, гэмт этгээдүүдэд бага эрсдэлээр өндөр ашиг олох эрх зүйн сул орон зайг олгож байна. FATF-ийн стандартаар мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт (Predicate offences) хууль бус наймаа, контрабанд, хуурамч бүтээгдэхүүний эргэлтийг багтаадаг. Манай улсад сэргээшийн хууль бус худалдаанаас олсон орлогыг спорт клубийн тоног төхөөрөмж худалдан авах, хууль ёсны спорт нэмэлт бүтээгдэхүүний дэлгүүрийн орлого мэтээр халхавчлан хууль ёсны эргэлтэд оруулж (угааж) байна. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд сэргээшийн хууль бус эргэлтийг "суурь гэмт хэрэг"-ийн жагсаалтад албан ёсоор тусгаагүй байгаа нь манай улсын санхүүгийн тогтолцоог олон улсын үнэлгээгээр эрсдэлтэй харагдуулах хор уршиг дагуулж байна.

Сэргээшийн төрлийн бодисын эсрэг тэмцэл нь зөвхөн спортын байгууллагын ажил биш бөгөөд Цагдаа, Гааль, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын газар болон Санхүүгийн мэдээллийн албаны хамтын ажиллагаанд тулгуурлах шаардлагатай байна. FATF-ийн зөвлөмжийн дагуу техник нийцлийг хангахын тулд сэргээшийн хууль бус эргэлтийг "мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг"-т албан ёсоор хамааруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Боломжийн онолын хүрээнд авч үзвэл сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт болон мөнгө угаах гэмт хэрэг нь нийгмийн хөгжил, дижитал шилжилтээс үүдэлтэй "боломж"-оос хамаарч байна. Онолын хүрээнд авч үзвэл уг гэмт хэргийн урьдчилан сэргийлэлтийг хувь хүн рүү биш, харин гэмт хэрэг үйлдэгдэх "боломжийг хаах" буюу Санхүүгийн мэдээллийн алба, цагдаа, гааль, эрүүл мэндийн байгууллагуудын салбар дундын хяналтын тогтолцоо буюу "Харгалзагч" (Capable guardian)-ийг сайжруулахад чиглүүлэх шаардлагатай байна.

Сэргээшийн төрлийн бодисыг ердийн иргэн бусдад худалдах, сурталчлах зэрэг үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог орнуудын тоо дэлхий даяар улам нэмэгдсээр байна. 2026 оны байдлаар дор хаяж 37 орон сэргээшийн төрлийн бодистой холбоотой зохицуулалтыг эрүүгийн хуульдаа тусгасан байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүн шинжилгээнд тулгуурлан Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход дараах саналыг дэвшүүлж байна:

1. Хуулийн зохицуулалтын санал

✓Эрүүгийн хуулийн тусгай ангид “Сэргээшийн төрлийн бодис, түүний түүхий эдийг хууль бусаар импортлох, худалдах, зуучлан түгээх” гэсэн бие даасан шинэ зүйл заалт нэмж, Эрүүгийн хуулийн 20.14 дэх ерөнхий зүйлчлэлээс салгаж, нийгмийн хор аюулд нь тохирсон ял шийтгэл оногдуулдаг болох;

✓Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтыг зөвхөн “тамирчин”, “эмч” гэх хязгаарлалтаас салгаж сэргээшийн төрлийн бодис зөвшөөрөлгүй худалдсан иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг нэмэгдүүлж, Эрүүгийн хуулийн хариуцлагаас зааглах;

✓Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг (Predicate offence) болох бүрэн шинжтэй тул FATF-ийн Зөвлөмж 3-т нийцүүлэн, Санхүүгийн мэдээллийн албаны сэжигтэй гүйлгээг таних, тайлагнах удирдамж, журам болон эрсдэлийн үнэлгээнд сэргээшийн төрлийн бодисын хууль бус далд эргэлтийг мөнгө угаах өндөр эрсдэлтэй салбарт албан ёсоор хамааруулж тооцох.

2. Бусад санал

✓FATF-ийн аргачлалыг хэрэгжүүлэх үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон Санхүүгийн мэдээллийн албаны хамтарсан "Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт, санхүүгийн урсгалыг хянах ажлын хэсэг"-ийг байгуулж эмийн сан, фитнес клуб, онлайн худалдааны цахим гүйлгээнд салбар дундын хяналт шалгалт хийж, мэдээлэл солилцоог шуурхай болгосноор Боломжийн онолын "Харгалзагч" (Carable guardian)-ийн үүргийг практикт хэрэгжүүлэх;

✓Залуучуудад сэргээшийн төрлийн бодисын хор уршгийг таниулах сургалт зохион байгуулж, жоргүй олгох боломжгүй сэргээшийн төрлийн эмийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй болгох.

3. Дэвшүүлсэн санал зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тулгарч болох саад, хүчин зүйлс болон тэдгээрийг даван туулах арга зам

Дээрх хууль эрх зүйн шинэчлэл болон практик зөвлөмжүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд дараах саад, хүчин зүйл тулгарч болох бөгөөд тэдгээрийг тус тусын арга замаар даван туулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

○**Хууль тогтоох үйл явцын хугацаа алдалт (Хүчин зүйл):** Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажил нь УИХ-ын хэлэлцүүлгийн шатнаас хамаарч урт хугацаа шаарддаг сул талтай.

○ *Даван туулах арга зам:* Монгол Улс мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тусгайлсан жагсаалтаар биш, Эрүүгийн хуулийн тусгай ангиар бүхэлд нь авч үздэг. Иймд хуулийн томоохон өөрчлөлтийг хүлээлгүйгээр, Санхүүгийн мэдээллийн албанаас гаргадаг удирдамж, журамд нэмэлт оруулж, "Сэргээшийн төрлийн бодисын хууль бус эргэлт"-ийг сэжигтэй гүйлгээг таних индикаторт яаралтай тусгах замаар санхүүгийн хяналтыг шууд эхлүүлэх боломжтой.

○**Салбар дундын хамтын ажиллагааны идэвхгүй байдал (Хүчин зүйл):** Дэвшүүлж буй "Ажлын хэсэг"-т багтах байгууллагууд (Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон Санхүүгийн мэдээллийн алба) өөрсдийн үндсэн чиг үүргийн ачаалал, мэдээллийн хаалттай байдлаас шалтгаалан мэдээлэл солилцоог шуурхай явуулахгүй байх, улмаар ажлын хэсгийн үйл ажиллагаа хэлбэр төдий болох эрсдэлтэй.

- *Даван туулах арга зам:* Засгийн газрын тогтоол эсвэл салбарын сайд нарын хамтарсан тушаалаар ажлын хэсгийн чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зааж, улирал тутам уулзаж үр дүнгээ тайлагнадаг "Байнгын бүтэц" болгон эрх зүйн хувьд баталгаажуулах шаардлагатай. Мөн олон улсын WADA, Нэгдсэн Үндэсний байгууллагын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC) зэрэг байгууллагуудын техникийн туслалцааг авч, холбогдох мэргэжилтнүүдийг хамтарсан сургалтад хамруулж чадавхжуулна.

○**Цахим орчин дахь хяналтын сул байдал (Хүчин зүйл):** Сэргээшийн төрлийн бодисын худалдаа нь онлайн сүлжээ, хаалттай сошиал бүлгүүд болон цахим шилжүүлгээр нууцлагдмал байдлаар халхавчлагдан явагддаг тул практикт Боломжийн онолын "Харгалзагч" (Sarable guardian)-ийн үүргийг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын мөрдөн шалгах ажиллагааны нарийн мэргэшил, техник хэрэгсэл дутагдах талтай.

- *Даван туулах арга зам:* Мөрдөн шалгах чиг үүрэг бүхий цагдаагийн алба болон арилжааны банкуудын комплаенсын (хяналтын) албыг тус ажлын хэсэгтэй шууд мэдээллийн сүлжээгээр холбох нь зүйтэй. Цахим орчинд зарагдаж буй сэргээшийн төрлийн бодистой холбоотой түгээмэл ашиглагддаг эмийн нэршил, дансны гүйлгээний утга, түлхүүр үгсийг санхүүгийн хяналтын системд алгоритм (шүүлтүүр) болгон суулгаснаар, хууль бус санхүүгийн урсгалыг автоматжуулсан системээр урьдчилан таньж, шуурхай илрүүлэх боломж бүрдэнэ.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх

- Биеийн тамир, спортын тухай хууль. (2024). <https://legalinfo.mn>
- Допингийн эсрэг үндэсний дүрэм. (2022). <https://legalinfo.mn>
- Дэлхийн допингийн эсрэг дүрэм (World Anti-Doping Code). (2021).
- Зөрчлийн тухай хууль. (2017). <https://legalinfo.mn>
- Зүмбэрэлхам, Д. (2002). Мөнгө угаах гэмт хэрэг ба түүний мөн чанар. *Гэмт явдалтай тэмцэх асуудал: Онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл*, №1.
- Ийгл Ньюс. (2026). *Допинг Тусгай сурвалжлага* [Видео]. Facebook. <https://www.facebook.com/share/v/1BjkwWv2sR/>
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. (2002). <https://legalinfo.mn>
- Монгол банк. (2018). *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны сургалтын гарын авлага*. Улаанбаатар.
- Монгол Улсын Үндсэн хууль. (1992). <https://legalinfo.mn>
- Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газар. (2024). *Гэмт хэргийн статистикийн тайлан (2019–2023)*.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. (2013). <https://legalinfo.mn>
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт (International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation). (2023).
- Нарангэрэл, С. (2021). *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь* (Анхны хэвлэл). Улаанбаатар.
- НҮБ. (1961). *Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц*.
- НҮБ. (1971). *Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц*.
- НҮБ. (1988). *Мансуурал болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймааны эсрэг конвенц (Венийн Конвенц)*.

Санхүүгийн мэдээллийн алба. (2021). *2020 оны жилийн тайлан*. Монголбанк.
<https://fiu.mongolbank.mn/mn/r/62>

Санхүүгийн мэдээллийн алба. (2022). *2021 оны жилийн тайлан*. Монголбанк.
<https://fiu.mongolbank.mn/mn/r/560>

Санхүүгийн мэдээллийн алба. (2023). *2022 оны жилийн тайлан*. Монголбанк.
<https://fiu.mongolbank.mn/mn/r/900>

Санхүүгийн мэдээллийн алба. (2024). *2023 оны жилийн тайлан*. Монголбанк.
<https://fiu.mongolbank.mn/mn/r/1320>

Санхүүгийн мэдээллийн алба. (2025). *2024 оны жилийн тайлан*. Монголбанк.
<https://fiu.mongolbank.mn/mn/r/2280>

Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц (International Convention against Doping in Sport). (2005).

Хоригласон жагсаалт 2026 (Prohibited List 2026). (2026).

Шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим сан. (2026). <https://shuukh.mn>

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль. (2024). <https://legalinfo.mn>

Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандарт (International Standard for Therapeutic Use Exemptions - ISTUE). (2016).

Эрүүгийн хууль. (2015). <https://legalinfo.mn>

Гадаад хэлээрх

Act against doping in sport (AntiDopG) of 10 December 2015. (2015). Federal Law Gazette I, p. 2210. https://www.gesetze-im-internet.de/englisch_antidopg/englisch_antidopg.html

Albano, G. D., Amico, F., Cocimano, G., Liberto, A., Maglietta, F., Montana, A., Ponticelli, V., Puglia, M., Romano, G., Volti, G. L., & Salerno, M. (2021). Adverse effects of anabolic-androgenic steroids: A literature review. *Healthcare*, 9(1), 97.
<https://doi.org/10.3390/healthcare9010097>

Banned Substances Control Group. (n.d.). *WADA prohibited list - Banned drugs and supplement risks*. <https://www.bscg.org/wada-prohibited-list-banned-drugs-and-supplement-risks>

Bird, S. R., Goebel, C., Burke, L. M., & Greaves, R. F. (2016). Doping in sport and exercise: Anabolic, ergogenic, health and clinical issues. *Annals of Clinical Biochemistry*, 53(2), 196–221. <https://doi.org/10.1177/0004563215609952>

- Brunton, L. L. (Ed.). (2018). *Goodman & Gilman's the pharmacological basis of therapeutics* (13th ed.). McGraw-Hill Education.
- Business Chosun. (2026, March 24). Korea busts ring selling 4.4 billion won in illegal anesthetics, steroids. *Business Chosun*. <https://biz.chosun.com>
- China Anti-Doping Agency. (n.d.). *Anti-doping regulations and enforcement guidelines*. <http://www.chinada.cn>
- Claims.co.uk. (n.d.). *Athlete doping: Criminal offence or not?* <https://www.claims.co.uk/knowledge-base/sports-law/athletes-doping-and-criminal-law>
- Clarke, R. V. (1983). Situational crime prevention: Its theoretical basis and practical scope. *Crime and Justice*, 4, 225–256.
- Cohen, L. E., & Felson, M. (1979). Social change and crime rate trends: A routine activity approach. *American Sociological Review*, 44(4), 588–608.
- CriminalDefenseLawyer. (2026). *Illegal steroids and human growth hormone (HGH)*. <https://www.criminaldefenselawyer.com/resources/illegal-steroids-and-human-growth-hormone-hgh.htm>
- Cyclist. (n.d.). *Should doping be criminalised?* <https://www.cyclist.co.uk/in-depth/should-doping-be-criminalised>
- Efverström, A., Bäckström, Å., & Hoff, D. (2026). Mapping doping-related criminal legislation together: An informed stakeholder consultation. *Performance Enhancement & Health*, 14(1), 100284. <https://doi.org/10.1016/j.peh.2026.100284>
- Euronews. (2025, July 26). *How does doping affect athletes' health in the long and short term?* <https://www.euronews.com/health/2025/07/26/how-does-doping-affect-athletes-health-in-the-long-and-short-term>
- Farrell, G., & Clarke, R. V. (2004). Maximum preventive benefits and the criminal career. *Security Journal*, 17(3), 69–85.
- Felson, M. (2002). *Crime and everyday life* (3rd ed.). Sage Publications.
- Ferner Alsdorf Law Firm. (2026, February). *Trenbolone and punishable doping in Germany*. <https://www.ferner-alsdorf.com/trenbolone-and-punishable-doping-in-germany/>
- Financial Action Task Force. (2023). *The FATF Recommendations*. FATF/OECD.
- Financial Action Task Force. (2024). *International standards on combating money laundering and the financing of terrorism & proliferation: The FATF recommendations*. FATF/OECD.

- Gaffey, C. (2016, November 3). Russia set to introduce criminal punishments for doping. *Newsweek*. <https://www.newsweek.com/russia-set-introduce-criminal-punishments-doping-516580>
- Heuberger, J. A., & Cohen, A. F. (2019). Review of WADA prohibited substances: Limited evidence for performance-enhancing effects. *British Journal of Clinical Pharmacology*, 85(3), 484–503. <https://doi.org/10.1111/bcp.13815>
- INTERPOL. (n.d.). *Anti-doping*. <https://www.interpol.int/en/Crimes/Corruption/Anti-doping>
- Italian Anti-Doping Law No. 376. (2000). *Disciplina della tutela sanitaria delle attività sportive e della lotta contro il doping* [Law on the health protection of sporting activities and the fight against doping]. December 14, 2000.
- Korea Anti-Doping Agency. (n.d.). *Korea anti-doping code*. <https://www.kada.or.kr>
- LegalClarity. (2025, August). *What are the laws on steroids in Germany?*. <https://legalclarity.org/what-are-the-laws-on-steroids-in-germany/>
- LegalMatch. (n.d.). *U.S. Anti-Doping Agency lawyers*. <https://www.legalmatch.com/law-library/article/us-anti-doping-agency.html>
- Levi, M., & Reuter, P. (2006). Money laundering. *Crime and Justice*, 34(1), 289–375. <https://doi.org/10.1086/501508>
- Lexology. (n.d.). *Sports law in Italy*. <https://www.lexology.com/library/detail.aspx?g=61f2cbb9-8c84-4c42-a0cf-6658f6c46c66>
- Mayo Clinic. (2023). *Anabolic steroid abuse*. <https://www.mayoclinic.org/>
- Mazan, J. (2000). *The use of criminal justice mechanisms to combat doping in sport*. ResearchGate. <https://www.researchgate.net/publication/27829168>
- NADA Germany. (n.d.). *Anti-doping law*. <https://www.nada.de/en/legal-matters/anti-doping-law>
- NADA Germany. (n.d.). *National Anti-Doping Code*. <https://www.nada.de>
- NADO Italia. (n.d.). *Italian anti-doping rules*. <https://www.nadoitalia.it>
- Narcotics Control Act. (2023). *Act on the Control of Narcotics, etc.* [Act No. 19556].
- National Institute on Drug Abuse. (2024). *Prescription stimulants DrugFacts*. National Institutes of Health.
- National People's Congress. (1997). *Criminal Law of the People's Republic of China*. <http://www.npc.gov.cn>

- NPR. (2005, December 9). *Italy's strict anti-doping laws clash with Olympic rules*. <https://www.npr.org/templates/story/story.php?storyId=5044688>
- Pharmaceutical Affairs Act. (2023). *Yak-sa-beop* [Act No. 19634].
- Pratt, A. (2013). *Where in the world is doping crime?* (Background Note). Parliament of Australia, Parliamentary Library. https://parlinfo.aph.gov.au/parlInfo/search/display/display.w3p;query=Id:%22library/p_rspub/2398222%22
- Preston, K. L., & Epstein, D. H. (2022). Therapeutic use and chronic abuse of CNS stimulants and anabolic drugs. *Current Topics in Behavioral Neurosciences*, 56, 1–32. https://doi.org/10.1007/7854_2022_370
- Reuter, P., & Truman, E. M. (2004). *Chasing dirty money: The fight against money laundering*. Peterson Institute for International Economics.
- Reuters. (2021, January 15). German doctor jailed for blood doping network (Operation Aderlass). *Reuters*. <https://www.reuters.com>
- SE Legal. (n.d.). *Doping defense lawyers in Germany*. <https://www.se-legal.de/services/criminal-defense-lawyer/doping-defense-lawyers>
- Sport Integrity Australia. (n.d.). *Health effects of doping*. <https://www.sportintegrity.gov.au/education/health-effects-of-doping>
- State Council of the People's Republic of China. (2004). *Anti-Doping Regulation*. <http://www.gov.cn>
- Sulzer, D., Sonders, M. S., Poulsen, N. W., & Galli, A. (2005). Mechanisms of neurotransmitter release by amphetamines: A review. *Progress in Neurobiology*, 75(6), 406–433. <https://doi.org/10.1016/j.pneurobio.2005.04.003>
- Taylor, J., & Anderson, K. (2025). Sanctions to sentences: A systematic analysis of two decades of discourse on doping criminalisation. *International Journal of Sport Policy and Politics*, 17(2), 100255. <https://doi.org/10.1080/19406940.2025.2552650>
- The Sports Pharmacist. (2019, April 22). *Should doping in sport be a criminal offence?*. <https://thesportspharmacist.com/2019/04/22/should-doping-in-sport-be-a-criminal-offence/>
- U.S. Anti-Doping Agency. (n.d.). *Effects of performance-enhancing drugs*. <https://www.usada.org/substances/effects-of-performance-enhancing-drugs/>
- Unger, B. (2007). *The scale and impacts of money laundering*. Edward Elgar Publishing.
- United Nations. (1971). *Convention on Psychotropic Substances*. United Nations Publishing.
- WNET. (n.d.). *Doping for gold: The dangers of doping*. PBS. <https://www.pbs.org/wnet/secrets/the-dangers-of-doping/56/>

- World Anti-Doping Agency. (2021). *World anti-doping code*. <https://www.wada-ama.org>
- World Anti-Doping Agency. (2023, September 22). *WADA Executive Committee decides to allege non-compliance of National Anti-Doping Organization of Mongolia*. WADA. <https://www.wada-ama.org/en/news/wada-executive-committee-decides-allege-non-compliance-national-anti-doping-organization-mongolia>
- World Anti-Doping Agency. (2023). *World Anti-Doping Code*. <https://www.wada-ama.org/>
- World Anti-Doping Agency. (2024). *The prohibited list*. <https://www.wada-ama.org/en/prohibited-list>
- World Anti-Doping Agency. (2025). *The 2025 prohibited list*. <https://www.wada-ama.org/en/prohibited-list>
- World Health Organization. (1994). *Lexicon of alcohol and drug terms*. World Health Organization.
- World Health Organization. (2021). *Guidelines on the international control of psychotropic substances*. World Health Organization.
- Zareie, A., Solati, K., Ghorbani, M., & Shirani, K. (2024). Long-term effects of doping with anabolic steroids during adolescence on physical and mental health. *Scientific Reports*, 14(1), 18836. <https://doi.org/10.1038/s41598-024-69865-9>

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Судалгааны ярилцлагын удирдамж



Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам: сэргээшийн төрлийн бодисын жишээн дээр	Судалгааны ярилцлагын удирдамж
Энэхүү удирдамж нь судлаачид зориулагдсан. Ярилцлагын явцад зорилтот бүлэгт тохирсон үг хэллэг хэрэглэх ба ярилцлагын дарааллыг судлаач өөрөө тодорхойлж болно.	
УДИРДАМЖИЙН БҮТЭЦ ХЭСЭГ 1: Танилцуулга (4 минут) ХЭСЭГ 2: Судалгааны сэдвийн ерөнхий мэдээлэл өгөх (3 минут) ХЭСЭГ 3: Асуулт асуух (20 минут) ХЭСЭГ 4: Чөлөөт асуулт хариулт (5 минут)	

ХЭСЭГ 1: Танилцуулга	4 минут
ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Монгол Улсад сэргээшийн төрлийн бодис мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болон үйлдэгдэж байгаа талаарх өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, сайжруулах арга замыг тодорхойлоход оршино. Судалгаанд оролцогчдод судалгааны зорилго, нууцлал, ярилцлагын журам, итгэлцлийг тайлбарлах.	

СУДЛААЧ ӨӨРИЙГӨӨ БОЛОН СУРГУУЛИА ТОВЧ ТАНИЛЦУУЛАХ

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДОД АНХААРУУЛАХ

Зөв буруу хариулт гэж үгүй

Бусдын санаа бодолд хүндэтгэлтэй хандах

Оролцогч хүсвэл хувь хүний нууцыг хадгална

Протокол хөтөлж буй болон дуу хураагуур ашиглахыг тайлбарлах

Хэсэг 2 Сэргээшийн төрлийн бодисын хэрэглээ болон худалдааны талаар өнөөгийн нөхцөл байдал	3 минут
ЗОРИЛГО: Судалгааныд оролцогчдод судалгааны сэдэв, зорилго, ач холбогдлыг товч ойлгомжтой танилцуулах, тэдэнд ярилцлагын талаар ойлголт өгч, орчныг бүрдүүлэх	

СУДАЛГААНЫ АГУУЛГЫГ ТАНИЛЦУУЛАХ

Судлаач судалгааныд оролцогчдод сэдвийн талаар ерөнхий ойлголт өгнө.

Хэсэг 3: Асуулт, хариулт	15 минут
ЗОРИЛГО: Тулгамдсан асуудлыг тодорхойлоход оршино.	

Та сэргээшийн төрлийн бодис гэж мэдэх үү? Ямар бодисууд хамаардаг вэ?

Та сэргээшийн төрлийн бодис хэрэглэж байсан уу? Хэрэглэж байсан бол ямар төрлийн бодисыг хэдэн удаа хэрэглэж байсан бэ?

Та сэргээшийн төрлийн бодисыг хаанаас олж авч байсан бэ? Сэргээшийн төрлийн бодисын олдоц элбэг байдаг уу? Хаана хаанаас олж авах боломжтой вэ?

Сэргээшийн төрлийн бодисыг биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдэх үү?

Сэргээшийн төрлийн бодисыг хэрэглээд таны биед сөрөг нөлөө үзүүлж байсан уу?

Таны эргэн тойронд сэргээшийн төрлийн бодисыг хааяа болон тогтмол хэрэглэдэг хүн байдаг уу? Хаанаас, хэрхэн олж авдаг талаар мэдэх үү?

Сэргээшийн төрлийн бодис хэрэглэдэг шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл юу байсан бэ?

Та сэргээшийн төрлийн бодис бусдад худалдаж байсан уу? Тийм бол ямар давтамжтайгаар хэрхэн худалдаж байсан бэ?

Сэргээшийн төрлийн бодисыг хувь хүн, эмийн сангаар чөлөөтэй худалдаалж байгаа шалтгааныг та юу гэж бодож байна вэ?

Сэргээшийн төрлийн бодисыг хориглосон эрх зүйн зохицуулалт хангалттай гэж та бодож байна уу?

Хууль тогтоомж хангалтгүй байгаагаас ямар асуудал үүсдэг вэ?

Хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай эсэх талаар таны бодол?

ХЭСЭГ 4: Чөлөөт асуулт хариулт	5 минут
ЗОРИЛГО: Тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох	

Ярилцлагын явцад нэмж асуух шаардлагатай гэж үзсэн асуултыг асуух

Асуултын агуулгад тусгагдаагүй, судалгаанд оролцогчоос нэмж хэлэхийг хүссэн санал

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЭХ